



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 – 2026)



Зармагийн хоолой – Зармангийн баянбүрд, Эдрэнгийн нуруу

Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум

2022 он

Батлав:

..... /Ж.Донойбямба/

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын дарга



ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(2023 – 2026)

Менежментийн төлөвлөгөө боловсруулсан:

Луужин Амьтан Судлалын Нийгэмлэг

Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулсан:

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын Газар

Хянасан:

Эрдэнэ сумын засаг дарга

Говь-Алтай аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн

Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь
төслийн ТХГН-ийн менежментийн зөвлөх



Э.Давааням

Я.Жаргалцэцэг

Б.Оюунгэрэл

2022 он

Батлав: /Ж.Донойбямба/
Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын дарга

ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(2023 – 2026)

Менежментийн төлөвлөгөө боловсруулсан:

Луужин Амьтан Судлалын Нийгэмлэг

Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулсан:

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын Газар

Хянасан:

Эрдэнэ сумын засаг дарга

Э.Давааням

Говь-Алтай аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн

Я.Жаргалцэцэг

Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь
төслийн ТХГН-ийн менежментийн зөвлөх

Б.Оюунгэрэл

2022 он

ГАРЧИГ

ГАРЧИГ	1
ТОВЧИЛСОН ҮГ	3
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХУРААНГУЙ.....	9
Оршил.....	9
Тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолт ба ангилал.....	9
Тусгай хамгаалалттай газар нутгийн засаглал.....	11
Монгол Улсын Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар	14
Хамрах хүрээ	14
ОНТХГ-ын эрх зүйн орчин	14
I БҮЛЭГ: УДИРТГАЛ	15
ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	15
Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум	15
Газарзүйн онцлог, байгалийн нөөц	15
Хөгжлийн төлөв	21
Менежментийн төлөвлөгөө боловсруулах үндэслэл.....	39
Менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүй.....	40
Менежментийн төлөвлөгөө боловсруулсан баг.....	41
II БҮЛЭГ: ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	43
Алсын хараа	43
Хамрах хүрээ	43
Хамгаалах үнэт зүйлс, сонгосон үндэслэл	44
Нөхцөл байдлын дүн шинжилгээ.....	45
Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн төлөв байдал	47
Зармангийн хоолой ОНТХГ-ын өнөөгийн төлөв байдлын үнэлгээ.....	55
.....	55
Үнэт зүйлсэд учирч буй аюул дарамтын үнэлгээ	55
Зармангийн хоолойн малчдын амьжиргаа, байгаль орчны хандлага.....	56
Малчдын нийгэм эдийн засгийн байдал	30

Байгалийн нөөц, доройтол, хамгааллын талаарх малчдын хандлага, ойлголт.....	56
Орон нутгийн тусгай хамгаалалтай газрын менежментийн зорилго, зорилт	63
III БҮЛЭГ. ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	70
Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө.....	70
Мониторингийн төлөвлөгөө.....	72
Дотоод хяналт.....	72
Үнэт зүйлийн мониторинг.....	72
IV БҮЛЭГ: МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ.....	77
ОНТХГ-ын хамгааллын менежментийг хэрэгжүүлэгч байгууллага, бүтэц, зохион байгуулалт.....	77
ОНТХГ-ын менежментийг хэрэгжүүлэх бусад талууд, эрх үүрэг, оролцоо	85
ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, тайлагнах	
ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөний санхүүжилт, тогтвортой байдал.....	89
АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ	94
ХАВСРАЛТ	
Хавсралт 1. Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын тогтоол	
Хавсралт 2. Ашигт малтмал, газрын тосны газрын албан бичиг	
Хавсралт 3. Зармангийн хоолой ОНТХГ-ын кадастрын бүртгэл	

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АИХ	Ардын Их Хурал
АЦБ	Ариун цэврийн байгууламж
БНГ	Байгалийн нөөц газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХ	Байгаль орчны хяналт
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
БХОУХ	Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГИДЦГ	Говийн Их дархан цаазат газар
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДЦГ	Дархан цаазат газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НИТАЖ	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал
ОБ	Орчны бүс
ОБЗ	Орчны бүсийн зөвлөл
ОБС	Орчны бүсийн сан
ОНХГ	Орон нутгийн хамгаалалттай газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХНУГ	Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар
УИХ	Улсын Их хурал
УТХГН	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗ	Хамгаалалтын захиргаа
ШУ	Шинжлэх ухаан
ЭЧХЗ	Экологийн чухал хүчин зүйл
МАВ	Man and Biosphere Programme
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, Threats

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

График 1. 2013-2022 оны агаарын дундаж температур ба жилийн дундаж хур тунадасны хэмжээ .	17
График 2. Эрдэнэ сумын хүн амын тоо, хэтийн өсөлт	20
График 3. Эрдэнэ сумын хүн ам	21
График 4. Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэл ба нэг хүнд ноогдох ДНБ, 2040 он хүртэлх хэтийн төсөөлөл	22
График 5. 2021 оны байдлаар Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэл, салбараар.....	22
График 6. 2040 оны байдлаар Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэл, салбараар	23
График 7.Эрдэнэ сумын хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө, үйлдвэрлэл, ажил эрхлэлт	24
График 8. Эрдэнэ сумын бэлчээрийн малын тоо толгой, төрлөөр, 2040 он хүртэлх хэтийн төсөөлөл	24
График 9.Эрдэнэ сумын нийт бэлчээрийн малын тоо толгой, 2040 он хүртэлх хэтийн төсөөлөл.....	25
График 10. Эрдэнэ сумын таван хошуу малын эзлэх хувь, 2040 он хүртэлх төсөөлөл	25
График 11. Эрдэнэ сумын бэлчээрийн боломжит ургацын хэмжээ.....	26
График 12. Эрдэнэ сумын 1990 оноос хойших бэлчээрийн даац хэтрэлт болон хэтийн төлөв	27
График 13. Эрдэнэ сумын аж үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө, үйлдвэрлэл, ажил эрхлэлт	28
График 14. Эрдэнэ сумын үйлчилгээний салбарын хөрөнгө, үйлдвэрлэл, ажил эрхлэлт.....	29
График 15. Аймгийн агаарын дундаж температурын хэтийн төлөв	30
График 16. Говь-Алтай аймгийн хур тунадасны хэмжээний хэтийн төлөв	30
График 17. Гэрлэлтийн байдал, %, N=46	31
График 18.Судалгаанд оролцогчдын тоо, насны ангиллаар, %, N=46	31
График 19. Боловсролын түвшнээр, %, N=46	32
График 20. Боловсролын түвшнээр хистограмм, насанд хүрсэн нийт өрхийн гишүүдээр, %, N=46... 32	32
График 21. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, %.....	33
График 22.Өрхийн амьдарч буй сууцны төрөл, %, N=46.....	33
График 23. Өрхийн цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=46	34
График 24. Өрхийн үндны усны гол эх үүсвэр, давхардсан тоогоор %, N=46.....	35
График 25. Дулаан хангамжийн эх үүсвэр, давхардсан тоогоор, %, N=46.....	35
График 26. Өрхийн нийгмийн амьжиргааны түвшин, %, /өөрийн субъектив үнэлгээгээр/	36
График 27. Өрхийн амьдралын түвшний өөрчлөлт, %	36
График 28. Өрхийн амьдралын өөрчлөлтийн шалтгаан, %.....	37
График 29.Өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр, /оноор/.....	37
График 30. Өрхийн жилийн дундаж зарлага, мөнгөн дүнгээр, /оноор/	38
График 31.Өрхийн орлого, зарлагын өөрчлөлт, мөнгөн дүнгээр, /оноор/	38
График 32. Сүүлийн хоёр жилийн хадгаламж болон зээл авсан байдал	39
График 33.Зармангийн хоолой ОНТХГ-т хамгаалах үнэт зүйлийг тодорхойлсон байдал.....	44
График 34. Зармангийн хоолой орчмын 2010 болон 2019 оны газрын бүрхэвчийн ангиллын эзлэх хувь	46
График 35. Хар сүүлт харсан давтамж, N=44	57
График 36. Янгир харсан давтамж, N=44.....	57
График 37. Ирвэс харсан давтамж, %, N=6	57
График 38. Чоно харсан давтамж, %, N=23	57
График 40. Байгаль орчны зөрчлийг хэн үйлдэж байна, %.....	59
График 41. Байгаль хамгааллын талаарх малчдын ойлголт, %	60

График 42. Байгаль хамгаалал, орчны бүсийн менежментийн тогтолцооны талаарх малчдын хандлага, %	61
График 43. Нөхөрлөлд хамрагдсан байдал болон үйл ажиллагааны идэвх	62

Хүснэгт 1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ангилал, зорилгыг БХОУХ-ны ангилалтай харьцуулсан нь (Эх сурвалж: У.Тунгалаг ба бусад, 2021, х.32)	10
Хүснэгт 2. Эрдэнэ сумын нийт хүн ам, төрөлт, нас баралт, цэвэр шилжилт хөдөлгөөн, хэтийн төсөөлөл.....	20
Хүснэгт 3. Эрдэнэ сумын бэлчээрийн малын тоо толгой, төрлөөр, 2030,2040 онуудын хэтийн төсөөлөл.....	25
Хүснэгт 4. 2021 оны ямааны эзлэх хувь хэмжээ, бүс нутгаар.....	26
Хүснэгт 5. Нийт гишүүдийн тоонд эмзэг бүлэгт хамаарах гишүүдийн тооны эзлэх хувь.....	32
Хүснэгт 6.Ундны цэвэр усны үүсвэрт хүрэх хугацаа, %, N=46.....	35
Хүснэгт 7. Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээ	55
Хүснэгт 8.Үнэт зүйлсэд учирч буй аюул дарамтын үнэлгээ.....	56
Хүснэгт 9. Зэрлэг амьтны тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=46.....	56
Хүснэгт 11. Сүүлийн 2 жилийн хугацаанд байгаль орчны зөрчилд гарсан өөрчлөлт, %, N=46.....	58
Хүснэгт 12. Байгаль орчны зөрчил голчлон гарч буй улирлууд, %.....	58
Хүснэгт 14. Үйл ажиллагааны төлөвлөгөө.....	72
Хүснэгт 15. Зармангийн хоолой ОНТХГ-ын үнэт зүйлсийн мониторингийн төлөвлөгөө	76
Хүснэгт 16. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийн төсөөлөл үйл ажиллагаа/жилээр	90

Зураг 1. ТХГН-ийн ангиллыг байгалийн онгон зэрлэг байдал, эвдрэлийн зэрэглэлээр үзүүлсэн нь (Эх сурвалж Dudley, 2008, х. 24)	11
Зураг 2. Монгол Улсын Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын байршил	14
Зураг 3. Зармангийн ургамалжилт болон хөрсний хэв шинж	16
Зураг 4. Эрдэнэ сумын Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар ба газар ашиглалт.....	19
Зураг 5. Эрдэнэ сумын хүн амын сектор.....	20
Зураг 6. Говийн их дархан цаазат газрын “А” орчны бүсэд хамрагдах сумдын ДНБ-ний сектор.....	21
Зураг 7. Аж үйлдвэрлэлийн салбарын сектор.....	27
Зураг 8.Зармангийн хоолой Орон нутгийн тусгай хамгаалалттай газар	43
Зураг 9. Зармангийн хоолой орчмын газрын бүрхэвчийн 2000 болон 2020 онуудын Лансат хиймэл дагуулын зураг.....	46
Зураг 10. Газрын бүрхэвчийн өөрчлөлт гарсан газрууд	47
Зураг 11. Зармангийн хоолой ОНТХГ-ын үнэт зүйлсийг хамгаалах үр дүнгийн хэлхээс	65
Зураг 12. Зорилт 1-ийн үйл ажиллагааны хэлхээс	66
Зураг 13. Зорилт 2-ийн үйл ажиллагааны хэлхээс	67
Зураг 14. Зорилт 3-ийн үйл ажиллагааны хэлхээс	68
Зураг 15. Зорилт4 -ийн үйл ажиллагааны хэлхээс	69
Зураг 16. Нөхөрлөлийн дотоод засаглал.....	78
Зураг 17. Дундын хуримтлалын бүлэг аргачлал	81
Зураг 18. Нөхөрлөлийн холбооны дотоод засаглалын бүтэц.....	83
Зураг 19. Менежментийг хэрэгжүүлэгч талууд.....	85

Зураг 20	86
Зураг 21.Хамтын ажиллагааны схем зураг	89

ТАЛАРХАЛ

Зармангийн хоолойн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөө” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх явцад холбогдох мэдээ мэдээллээр ханган, судалгаанд оролцож, үнэтэй санал, зөвлөмж өгч идэвхтэй хамтран ажилласан Говь-Алтай аймгийн БОАЖГ, ЦУОШГ, ХХААГ, Эрдэнэ сумын ИТХ, сумын ЗДТГ-ын хамт олон, Цагаан Уул, Сангийн далай, Өлзийт, Цэцэг нуур багийн малчид болон Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь (ENSURE) төслийн багт талархал илэрхийлье.

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮН

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ИТХ, ЗДТГ:

ИТХ-ын дарга Ж.Донойбямба

Засаг дарга Э.Давааням

Засаг даргын орлогч Ц.Жанчивдорж

ЗДТГ-ын дарга Т.Оргилмаа

Статистикийн мэргэжилтэн Р.Цэрэндулам

Цаг уурч Э.Сугар-Эрдэнэ

Газрын даамал Э.Мөнхтуул

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Р.Ичинхорлоо

Байгаль хамгаалагч П.Гансүх

Хөдөө аж ахуйн тасгийн дарга Д.Янсандулам

Жижиг дунд үйлдвэрлэл, бэлчээр хариуцсан мэргэжилтэн Г.Адиймаа

Татварын байцаагч М.Өнөржаргал

Цагаан-Уул багийн засаг дарга Ю.Мөнхсүлд

Сангийн далай багийн засаг дарга М.Тогтохмэнд

Өлзийт багийн засаг дарга Д.Бат-Эрдэнэ

Цэцэгнүүр багийн засаг дарга Д.Лувсан-Очир

ЕБС-ийн “Их говийн багачууд” эко-клубийн багш О.Оюумаа

Хувиараа хөдөлмөр эрхлэгч Б.Мягмарсүрэн

Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь (ENSURE) төсөл:

Менежер Б.Эрдэнэбилэг

Ногоон хөгжил, байгалийн нөөцийн менежментийн мэргэжилтэн Т.Энэрэл

ТХГН-ийн менежментийн зөвлөх Б.Оюунгэрэл

Говь-Алтай аймаг дахь орон нутгийн зохицуулагч Э.Цэцэгмаа

Говь-Алтай аймгийн Эрдэнэ суман дахь идэвхжүүлэгч С.Мягмарсүрэн

Худалдан авалт хариуцсан ажилтан С.Нарангарав

Санхүүч А.Цэцэгдарь

Судлаачид:

ШУТИС-ийн багш, доктор, профессор Б. Ууганбаяр

ШУА-ийн ГГЭХ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан Н. Болдбаатар

МУИС-ийн Байгалийн ухааны сургуулийн Биологийн тэнхимийн оюутан С.Халиун

МУИС-ийн Байгалийн ухааны сургуулийн Биологийн тэнхимийн оюутан оюутан Ж. Номундарь

ХУРААНГУЙ

Оршил

Дэлхийн гадаргын 29 хувь нь хуурай газар, 71 хувь нь усан бүрхүүлтэй бол, энэхүү хуурай гадаргын 15,4 хувь, усан гадаргын 19,0 хувь нь тусгай хамгаалалтад байдаг (UNEP-WCMC, 2021). Сүүлийн 40 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд тусгай хамгаалалттай нутгийн талбай Их Британийн нутаг дэвсгэрийн хэмжээнээс Өмнөд Америкийн нутаг дэвсгэртэй дүйцэхүйц хэмжээнд хүрч томорсон байна (Dudley, 2008). Дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн стандартыг тогтоодог нэр хүндтэй байгууллага болох Байгаль Хамгаалах Олон Улсын Холбоо (IUCN)-оос тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН)-ын удирдлагын асуудлаар олон баримт бичиг, гарын авлага боловсруулсныг Дэлхийн ТХГН-ийн Комисс (World Commission for Protected Areas) болон Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), түүний Биологийн Олон Янз Байдлын Конвенц (БОЯБК)-ийн Газар хүлээн зөвшөөрч баталсан. БХОУХ-ны эдгээр баримт бичигт тусгасан ТХГН-ийн менежментийн стандартыг дэлхий даяар хамгаалалттай газрын үйл ажиллагааг зохицуулах чиглэл болгон ашиглаж ирлээ. Дэлхийн энэ жишиг, стандартын дагуу Монгол Улсын Байгаль Орчин Аялал Жүүлчлал (БОАЖ)-ын сайдын 2021 оны 1-р сарын 22-ны өдрийн А/16 тоот тушаалаар “**Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй**”-г баталсан байдаг.

Луужин Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН) нь Архангай аймгийн “Булган сумын Хойд Могойн гол – Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгааллын менежментийн загварыг бий болгох” төслийг Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Төлөөлөгчийн газрын статустай байх үедээ 2018-2021 онд үр дүнтэй хэрэгжүүлсэн түршлагатай. Иймд энэхүү Зармангийн хоолойн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөө нь дээр дурдсан Байгаль орчин аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны баталсан арга зүйн дагуу ЛАСН-ийн орон нутагт ажилласан түршлага мэдлэгт тулгуурласан болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолт ба ангилал

БХОУХ-ны тодорхойлсноор **тусгай хамгаалалттай газар нутаг** гэдэг нь дараах шинж чанартай байх ёстой. “Байгалийг экосистемийн үр өгөөж, соёлын үнэ цэний хамт урт хугацаанд хуулиар болон бусад үр дүнтэй арга хэлбэрээр хамгаалах зорилготой, хүлээн зөвшөөрөгдсөн, тусгайлсан, удирдлага, зохион байгуулалт бүхий, хил хязгаар нь тодорхой газарзүйн орон зайг тусгай хамгаалалттай газар нутаг гэнэ” (Dudley, 2008). БХОУХ-оос тухайн газрын **менежментийн зорилго**ос хамааран ТХГН-ийг зургаан ангилалд хуваан үзэж тус бүрийн хамгааллын зорилго, онцлог ялгааг тогтоон баталсан байдаг. Үүнд:

I. Дархан цаазат газар:

Ia. Дархан цаазат байгалийн нөөц газар (*Strict Nature Reserve*)

Iб. Онгон зэрлэг газар (*Wilderness Area*)

II. Байгалийн цогцолборт газар (*National Park*)

III. Байгалийн дурсгалт газар (*Natural Monument*)

IV. Биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах газар (*Habitat/Species Management area*)

V. Хамгаалалттай ландшафт (*Protected Landscape*)


VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалттай газар (*Protected Area with Sustainable Use of Natural Resources*).

Манай улсад БХОУХ-оос тодорхойлсон эдгээр ангилалтай менежментийн зорилго, онцлох шинж чанар буюу шалгуур үзүүлэлтийн хувьд ойролцоо дөрвөн ангилал байдаг. Үүнд: БХОУХ-ны ангилал I нь дархан цаазат газартай, II нь байгалийн цогцолбор газартай, III нь дурсгалт газартай, IV нь байгалийн нөөц газартай дөхүү юм. Харин ОНТХГ нь **ангилал VI**-тай ойролцоо менежментийн зорилго, субъекттэй. Дараах хүснэгтээс эдгээр ижил төстэй болон ялгаатай байдлыг харж болно (Хүснэгт.1).

БХОУХ-ны ТХГН-ын ангилал, менежментийн зорилго	БХОУХ-оос тодорхойлсон онцлог шинж чанар, шалгуур үзүүлэлт (Dudley, 2008)	Монгол Улсын ТХГН-ын нийцэж буй ангилал, зорилго (ТХГН-ийн тухай хууль 1994 он)	Монгол Улсын ТХГН-ын эрх зүйн актад орсон холбогдох шалгуур	Нийцэж буй эсэх
<p>VI. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт бүхий хамгаалалт-тай газар</p> <p>Байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийг хамгаалах, улмаар зохистой ашиглалт, байгаль хамгааллыг зөв хослуулах зорилготой.</p>	<p>Онцлог нь байгалийн нөөцийг тогтвортой ашиглах замаар байгаль хамгаалах зорилготой. Тухайн газрын байгальтай холбоотой соёлын үнэ цэнийг хамгаалах зорилгыг багтаадаг тул хэмжээний хувьд харьцангуй том байх нь цөөнгүй.</p> <p>Үйлдвэрлэлийн түвшний ашиглалт их хэмжээгээр явуулдаггүй</p> <p>Аливаа ашиглалтыг хэсэгчлэн хориглохыг зөвлөмж болгодог. Тухайлбал, нийт газрын гуравны хоёрт аливаа эдийн засгийн үйл ажиллагааг хориглох гэх мэт. Ийм шийдвэрийг тухайн улс, орон нутаг тухайн ТХГН-ийн онцлогт тааруулан өөрсдөө шийдэхээр заасан.</p>	<p>5/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газар</p> <p>Тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилготой нутаг</p>	<p>1/ Байгалийн унаган төрхөө хадгалсан байдал</p> <p>2/ Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх шаардлага</p> <p>3/ Элбэг ан амьтан, ургамлын ангилалд багтах боловч тухайн аймаг, сумын хэмжээнд нөөц багатай, хязгаарлагдмал тархац бүхий амьтан, ургамлын байршил нутаг</p> <p>4/ Амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой нутаг</p> <p>(Байгаль орчны сайдын 2000 оны 07-р тушаал)</p>	<p>✓</p> <p>✓</p> <p>✓</p>

Хүснэгт 1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ангилал, зорилгыг БХОУХ-ны ангилалтай харьцуулсан нь (Эх сурвалж: У.Тунгалаг ба бусад, 2021, х.32)

БХОУХ-ны тодорхойлсноор аливаа ТХГН-ийн менежментийн зорилгодоо хүрч чадаж буй эсэхийг **онгон зэрлэг хөндөгдөөгүй байдал** (naturalness) болон **өөрчлөлт эвдрэлд өртсөн байдлын** (environmental modification) үзүүлэлтээр дүгнэдэг. Энэ хоёр шалгуураар ТХГН-ийн ангилал хэрхэн ялгардаг болохыг дараах зургаас харж болно.



Зураг 1. ТХГН-ийн ангиллыг байгалийн онгон зэрлэг байдал, эвдрэлийн зэрэглэлээр үзүүлсэн нь
(Эх сурвалж Dudley, 2008, х. 24)

Иймд ОНТХГ нь онгон зэрлэг байдлын хувьд Байгалийн нөөц газартай ижил түвшинд боловч эвдрэлийн хувьд бага байх учиртай ажээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн засаглал

Сайн засаглалгүйгээр тухайн газар нутгийн экологийн болон соёлын үнэ цэнийг урт хугацаанд хамгаалах ТХГН-ийн зорилгыг хэрэгжүүлэх боломжгүй. Эрх мэдлийн хүрээнд хүчин төгөлдөр шийдвэр гарч талууд үйл ажиллагаа явуулж буй газар бүрд засаглал хэрэгжиж байдаг. Иймд ямар зорилгоор, юуг, хэрхэн хийхийг, хэн шийдэж байгаа болон шийдвэрээ ямар хэлбэрээр гаргаж байгаа, хэнд эрх мэдэл, хүчин чадал, хариуцлага байна, хэнтэй хариуцлага тооцож байна гэдэг бол бүгд **засаглалын** асуудал юм. Харин **менежмент** бол тухайн зорилгод хүрэхийн тулд ямар үйл ажиллагааг ямар арга хэрэгсэл, хэлбэрээр гүйцэтгэж буй тухай асуудал болно. Иймд засаглалыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

“Иргэд болон бусад оролцогч талууд саналаа хэлж, шийдвэрүүд гарч, эрх мэдэл, хариуцлага хэрэгжих орчныг бүрдүүлдэг бүтэц тогтолцоо, тэдгээрт холбогдох үйл явц, тогтсон уламжлалын хоорондох харилцан үйлчлэлийг засаглал гэнэ” (Borrini-Feyerabend et al., 2013).

Үүнээс үүдэн ТХГН-ийн засаглалын **хоёр хэмжээс** байдаг бөгөөд эхнийх нь **засаглалын хэлбэр** юм. Засаглалын хэлбэр нь гол шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлага, үүрэг хэнд байгааг тодорхойлдог. БХОУХ-оос ТХГН-ийн засаглалын дараах дөрвөн хэлбэрийг тодорхойлсон. Үүнд:

- А. Төрийн байгууллагын засаглал
- Б. Хамтын засаглал
- В. Хувийн засаглал
- Г. Уугуул болон нутгийн иргэдийн засаглал

ТХГН-ийн засаглалын хоёр дах хэмжээс бол **засаглалын чанар** юм. Засаглалын чанар гэдэг нь тогтоосон зарчмуудаа шийдвэр гаргах үйл явцдаа аль хэр сайн мөрдөж чадаж байгаа эсэх, улмаар энэ нь менежментийн үр дүнд болон байгаль хамгааллын зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлдог. ТХГН-ийн засаглалыг “сайн” байлгах дараах зарчмуудыг БХОУХ мөн тодорхойлсон байдаг.

Сайн засаглалын зарчим

- **Олон ургалч ба хууль ёсны дагуу байх** (*legitimacy and voice*): хүнийг нас, хүйс, үндэс угсаа, амьдралын хэв маяг, соёлын болон бусад онцлогоор нь ялгаварлан гадуурхахгүйгээр үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх, ТХГН-ийн менежментийн зорилго, стратегийн асуудлаар хэлэлцэх, харилцан зөвшилцөх үйл явцад оролцох боломжоор хангах,
- **Нутгийнханд нь эрх мэдэл өгөх** (*subsidiarity*): тухайн байгалийн нөөцөд хамгийн ойр, дэргэд нь байгаа (хуулиар хүлээн зөвшөөрсөн болон уламжлалт) институцид эрх мэдэл, хариуцлагыг шилжүүлэх;
- **Шударга байх** (*fairness*): ТХГН-ийг байгуулах, менежмент хийхтэй холбоотой гарсан зардал, үр ашгийг ижил тэгш хуваах, зөрчил гарсан тохиолдолд шударга зарчмаар шүүх боломжоор хангах,
- **Хохироохгүй байх** (*do no harm*): ТХГН-ийг байгуулж менежмент явуулахдаа ядуурал, эмзэг байдлыг ихэсгэх зэрэг нийгмийн өртөг гарз бага гаргах,
- **Удирдан чиглүүлэх** (*direction*): ТХГН-ийн ирээдүйн урт хугацааны алсын хараа, хамгааллын зорилгыг тодорхойлж, түүштай хэрэгжүүлэх,
- **Сайн гүйцэтгэл** (*performance*): биологийн олон янз байдлыг үр дүнтэй хамгаалахын сацуу талуудын асуудлыг шийдвэрлэх, нөөцийг арвигч хямгачаар ашиглах,
- **Хариуцлага** (*accountability*): хариуцлагыг ойлгомжтой тодорхой хуваарилах, бүрэн тайлагнах, хариуцлагын асуудлаарх талуудын санал шүүмжлэлд зохистой хариу өгч ажиллах,
- **Ил тод байдал** (*transparency*): бүх талуудад мэдээллийг ил тод тэгш хүртээмжтэй байлгах,
- **Хүний эрх** (*human rights*): ТХГН-ийн засаглалыг хэрэгжүүлэхдээ хүний эрх ялангуяа, ирээдүй хойч үеийн эрхийг хүндэтгэж ажиллах.

Эдгээр хүний эрхэд-суурилсан зарчмууд бүрэн дүүрэн хэрэгжихийн хэрээр ТХГН-ийн сайн засаглал оршин тогтнож байна хэмээн үзнэ. Ийм төлөв байдалд хүрэхийн тулд юуны өмнө эдгээр зарчмууд тухайн улсын ТХГН-ийн асуудлыг зохицуулдаг хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичигт тусгай заалт болон орсон, тэдгээрийг засаглалын бүх түвшинд хэрэгжүүлдэг байх учиртай.

Засаглалд оролцогч талууд

Сайн засаглалын дээрх зарчмуудын “амин сүнсэнд” хамгаалж буй байгалийн нөөцтэй хамаатай хүний эрх оршиж байдаг. Иймд засаглалын үйл явцад оролцож байгаа талуудыг “**давуу эрхтэй тал**” (rightsholder) болон “**оролцогч тал**” (stakeholder) гэж ялган авч үздэг (Borrini-Feyerabend et al., 2013, x. 15).

Давуу эрхтэй тал гэдэг нь нийгмээс хүлээн зөвшөөрсөн, тухайн газар, ус, бусад байгалийн нөөцийн хууль ёсны эсхүл хэвшмэл эрхтэй этгээд бөгөөд голдуу тухайн асуудлыг шууд хамаардаг шат шатны төрийн байгууллагууд болон тухайн нутагт үеийн үед амьдарсан нутгийн иргэдэд хамаардаг. Харин **оролцогч тал** гэдэг нь хуулиар болон нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрсөн тийм эрх байхгүй ч тухайн нөөцийн асуудлаар шууд болон шууд бус ашиг сонирхолтой этгээд байдаг.

Менежментийн арга хэрэгсэл


Засаглалд оролцож буй олон талуудын ашиг сонирхлыг харгалзан үзэж, тэдгээрийн хоорондын зөрчлийг шийдвэрлэж ажиллах нь ТХГН-ийн менежментийн гол сорилт байдаг. Үүнийг амжилттай давахын тулд дэлхий дахинаа доор дурдсан менежментийн олон төрлийн арга хэрэгслийг хэрэглэдэг. Үүнд:

- **Олон улсын хууль, конвенц, стандарт**, ялангуяа тухайн улс нэгдэн орсон гэрээ конвенцууд;
- Тухайн **улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, стратегийн төлөвлөгөө** (улсын үндсэн хуулиас эхлээд ТХГН-нд хамаатай салбарын хууль журам, орон нутгийн чанартай дүрэм журам бүгд үүнд хамаарна),
- **ТХГН-ийн тухай эрх зүйн баримт бичгүүд, менежментийн төлөвлөгөө** (тухайлбал, эн тэргүүний зорилтуудыг тодорхойлсон, бүсчлэлийг тогтоосон, нөөц ашиглах болон нээх/хаах хугацааг заасан, ан агнах, мал бэлчээх гэх мэт аливаа үйл ажиллагааны хугацаа эсхүл техник технологи ашиглахыг зөвшөөрсөн/хориглосон зэрэг зохицуулалт хийсэн),
- Тухайн орон нутагт **сахиж мөрддөг уламжлалт ёс жаяг, горим** (нутгийн институцийн зохицуулдаг нөөцийг ашиглах, хязгаарлах ёс заншил),
- **Мэргэжлийн зөвлөл, экспертүүд, техникийн хорооны санал зөвлөмж** (хамгийн үр нөлөөтэй, найдвартай, боломжийн, зардал багатай үйл ажиллагааны чиглэл өгөх),
- Нийгмийн **урамшууллын болон шийтгэлийн систем** (нийгмээрээ хүлээн зөвшөөрөх, талархах, шагнах, зохисгүй буруу үйлдэл хийгсдийг зэвүүцэх, жигших),
- **Мөнгөн урамшуулал ба шийтгэл** (ажлын хөлс, менежментийн төлбөр, байгаль хамгаалсны төлөө татвараас чөлөөлөх, байгальд хохирол учруулсан, доройтуулсны татвар, төлбөр),
- **Санхүүгийн хөрөнгө оруулалт** (төсөл хөтөлбөр, дэд бүтэц),
- **Хүний нөөцийн болон цаг хугацааны хөрөнгө оруулалт** (нөхөн сэргээлтийн болон эргүүлийн ажилд сайн дураараа оролцох),
- Уулзалт хийх, хэлэлцүүлэг хийх, санал солилцоход зориулан байр, тээвэр, утсан харилцаа, компьютер зэрэг **тоног төхөөрөмж, мэдээлэл, орчноор хангах**,
- **Боловсролын хөтөлбөрөөр хангах** (ерөнхий болон тусгай боловсрол, магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн курс),
- ТХГН-ийн хэрэгцээнд нийцүүлэн **цалин, материаллаг болон захиргааны дэмжлэг** үзүүлэх,
- ТХГН-ийн менежментэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүний шийдлийг гаргахад чиглэсэн **судалгааны болон сургалтын хөтөлбөр** хэрэгжүүлэх,
- **Мониторинг, үнэлгээний ажлыг дэмжих** сайжруулах (засаглалын асуудлууд),
- Хуулийн **зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих**, биет саад хашаагаар хангах.

Монгол Улсын Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар

Хамрах хүрээ

БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн сангийн 2021 оны мэдээгээр аймаг нийслэл, сум дүүргийн нийт **2745 ОНТХГ** байгаа нь **68,8 сая га** талбайг хамарч байна. Үүнээс 3/2 нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, улсын болон орон нутгийн ТХГ-ын хилийн заагтай хэсэгчилсэн болон бүрэн давхцалтай зэрэг кадастрын зөрчилтэй, харин 33 хувь буюу 22,6 сая га талбай бүхий 1366 ОНТХГ аливаа зөрчилгүй байна (БОАЖЯ, 2021а). Монгол Улсад ОНТХ-нд авсан газрын байршлыг дараах зургаас дээр харж болно (Зураг.2).



ОНТХГ-ын эрх зүйн орчин

Зураг 2. Монгол Улсын Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын байршил

Улсын нийт нутаг дэвсгэрийн 14 хувийг эзэлж буй эдгээр ОНТХГ-ыг байгуулах, менежментийн эрх зүйн үндэслэл нь Үндсэн хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч” гэсэн заалт, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт, уг хуулийн 28 дугаар зүйлийн 1.3, 29 дүгээр зүйлийн 1.2-т тус тус тусгасан аймаг, нийслэл, сум, дүүргийн тодорхой газар нутгийг ОНТХ-нд авах талаар санал боловсруулж, зохих байгууллагад уламжлах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоож хэрэгжүүлэхээр хуульчилсанд оршино. Мөн “Газрын тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан улсын газрын нэгдмэл сангийн ангиллаар “Тусгай хэрэгцээний газар”-нд ОНТХГ-ыг бүртгэдэг.

БОАЖ-ын сайдын 2000 оны 07 тоот тушаалаар баталсан “Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай” журмыг одоо мөрдөж байна. Тус журамд газар нутгийг ОНТХ-нд авах зорилго, шалгуур, түүний ангилал”, хамгаалалтад авах тухай санал гаргах, шийдвэрлэх болон ОНТХГ-ын санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулсан байдаг. Түүнчлэн 1998 оны “ТХГН-ийн үндэсний хөтөлбөр”-ийн 4.5.1-т заасны дагуу ОНТХГ нь менежментийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг.

I БҮЛЭГ: УДИРТГАЛ

ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум

Газарзүйн онцлог, байгалийн нөөц

Газарзүйн байршил, хил хязгаар: Эрдэнэ сумын нутаг Монгол Алтайн нурууны өмнөд үзүүр, Говь-Алтайн нурууны эхлэл заагт орших Эмээлцэг, Баянцагаан, Жавхлант, Гичгэний нуруунаас баруун тийш эдгээр нуруудтай зэрэгцэн, баруун хойноос зүүн урагш сунан тогтсон Эдрэн, Суман хад, Цагаан байшинт, Булган хошууны нуруу, Хатан суудлын хяр, Нарансэвстэйн нуруу хэмээх алдарт зургаан их нурууг дамнан оршдог. Алтайн өвөр говийн бэсрэг уулсын жинхэнэ төрхийг агуулсан эдгээр нурууд нь өөр өөрийн онцлог бүхий экосистемийг бүрдүүлдэг бөгөөд өндрөө булаалдсан ноён шовх оргилуудтай.

Эмээлцгийн хяр, Хүрэмтийн нурууны заагт орших Баянзүрх уул далай түвшнээс дээш 3,759м, Гичгэний нурууны оргил Өлийн овоот уул 3,359м, Эдрэнгийн нурууны оргил Юмт уул 2,076м, Суман хадны нурууны оргил 2054м, Цагаан байшинтын нурууны оргил 1,702м, Булган уул 1,550м, Нарансэвстэйн уул 1,376м гэж тэмдэглэгдсэн нь Алтай нурууны хяраас баруун тийш улсын хил рүү ойртох тусам намсан намссаар их цөлтэй залгадаг ажээ.

Дээр дурдсан нуруудын завсар хоолойд Хараат хайрхан 3,008 метр, Эрдэнэ хайрхан, Чандмань хайрхан 2,830 метр, Цагаан-Уул 2,645 метр, Суман гүн уул 2,573 метр, Цахиурт 1,788 метр, Буурын хяр, 1,422 метр, Зангат 1,262 метр, Чингис уул 2,210 метр, Шар хулст уул 1,754 метр зэрэг зүмбэрлэсэн тогтолцоотой хадат уулс дуниартан мяралзах зэргэлээн дунд сүүмэлзэн оршино. Эдгээр нь Монгол Улсын газрын зураг дээр нэр бүхий өндөрлөгөөрөө тэмдэглэгдсэн байх төдийгүй Говийн Их Дархан Цаазат Газрын тод томруун хэсэг болдог.


Тус сумын нутаг дэвсгэрийн хил заагийг 1962 онд шинэчлэн тогтоосноор Умын даваанаас Индэртийн хяраар Говь-Алтайн Бигэр сумтай, Индэртийн хяраас Эмээлцгийн хяраар дамжин Мөсөн түрүүний гол, Хүнхэрийн бууц, Алагийн гол, Ханхайрхан, Өлийн овоо, Зүлэгтийн эх хүртэл Говь-Алтай аймгийн Чандмань сумтай, Зүлэгтийн эхнээс Их Өлзийтийн урд хамраар дамжин Хадатын булаг, Ханангийн худаг, Чухайн худаг, Улаан чулууны овоо, Зүлэгтийн худаг, Бага толийн булаг, Сайрын уул, Долооны худаг, Хярын гүний худаг, Шар хулсны булаг, Балин цохио уул, Энгэрийн ус булаг, цааш ГИДЦГ-ын А хэсгийн 1073 тоот өндөрлөгөөр Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумтай, энэхүү тоот өндөрлөгөөс Наран сэвстэйн нурууны цаад хоолойгоор дамжин 180 дугаар тэмдэгт хүртэл Монгол Улсын хилийн дагуу БНХАУ-ын Гансу мужтай, мөн 180 дугаар тэмдэгтээс Арслан хайрхан, Бөөрийн хар, Дунд хүрэн цавийн уул, Шатан Гэгээтийн голын уулзвараас Умын даваа хүртэл Говь-Алтай аймгийн Цогт сумтай хил залган оршдог.

Нийт 25,265 км² ам дөрвөлжин километр (2,543,666 га) хэмжээтэй талбайг хамарсан асар өргөн нутагтай Эрдэнэ сум нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ Говь-Алтай аймагтаа нэгдүгээрт, улсын хэмжээд хоёрдугаарт эрэмбэлэгддэг. Үүнээс Зармангийн хоолой ОНТХГ 118472,72 га талбайг эзлэн орших ба 34,879 га талбай Өлзийт багт, 34,677 га талбай Цагаан- Уул багт, 43,449 га талбай Сангийн далай багт, 6,415 га талбай Цэцэг нуур багийн нутагт хамаарна.

Газрын гадарга хөрс: Эрдэнэ сумын газар нутаг газарзүйн мужлалын хувьд Алтайн уулархаг их мужийн аль алины төлөөллийг өөртөө агуулсан байдаг. Чухамдаа Говь-Алтай нурууны шувтрах үзүүрийн 2,500-3,700 метрт өргөгдсөн өндөр уулс, тэдгээрийн ар өврөөс хотос, тал хөндий, цаашлаад говь цөлийн хоолой үргэлжлэх тул газрын гадаргын хэв шинж олон янз болдог. Говь-Алтайн уулс нь дөрөвдөгч галавын үед Монгол орны нутгаас далай бүр мөсөн түрэгдэн арилах үед Альпийн атираатлын явцад үүссэн гэж үздэг. Дунд төрмөлийн эриний үед хотос хонхор, уулс ялгаран тогтоход сумын нутгийн гадаргын одоогийн төлөв байдал бий болсон гэсэн дүгнэлтийг тэр үеийн усанд амьдарч байсан дунгийн төрлийн амьтад болон мэлхий, үлэг гүрвэлийн яс, өндөг зэрэг ул мөр Эдрэнгийн нурууны ар өвөр хоолойгоос олдсоныг үндэслэн таамагласан байдаг. Гэсэн ч тус сумын нутгийг палентологийн хувьд нарийвчлан судалсан нь үгүй тул баттай нотолгоо одоогоор дутмаг байна.

Тус сум газар зүйн мужлалаар говийн мужийн бүсшилийн Алтай хийгээд говийн тойргуудад багтана. Сумын нутаг дахь Эмээлцэг, Гичгэний хяр, Баянцагаан, Хараат, Эрдэнэ уул, Чандмань хайрхан зэрэг уулсаар өндөр уулын хуурай хээрийн бүдүүн ялзмагт, уулын нугын, уулын нугат хээрийн, уулын хүрэн, уулын цайвар хүрэн, уулын цөлөрхөг хээрийн бор хэв шинжийн хөрсүүд хослон тогтжээ. Харин уулс хоорондын хонхор, хотгор хөндий болон Алтайн өвөр говь, Номингийн говь, Зармангийн говь нутагт талархаг болон хотгор газрын хөрс зонхилох бөгөөд ил нутгуудад хүрэн, цайвар хүрэн, нимгэн цөлөрхөг хээрийн нугат бор, цөлийн бор саарал, цөлийн нимгэн давхаргатай бор саарал, хэт гандуу цөлийн гөлтгөнөтэй нимгэн давхрагатай бор саарал, борзонт, марз, мараа бүхий хэв шинжийн хөрс тархан бүрэлджээ.

Ургамалжилт: Зармангийн хоолой ОНТХГ-нд 12 төрлийн ургамал-хөрсний хэв шинж тодорхойлогдсон байна. Түүнээс саарал хүрэн цөлөрхөг хөрсөнд баглуур зонхилсон таар, шар мод, зээргэнэ, загт бүлгэмдэл эсвэл шаварлаг хүрэн хөрсөнд, шар мод, газрын цагаан шарилж бүхий бүлгэмдэл ОНТХГ-ын төв хэсгээр 52,773 га талбайд (нийт нутгийн 44.2%) зонхилон тархжээ. (Зураг. 3)



Зураг 3. Зармангийн ургамалжилт болон хөрсний хэв шинж

Уур амьсгал: Эрдэнэ сумын нутаг бүхэлдээ хуурай сэрүүн, салхитай, хүйтэвтэр уур амьсгалтай. I сарын агаарын дундаж температур $-14-20^{\circ}\text{C}$, VII сарынх $+19+26^{\circ}\text{C}$ байдаг. Хоногийн агаарын дундаж хэм $+10^{\circ}\text{C}$ байх хугацаа 70-90 хоног, говьдоо 120-130 хоног байдаг. Гэвч уулын хяр, говь цөл нь эрс тэс зөрүүтэй. Зун VII сард Зармангийн говьд $+50^{\circ}\text{C}$ хүртэл халуун байхад Эмээлцгийн нуруунд дөнгөж $+4^{\circ}\text{C}$ байх жишээтэй байдаг. Гичгэний нуруу, Эмээлцгийн нуруунд зуны ихэнх хоногт өндөр уулын салхитай хуурай, хүйтэвтэр уур амьсгал зонхилж байдаг бол Алтай өвөр говь, Номингийн говь, Зармангийн говь, Хатан суудлын тал нутгаар дулаавтар цөлөрхөг хээрийн уур амьсгалын шинж төлөв ажиглагдана. Алтайн өвөр говьд хавар V сарын 1-ээс өмнө агаарын хоногийн температур 10°C бол ууландаа VI сарын 1-ээс хойш дундаж температур энэ хэмд очно. Сүүлийн 10 жилийн агаарын дундаж температур -16.46°C -аас $+16.32^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэв/График 1/.




График 1. 2013-2022 оны агаарын дундаж температур ба жилийн дундаж хур тунадасны хэмжээ

Жилийн дундаж хур тунадас 100-150 мм. Нутгийн хойд хэсэгтээ 200 мм, өмнөд хэсэгтээ 50 мм хур тунадас жилд унадаг. Жилдээ 30-40 хоног 15м/с салхитай байдаг. Үүнээс үзэхэд Эрдэнэ суманд хур тунадас багатай гандуу зун, хахир хатуу өвөл болдог. Ийнхүү ган, зуд болж сумын эдийн засгийн гол тулгуур болдог мал аж ахуйд ихээхэн бэрхшээл учрах нь олонтаа. Тухайлбал, 1924-1925 он, 1944-1945 он, 1957-1958 он, 1963-1964 он, 1967-1968 он, 1992-1993 он, 2000-2002 он, 2009 оны өвөл хавар орсон их хэмжээний цасны улмаас зуд болж олон тооны мал хорогдож байжээ.

Гэвч хур бороотой бүрхэг өдөр цөөн, байнгын салхитай байдаг нь нар салхины сэргээгдэх эрчим хүчийг ахуйн зориулалтаар ашиглах таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Гадаргын болон хөрсөн доорх ус: Гадаргын усны мужлалын хувьд Эрдэнэ сумын нутаг нь түргэн урсгал бүхий гол горхитой мужид хамрагдана. Өөрөөр хэлбэл улирлын хомсдолтой гүний болон цас мөсний усаар тэтгэгддэг жижиг горхи, булаг шандууд гадаргын усны нөөцийг бүрдүүлдэг. Өндөр уулнаас эх авсан Өлзийт, Алдар, Цахир салаа, Ямаан ус, Өгөөмөр, Сэвхүүлт, Бумбат, Гурван гол, Улааны гол, Хадат, Жавхлант, Баянбулаг, Гудир, Овоот, Шатан зэрэг 30 орчим


жижиг горхи, булаг шандууд байдаг. Үүний зэрэгцээ Зарман, Баруун шарга, Зүүн шарга, Замын бэлгэх, Шар хулс, Цагаан бургас, Тооройн булаг, Бага цагаан дэрс, Богц цагаан дэрс, Загийн худаг, Цагаан байшинт, Хулангийн тойром зэрэг байгалийн үзэсгэлэнт баян бүрдүүдтэй. Гадаргын усны нөөцөд Цэцэг нуур, Сангийн далай, Улаан нуур, Цагаан нуур, Олгой нуур, Нүдэн нуур, Салхитын нуур, Гүн нуур, Бор довонгийн нуур, Цац нуур, Бүлагийн нуур, Шорвог нуур, Холбоо нуур зэрэг 20 шахам жижиг нуурууд орно. Газрын доорх усыг ашиглах гол хэлбэр нь инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худгууд юм.

Ашигт малтмал: Эрдэнэ сумын нутагт алт, зэс, цайр зэрэг өнгөт металл, гоёл чимэглэлийн чулуу, гянт болдын илэрцээс гадна чулуун нүүрс, төмөр, хар тугалганы хүдэр, Улаан толгой, Ширтийн олон өнгийн шороон будаг, Цахир замтын цагаан шороо зэрэг байгалийн орд газруудтай. 2020 оны байдлаар тус суманд ашиглалтын лиценз 3 талбайд, хайгуулын лиценз 12 талбайд олгогдсон байна.

Эрдэнэ сумын газар ашиглалт

Эрдэнэ сумын нийт нутаг дэвсгэрийн 1,690,145 га газар нутаг ГИДЦГ-ын А хэсэгт хамаарч улсын тусгай хамгаалалтад оршдог. Мөн сумын ИТХ-ын тогтоолоор 2005 оноос эхлэн нийт 296,881.85 га талбайг орон нутгийн хамгаалалтад авсан. Үүнд: Суман хайрхан 37892.2 га, Цагаан хайрхан 663.94 га, Хараат хайрхан 6787.16 га, Зармангийн говь 118472.62 га, Долооны хоолой 114566.73 га, Шүрт булаг 13610.52 га, Цагаан дэрс 42780.88 га.

Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хайгуулын лиценз бүхий талбай 83,203 га, ашиглалтын лиценз бүхий талбай 2747.62 га байна (Зураг.4).




Зураг 4. Эрдэнэ сумын Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар ба газар ашиглалт

Хүн ам

ГИДЦГ-ын “А” хэсгийн орчны бүсэд хамаарах 2 аймгийн 5 сумын нийгэм, эдийн засаг, байгаль орчны 2030 он хүртэлх хэтийн төлөвийн математик загварчлалаас харахад Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын хүн амын хэтийн төлөв 2030 оныг 1990 онтой харьцуулахад 39 хувиар өсөх тооцоололтой байна (График 2). Тухайлбал Эрдэнэ сумын суурин хүн ам 2021 оны байдлаар 2326 болж өссөн байна.

1990-2021 оны хооронд сумын хүн ам 14,2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2005 онд хамгийн бага буюу 2032, 1999 онд хамгийн их буюу 2638 хүн амтай байжээ. Энэ үзүүлэлтээрээ Эрдэнэ сум Говь-Алтай аймгийн 18 сумаас 7-нд эрэмбэлэгдэж байна. Харин бусад 4 сумын хүн амын нягтаршил 2030 он хүртэл өнөөдрийн түшингээс төдийлөн нэмэгдэхгүй, зарим сумдад буурах хандлагатай байна. Монгол улсын хүн амын цэвэр өсөлт дунджаар 1,5-2 хувь байдаг бөгөөд сумын хүн ам ийнхүү нэмэгдэхгүй байгаа нь шилжилт хөдөлгөөнтэй шууд холбоотой гэж үзэж байна (Хүснэгт.2).



Зураг 5. Эрдэнэ сумын хүн амын сектор




График 2. Эрдэнэ сумын хүн амын тоо, хэтийн өсөлт

	1990	2000	2010	2020	2030	2040
Нийт хүн ам	2036	2388	2241	2342	2488	2633
Төрөлт	-	-	67	64	61	65
Нас баралт	-	-	20	12	14	15
Цэвэр шилжилт хөдөлгөөн	-	-	162	68	33	35

Хүснэгт 2. Эрдэнэ сумын нийт хүн ам, төрөлт, нас баралт, цэвэр шилжилт хөдөлгөөн, хэтийн төсөөлөл





График 3. Эрдэнэ сумын хүн ам

Хөгжлийн төлөв

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Говь-Алтай аймгийн нийт ДНБ нь 2021 оны байдлаар улсын нийт ДНБ-ний 2,3 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн хувьд тодорхой алхам хийх шаардлагатай байгааг харуулж байна. Эрдэнэ сумын эдийн засагт ХАА-н салбар, үүн дотроо бэлчээрийн мал аж ахуйн салбар давамгайлдаг. Эрдэнэ сумын нэг хүнд ноогдох ДНБ болон нийт үйлдвэрлэлийн хэмжээг харуулав (График 4). Аймгийн хэмжээнд нийт үйлдвэрлэл 2021 онд 7 тэрбум төгрөгөөс 2040 онд 10 тэрбум төгрөг болж нэмэгдэхээр байна. Харин нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 6 сая төгрөгөөс 2040 он гэхэд 10,6 сая төгрөг болж нэмэгдэхээр байна.



Зураг 6. Говийн их дархан цаазат газрын “А” орчны бүсэд хамрагдах сумдын ДНБ-ний сектор





График 4. Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэл ба нэг хүнд ноогдох ДНБ, 2040 он хүртэлх хэтийн төсөөлөл




График 5. 2021 оны байдлаар Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэл, салбараар






График 6. 2040 оны байдлаар Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэл, салбараар

Хөдөө аж ахуй: 2021 оны байдлаар хөдөө аж ахуйн салбар нь Эрдэнэ сумын нийт үйлдвэрлэлийн 61%-ийг бүрдүүлж байна (График 7). Үүнд газар тариалан, бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл багтах бөгөөд ихэнх нь бэлчээрийн мал аж ахуйгаас бүрдэнэ. Хэтийн төлөвөөс харахад Эрдэнэ сумын хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл харьцангуй өсөлттэй байхаар байна (График5). Иймд малын гаралтай түүхий эдийг боловсруулах дараагийн шатны үйлдвэрүүдийг бий болгож чадвал Эрдэнэ сумын ДНБ илүү өсөх боломжтой.






График 7. Эрдэнэ сумын хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө, үйлдвэрлэл, ажил эрхлэлт

Мал сүрэг: Эрдэнэ сумын нийт малын 80 орчим хувийг ямаа эзэлдэг. 1990 онд нийт бэлчээрийн малын 4,5 хувийг адуу, 4,4 хувийг үхэр, 3,4 хувийг тэмээ, 44,9 хувийг хонь тус тус эзэлдэг байсан бол 2020 онд адуу 1,6 хувь, үхэр 0,6 хувь, тэмээ 1,3 хувь, хонь 18,5 хувь болж буурсан бол ямааны тоо 42,7 хувиас 77,9 хувь болж өссөн байна. 2021 оны байдлаар улсын хэмжээнд ямааны эзлэх хувь хэмжээ 39 хувьтай байгаа бол Эрдэнэ сумын ямааны тоо толгой эзлэх хувь хэмжээ бараг 2 дахин их буюу 78 хувьтай байна (Хүснэгт.3). Малчин иргэдийн орлогын 90 гаруй хувь нь зөвхөн мах, ноолуурын борлуулалт бүрдүүлж байна. Эрдэнэ сумын нийт бэлчээрийн малын тоо толгойг таван хошуу малын төрлөөр болон нийтээр нь харуулав (График 8, 9).




График 8. Эрдэнэ сумын бэлчээрийн малын тоо толгой, төрлөөр, 2040 он хүртэлх хэтийн төсөөлөл

	1990	2000	2010	2020	2030	2040
[Эрдэнэ, Адуу]	4.52	3.65	1.14	1.64	1.64	2.09
[Эрдэнэ, Үхэр]	4.41	1.69	0.31	0.57	0.57	0.49
[Эрдэнэ, Тэмээ]	3.4	1.72	1.33	1.31	1.31	1.86
[Эрдэнэ, Хонь]	44.92	35.85	18.49	18.53	18.53	15.16
[Эрдэнэ, Ямаа]	42.75	57.09	78.73	77.95	77.95	80.4

Хүснэгт 3. Эрдэнэ сумын бэлчээрийн малын тоо толгой, төрлөөр, 2030,2040 онуудын хэтийн төсөөлөл




График 9.Эрдэнэ сумын нийт бэлчээрийн малын тоо толгой, 2040 он хүртэлх хэтийн төсөөлөл




График 10. Эрдэнэ сумын таван хошуу малын эзлэх хувь, 2040 он хүртэлх төсөөлөл

	Нийт малын тоо, мянган тоо толгой	Ямааны тоо толгой, мянган тоо толгой	Эзлэх хувь
Улсын дүн	67,343.76	26,456.09	39%
Баруун бүс	16,448.05	7,715.20	47%
Говь-Алтай	2,990.51	1,875.76	63%
Эрдэнэ	180.27	140.78	78%

Хүснэгт 4. 2021 оны ямааны эзлэх хувь хэмжээ, бүс нутгаар

Бэлчээр: Эрдэнэ сумын бэлчээрийн боломжит ургацын хэмжээ нь жилд дунджаар 400-600 мянган центр байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлт, малын тоо толгойн өсөлтөөс шалтгаалан ирээдүйд багасах хандлагатай байна (*График10*). Эрдэнэ сумын бэлчээрийн даацад байх ёстой малын тоо 2011 оноос хойш байнга хэтрэлттэй байгаа бөгөөд 2017 онд 4 дахин хэтэрсэн тоон үзүүлэлт гарсан. Ирээдүйд Эрдэнэ сумын хувьд бэлчээрийн даац дунджаар 1,6 дахин их байхаар байна (*График11*). Иймд малын тоог зүй зохистой өсгөх тал дээр анхаарах шаардлагатай.





График 11. Эрдэнэ сумын бэлчээрийн боломжит ургацын хэмжээ

Түүхэн Бэлчээрийн даац хэтрэлт



2040 он хүртэлх бэлчээрийн даац хэтрэлт





График 12. Эрдэнэ сумын 1990 оноос хойших бэлчээрийн даац хэтрэлт болон хэтийн төлөв

Аж үйлдвэр: Эрдэнэ сумын аж үйлдвэрлэлийн салбар нийт ДНБ-ий 12 хувийг эзэлдэг бөгөөд цаашид энэхүү хувь өсөх хандлагатай байна (График 13). Мал аж ахуйн гаралтай түүхийг бүрэн боловсруулах үйлдвэрүүд барьж чадсанаар аж үйлдвэрлэлийн салбар хөгжих боломжтой харагдаж байна.

Үйлдвэрлэлийн салбар



Зураг 7. Аж үйлдвэрлэлийн салбарын сектор





График 13. Эрдэнэ сумын аж үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө, үйлдвэрлэл, ажил эрхлэлт

Үйлчилгээний салбар: Эрдэнэ сумын ДНБ-ий 27 орчим хувийг үйлчилгээний салбар эзэлдэг бөгөөд энэ хувь хэмжээ ирээдүйд өсөх хандлагатай байна (График 14). Учир нь ТХГН, ховор ан амьтдыг үзүүлэх экстрем аялал жуулчлал хөгжих боломжтой.






График 14. Эрдэнэ сумын үйлчилгээний салбарын хөрөнгө, үйлдвэрлэл, ажил эрхлэлт

Уур амьсгалын өөрчлөлт: Дэлхийн банкнаас Монгол Улсын 2100 он хүртэлх цаг агаарын өөрчлөлтийг урьдчилсан таамаглан гаргасан бөгөөд Говь-Алтай аймгийн агаарын дундаж температур болон хур тунадасны хэмжээг 5 өөр төрлийн сценариар харуулсан байдаг (График 15). Үүнд:

- **SSP1-1.9: IPCC-ийн хамгийн өөдрөг хувилбар.** 2050 он гэхэд дэлхийн CO₂ ялгаруулалт цэвэр тэг болж бүүрнэ, эдийн засгийн өсөлтөөс илүү нийгмийн сайн сайхан байдалд анхаарлаа хандуулж, илүү тогтвортой байдалд шилжинэ. Боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэнэ, тэгш бус байдал арилна. Цаг уурын эрс тэс үзэгдэл түгээмэл байсан ч сөрөг нөлөөллөөс зайлж чадна.
- **SSP1-2.6: Дараагийн сайн хувилбар.** Дэлхийн CO₂ ялгаруулалт эрс багасгасан ч хурдан биш, цэвэр тэг болох нь 2050 оноос хойш. Нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлын төсөөлөл SSP1-1.9 сценаритай адил. Дэлхийн агаарын температур энэ зууны эцэс гэхэд 1.8о С орчимд тогтворжино.
- **SSP2-4.5: Энэ бол “замын дунд” гэсэн сценари.** CO₂ ялгаруулалт зууны дунд үе эхлэхээс өмнө өнөөгийн түвшинд хүрч бүүрэх хэдий 2100 он гэхэд цэвэр тэгт хүрэхгүй. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс түүхэн хандлагаар үргэлжилнэ, мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй. Тогтвортой байдалд чиглэсэн ахиц дэвшил удаан, хөгжил, орлогын өсөлт жигд бус. Зууны эцэс гэхэд температур 2.7о С хэм хүрч нэмэгдэнэ
- **SSP3-7.0: 2100 он хүртэл хүлэмжийн хийн ялгаралт, агаарын температур нэмэгдэнэ.** CO₂ ялгаралт одоогийн түвшнээс бараг хоёр дахин их болно. Улс орнууд хоорондоо илүү өрсөлдөнө, үндэсний аюулгүй байдлаа хамгаалах, хүнсээ өөрсдөө хангахад илүү анхаарна. Зууны эцэс гэхэд дундаж температур 3.6о С хүрч нэмэгдэнэ
- **SSP5-8.5: Энэ бол ямар ч үнээр хамаагүй зайлсхийх сценари.** 2050 он гэхэд одоогийн CO₂ ялгаралтын түвшин ойролцоогоор хоёр дахин нэмэгдэнэ. Дэлхийн эдийн засаг хурдацтай хөгжих хэдий ч өсөлт нь чулуужсан түлш, эрчим хүч их шаарддаг амьдралын хэв маягаас үүдэлтэй. 2100 он гэхэд дэлхийн дундаж температур 4.4о С-ээс их болно.




График 15. Аймгийн агаарын дундаж температурын хэтийн төлөв

Говь-Алтай аймгийн агаарын дундаж температур 1995 онд 2,55 градус байсан бол 2014 онд 3,65 градус болж нэмэгдсэн ба 2021 онд 4 градус хүрч өссөн байна. 2050 он гэхэд агаарын дундаж температур хамгийн сайндаа 4,5 хамгийн муудаа 5,9 градус болж нэмэгдэхээр байна (График 16).




График 16. Говь-Алтай аймгийн хур тунадасны хэмжээний хэтийн төлөв

Харин Говь-Алтай аймгийн хур тунадасны хэмжээ 1995-2014 оны хооронд хамгийн ихдээ 135мм байсан бол хамгийн багадаа 113мм байжээ. Харин 2015-2050 оны хооронд хамгийн багадаа 94,2 хамгийн ихдээ 147мм болохоор байна.

Зармангийн ОНТХГ-ын малчдын нийгэм эдийн засгийн байдал

Өрхийн аж ахуй болон эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт (2021-2022)

Зармангийн хоолой ОНТХГ-нд нутагладаг 4 баг (Өлзийт, Цэцэг нуур, Сангийн далай, Цагаан уул)-ийн нийт 84 малчин өрхийн 55 хувь буюу 46 өрхөөс нийгмийн суурь судалгааны 6 багц асуулт бүхий судалгаа авч малчдын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлов. Үүнд: (i) Өрхийн ерөнхий мэдээлэл, (ii) Өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэнд, (iii) Өрхийн амьдралын нөхцөл, (iv) Өрхийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлт, гарсан өөрчлөлт, (v) Байгалийн нөөц, түүний доройтол, хамгаалал, (vi) Малчдын хандлага ойлголт.

Түүвэр судалгаанд малчин өрх тус бүрээс насанд хүрсэн, шийдвэр гаргах түвшний нэг гишүүнийг оролцуулав. Судалгаанд оролцсон гишүүдийн 25 нь өрхийн тэргүүлэгч, 20 нь эхнэр эсвэл нөхөр, 1 нь хүү эсвэл охин байв. Судалгаанд оролцогчдын 60.9% буюу 28 нь эрэгтэй, үлдсэн 39.1% буюу 18 нь эмэгтэй байв. Асуулгаар тухайн 46 өрхийн 205 гишүүний мэдээллийг цуглуулсан болно.

Судалгаанд хамрагдсан иргэд насны бүтцийн хувьд хамгийн багадаа 20 настай, хамгийн ихдээ 79 настай, дунджаар 41 насны оролцогчид судалгаанд хамрагджээ. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны ашигладаг насны ангиллаар судалгаанд оролцогчдын насыг ангилсан ба доорх гарафикт үзүүлэв (График 18). Нийт судалгаанд оролцогчдын 37.8% буюу гурван оролцогч тутмын хоёр нь 40-49 насныхан байсан бол 20-29 насны оролцогчдын хувьд харьцангуй цөөн буюу 13.3%-ыг бүрдүүлсэн байна. Ахмад буюу 50-аас дээш насны оролцогчид 22.2%-ыг бүрдүүлжээ.

Нийт оролцогчдын гэрлэлтийн байдалд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор гэрлэлтийн байдлыг зураглалаа. Судалгаанд хамрагдсан оролцогчдын дийлэнх буюу 84.4% нь гэрлэлтээ батлуулсан байсан. Харин салсан болон бэлэвсэн оролцогч тус бүр 2.2% -ийг эзэлж байна (График 19).




График 18. Судалгаанд оролцогчдын тоо, насны ангиллаар, %, N=46




График 17. Гэрлэлтийн байдал, %, N=46

Боловсрол: Судалгаанд хамрагдсан оролцогчдын боловсролын түвшин харьцангуй доогуур байв. График 18-аас харахад бакалавр болон дээд боловсролтой оролцогч байхгүй ба оролцогчид бүгд дунд болон түүнээс доош түвшний боловсролтой байна. Тухайлбал, нийт 69 иргэний 22 буюу 47.8% нь дунд сургуулийн, 9 иргэн буюу 19.6% нь бага сургуулийн, 8 иргэн буюу 17.4% нь бага, 6 иргэн буюу 13.3% нь Техникийн/мэргэжлийн боловсролтой ба 1 иргэн буюу 2.2% нь боловсролгүй байна.

Графикт 19-нд үзүүлсэн гистограммаас харахад нийт өрхийн гишүүдийн 1.7% бакалавр болон түүнээс дээш зэргийн боловсролтой, үлдсэн 98.3% нь бакалаврын бус зэргийн, техник, мэргэжлийн боловсрол болон түүнээс доош түвшний боловсролтой байна. Тухайлбал, нийт өрхийн 219 насанд хүрсэн гишүүнээс 38 гишүүн буюу 32.8% дунд, 29 гишүүн буюу 25% бүрэн дунд, 25 гишүүн буюу 19.8% бага, 13 гишүүн буюу 11.2% нь мэргэжлийн, 10 гишүүн буюу 8.6% нь бакалаврын бус зэргийн дипломтой, 1 гишүүн буюу 0.9% нь боловсролгүй байна.

Суурь судалгааны хувьд өрхийн насанд хүрсэн гишүүдийн дотор бага болон түүнээс доош (тав болон түүнээс доош анги) боловсрол эзэмшсэн гишүүнтэй 27 өрх байв. Энэ нь нийт судалгаанд

хамрагдсан өрхийн 58.7% байгаа нь өрхийн насанд хүрсэн гишүүдийн боловсрол дундаж байгааг илтгэж байна. Сургууль завсардсан сургуулийн насны (6-14 нас) хүүхэдтэй өрх суурь судалгаанд хамрагдаагүй байна.




График 19. Боловсролын түвшинээр, %, N=46

Эмзэг бүлэг: Суурь судалгаанд хамрагдсан 46 өрхийн 205 гишүүд дунд бэлэвсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус бүр 1 буюу 2.2% -ийг эзэлж байна. Харин өнчин, 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл, өвчтэй гишүүд гэсэн эмзэг бүлэгт хамаарагдах иргэн судалгаанд оролцсон өрхүүдэд байхгүй байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн дотор эмзэг бүлэгт хамрагдах гишүүдийн тоо, эзлэх хувийг нийт гишүүдийн тоонд эмзэг бүлэгт хамаарах гишүүдийн тооны эзлэх хувийг харуулав (Хүснэгт 5).

Эмзэг бүлэг	Суурь судалгаа, N=205	
	Бүлэгт хамаарагдах иргэдийн тоо	Эзлэх хувь
Бэлэвсэн хүн	1	2.2%
Хөгжлийн бэрхшээлтэй хүн	1	2.2%
Өнчин	0	0%
5-аас доош насны хүүхдийн эндэгдэлтэй	0	0%
Өвчтэй байгаа гишүүн	0	0%
Нийт	2	4.4%

Хүснэгт 5. Нийт гишүүдийн тоонд эмзэг бүлэгт хамаарах гишүүдийн тооны эзлэх хувь




График 20. Боловсролын түвшинээр хистограмм, насанд хүрсэн нийт өрхийн гишүүдээр, %, N=46

Эрүүл мэнд: Сүүрь судалгаанд хамрагдсан 46 өрхийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гишүүдийн тоогоор авч үзэхэд 97.8% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол үлдсэн 2.2% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байна. Тухайлбал, 2 удаа хамрагдаж байсан гишүүд 45.7% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин 4 болон 5 удаа хамрагдаж байсан гишүүд 6.5% болон 4.3% -ийг тус тус эзэлсэн байна. Төслийн сүүрь судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг гишүүдийн тооны интервал болон нийт өрхөд эзлэх хувиар харуулав (График21).




График 21. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, %

Амьдарч буй сууц, түүний нөхцөл: Сүүрь судалгаанд оролцсон өрхийн 78.3% нь гэр, 19.6% нь гэр болон байшин аль алинд нь, 2.2% нь байшинд амьдарч байна. Харин орон сууц болон бусад сууцны төрөл амьдарч байгаа өрх байхгүй байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн амьдарч буй сууцны төрөлд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор сууцны төрлийг ялган харууллаа (График 22).




График 22.Өрхийн амьдарч буй сууцны төрөл, %, N=46

Цахилгаан, эрчим хүч: Суурь судалгаанд оролцсон нийт өрхийн нэг өрхөөс бусад нь буюу 98.7% нь цахилгааны хангамжтай байна. Тэдний дийлэнх нь нарны эрчим хүчээр цахилгааны хэрэгцээгээ хангадаг ба нийт өрхийн 89.1% хувийг эзэлж байна. Дизель болон нарны эрчим хүч аль алиныг нь ашигладаг өрх 2 буюу нийт өрхийн 4,3%-ийг эзэлсэн бол бага оврын батарейтай цахилгаан үүсгэвэр, нийтийн тогийг түс бүр 1 өрх ашигладаг байна. Эндээс харахад суурь судалгаанд нэг өрх амьжиргааны түвшний индикаторын тог цахилгааны үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой гарсан байна. Нийт өрхийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор цахилгаан, эрчим хүчний эх үүсвэрийг ялган харууллаа (График 23)





График 23. Өрхийн цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=46



Ундны цэвэр ус: Ундны цэвэр усны гол эх үүсвэрийн хувьд суурь судалгаанд оролцсон нийт өрхийн дийлэнх буюу 89.7% нь хамгаалагдсан худаг ашиглаж байна. Харин 2.9% нь хамгаалагдсан булаг шанд, 4.4% нь зөөврийн усны үйлчилгээ, 3% буюу хоёр өрх нь гадаргын буюу гол, мөрөн болон борооны усыг ашигладаг байна. Өрхийн ундны цэвэр усны гол эх үүсвэрт ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор *График24*-т ундны цэвэр усны эх үүсвэрийг байршлаар ялган харууллаа.




График 24. Өрхийн ундны усны гол эх үүсвэр, давхардсан тоогоор %, N=46

Ундны цэвэр усны хүртээмжийн хувьд цэвэр усаар хангагдаагүй болон цэвэр ус авахаар гэрээсээ гарахад 30-аас дээш минут зарцуулах шаардлага гардаг бол цэвэр усны хомсдолтойд тооцдог. Ундны цэвэр усанд хоолойн ус, нийтийн цорго, цооног, шахуурга, хамгаалалттай худаг, хамгаалагдсан булаг шанд зэрэг ордог. Доорх хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан нийт өрх цэвэр усны хомсдолтойд тооцогдож байна (*Хүснэгт.6*).

	Өвөлжөө хугацаа	Хаваржаа хугацаа	Намаржаа хугацаа	Отор хугацаа
Ундны усанд хүрэх дундаж хугацаа	47 мин	62 мин	74 мин	68 мин

Хүснэгт 6. Ундны цэвэр усны үүсвэрт хүрэх хугацаа, %, N=46

Дулаан эх үүсвэрийн нөхцөл байдал: Тухайн өрх мод, нүүрс эсвэл аргал түлдэг бол цэвэр түлшний гачигдал хомсдолтойд тооцогддог. Өрхүүдийн дийлэнх нь ердийн галлагаа болох мод, бууцаар дулааны хангамжаа бүрдүүлж байна. Суурь судалгаанд оролцсон өрхийн 93.5% нь аргал, хөрзөн түлдэг, 41.3% нь мод түлдэг, 17.4% нь нүүрс түлдэг. Харин шахмал түлш хэрэглэж байгаа өрх 4.3%-ийг эзэлж байгаа нь цэвэр түлшний гачигдалтай байгааг илтгэж байна (*График25*).

Өрхийн амьжиргаа: Судалгаанд хамрагдсан малчин өрхийн нийгэм эдийн засгийн шинж байдал, түүний өөрчлөлтийг энэхүү бүлэгт харууллаа. Өөрчлөлтийг харуулахдаа сүүлийн 2 жилээр харьцуулан харуулсан ба өрхийн амьжиргааны нөхцөл байдал, өрхийн аж ахуй эрхлэлт, өрхийн орлого зарлага, хадгаламж ба зээлийн шинж байдал гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр хэмжсэн. Судалгаанд хамрагдсан нийт өрхөөс өөрсдийгөө амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдралтай гэж үзсэн өрх байхгүй байсан. Нийт өрхийн 63.04% нь өөрсдийгөө дундаж давхраанд, 32.6% нь дундаас дээгүүр давхраанд хамаарагдана гэж үзсэн байна (График26).




График 26. Өрхийн нийгмийн амьжиргааны түвшин, %, /өөрийн субъектив үнэлгээгээр/

Сүүлийн 2 жилийн амьжиргааны түвшний өөрчлөлтийн хувьд бүр дордсон гэж дүгнэсэн өрх байхгүй бөгөөд нийт өрхийн 6.5% нь бага зэрэг доошилсон, 52.2% нь хэвэндээ, 39.1% нь бага зэрэг дээшилсэн, 2.2% нь мэдэгдэхүйц дээшилсэн гэж үзсэн байна (График27).




График 27. Өрхийн амьдралын түвшний өөрчлөлт, %

Амьжиргааны түвшин өөрчлөгдсөн шалтгааныг давхардсан тоогоор авч үзэхэд 60,9% нь байгаль, цаг уурын нөхцөл, 50% нь COVID 19 цар тахлын нөлөө, 41.3% нь нутаг орны нийгэм эдийн засгийн байдал гэсэн 3 хүчин зүйл хамгийн өндөр хувиар нөлөөлсөн байна. Харин амьжиргааны түвшний өөрчлөлтөд олон улсын төсөл, хөтөлбөр огт нөлөөлдөггүй буюу 0% -ийг эзэлсэн (График 28).




График 28. Өрхийн амьдралын өөрчлөлтийн шалтгаан, %

Өрхийн орлого, зарлага: Малчдын орлого олдог хамгийн өндөр эх үүсвэр бол 2021, 2022 оны байдлаар ноолуур байна. Харин зөвхөн 2021 оны байдлаар авч үзэхэд цагаан идээ хамгийн өндөр орлого олсон боловч 2022 онд огцом буурсан үзүүлэлтийг үзүүлж байна (График29).




График 29. Өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр, /оноор/

Зарлагын хувьд хүнс, бензин, түлш, баяр наадам, малын тэжээл гэсэн бүлгүүдэд хуваан авч үзсэн бөгөөд эдгээр зарлагын эх үүсвэрүүдийн хооронд огцом ялгаа байхгүй ч 2021 оноос 2022 оны зарлага өссөн үзүүлэлт гарч байна (График 30). Орлого болон зарлагыг 2021-2022 оны байдлаар бууралт, өсөлт гарсан эсэхийг авч үзэхэд орлого өсөж, зарлагын хэмжээ буурсан байна (График31).




График 30. Өрхийн жилийн дундаж зарлага, мөнгөн дүнгээр, /оноор/




График 31. Өрхийн орлого, зарлагын өөрчлөлт, мөнгөн дүнгээр, /оноор/

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 63.04 хувь хадгаламжтай байна. Зээлтэй өрх 2022 онд 97.8% зээлжилтийн хувь маш өндөр байлаа. Гэвч төвөөс алслагдмал байдал, өрхийн орлого нотлох

боломжгүй зэрэг шалтгааны улмаас банкнаас зээлжих боломж бага. Тиймээс ах дүү, хамаатан саднаасаа зээл авах тохиолдол хэт өндөр буюу 98% байна (График 32).




График 32. Сүүлийн хоёр жилийн хадгаламж болон зээл авсан байдал

Менежментийн төлөвлөгөө боловсруулах үндэслэл

Зармангийн хоолой нь дэлхийн нэн ховор зэрлэг амьтад, Төв Азийн унаган ургамал, тэдгээрийн тархац нутаг болсон **Говийн Их Дархан Цаазат Газар** (ГИДЦГ)-ын “А” хэсгийн орчны бүс болохын сацуу зэрлэг амьтдын чөлөөтэй нүүх, шилжих хөдөлгөөний “коридор”¹ нутаг юм. Тус коридор нутгийн экологийн болон нийгмийн ач холбогдлыг хураангуйлбал² :

- Алтайн нурууны говийн мужийн Говь-Алтайн салбар уулс, хотгорын дэд мужид багтдаг, цөлжүү хээрийн экосистемийг хамардаг эмзэг экосистем бүхий нутаг
- Олон улсын болон Монгол Улсын улаан номд орсон хавтгай, хулан, хар сүүлт, мазаалай, ирвэс, аргаль, янгир зэрэг ховор амьтад, хойлог, ёл, тас, сар, ууль, бэгбаатар, шар шувуу зэрэг Евроазийн хээр ба цөлийн биомын шувуудтай, эдгээр ховор амьтад байнгын шилжилт хөдөлгөөн хийдэг өвөрмөц орчин
- “Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” конвенц (CITES)-ийн I, II хавсралтад орсон саарал чоно, мануул мийн идээшил нутаг
- Хиргисүүр, дугуй булш, чулуун байгууламж, хүрлийн үеийн булш, чулуун байгууламж зэрэг түүх соёлын дурсгалт газраар баян

Эдгээр ач холбогдлыг нь харгалзан Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 2020 оны 1 дүгээр сарын 25-ны 14 тоот тогтоолоор Зармангийн говийн төв хэсэгт хамаарах 118,472.62 га талбайг “Зармангийн хоолой” нэртэйгээр орон нутгийн тусгай

¹ Экологийн коридор нутаг нь урт хугацааны туршид хадгалах эсвэл экологийн үр дүнтэй холболтыг сэргээх, удирдан зохицуулах газарзүйн тодорхой орон зайг хэлнэ

² НҮБХХ/ДДБХ сангийн ЭНШҮР/ENSURE төслийн санхүүжилтээр хийсэн Зармангийн хоолойг ОНТХ-нд авах үндэслэл

хамгаалалтад (ОНТХ) авчээ. Улмаар Монгол Улсын кадастрын бүртгэлийн системд Зармангийн хоолой ОНТХГ-ын 118,460.58 га талбайг 2021 оны 2 сарын 4-нд бүртгэсэн байна (Зураг.5).

Тус газрын экологи-нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэж **Даян Дэлхийн Байгаль Орчны Сан** (ДДБОС)-ийн санхүүжилтээр **НҮБХХ, БОАЖЯ**-ны хамтран хэрэгжүүлж буй “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” (**ENSURE**) төслөөс Зармангийн хоолойн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах шийдвэр гаргасан бөгөөд тус ажлыг **Луужин Амьтан Судлалын Нийгэмлэг** гүйцэтгэв. Хоёр тал 2022 оны 7 дугаар сарын 27-нд 22/171 тоот гэрээг байгуулж нийт 5 сарын хугацаанд **Эрдэнэ сумын ИТХ, ЗДТГ, Зармангийн хоолойд нутаглах малчдын** оролцоотой уг менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүй

Зармангийн хоолойн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын БОАЖ-ын сайдын 2021 оны 1-р сарын 22-ны өдрийн А/16 тоот тушаалаар баталсан “**Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй**”-г баримтлан боловсруулахдаа дараах зарчмыг мөрдөн ажиллав. Үүнд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй харилцан уялдаатай, бодлогын залгамж чанарыг хадгалсан байх,
2. Хамтын оролцоог хангах, ил тод, нээлттэй байх,
3. Түншлэх,
4. Бүгдийг бус чухлыг сонгох,
5. Бодит мэдээлэлд суурилах, нотлох баримт бүрдүүлж зохих ёсоор ашиглах,
6. Үр дүнгээ тогтмол хянах,
7. Уян хатан байх,
8. Түршлагаа хуваалцах, суралцах, нээлттэй харилцах

Түүнчлэн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад тавигддаг гол **шаардлагыг** хангаж ажилласан. Ялангуяа, ГИДЦГ-ын орчны бүсэд тус ОНТХ-ыг байгуулсан үндэслэл, зорилгын хэрэгжилтийг хангахад чиглүүлж, түүний онцлогт нийцүүлэхийн сацуу Монгол Улсын болон аймаг, сумын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулах улмаар манай улсын нэгдэн орсон Олон улсын конвенцуудын үзэл санаатай нэгдмэл байх шаардлагыг хангахыг хичээв.

Цаашид энэхүү менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх Эрдэнэ сумын нутгийн удирдлага, малчид, бусад байгаль хамгааллын байгууллагуудын оролцоог хангахуйц бүтэц, зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэхийг зорьж ажиллав.

Зармангийн хоолойн экосистемийн зохистой үйл явцыг хангах, биологийн олон янз байдал, байгалийн нөөц баялгийг ашиглах, хамгаалах талаар Эрдэнэ суманд хэрэгжиж ирсэн болон цаашид хийгдэх ажлыг харгалзан үзэж, Алтайн өвөр говийн бүс нутгийн түвшинд байгаль хамгаалал, хөгжлийн нэгдмэл чанарыг ханган Их говьд ландшафтын нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд төлөвлөгөөг боловсруулав. Үүнд ОНТХГ-ын менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон санхүүгийн чадамж, хэрэгцээг харгалзан үзлээ.

Төлөвлөгөөг боловсруулахдаа Алтайн өвөр говь, ГИДЦГ “А” хэсэгт хийсэн шинжлэх ухааны судалгаа, орон нутгийн талуудын санал үзэл бодолт суурилсан бодит мэдээлэл, баримтыг ашиглав.

Төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилго, зорилт, төлөвлөсөн үйл ажиллагаа нь хэрэгжихүйц, бодитой байх шаардлагыг хангаж, цаг үеийн хэрэгцээнд нийцүүлэх, аль болох орчин үеийн шинэлэг, дэвшилтэт технологи, арга зүйг ашигласан болно.

Төлөвлөлтийг хийхдээ **таван үе шатаар** холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэлбэрээр ажилласан бөгөөд эдгээрийг дараах байдлаар жагсаав. Үүнд:

1.Тодорхойлох

- 1.1. Төлөвлөлтийн зорилго тодорхойлох, ажлын багаа байгуулах
- 1.2. Хамрах хүрээ, алсын харааг тодорхойлох
- 1.3. Хамгаалах үнэт зүйлс, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох
- 1.4. Аюул, дарамтыг тодорхойлж үнэлэх
- 1.5. Хамгааллын менежментийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх

2.Төлөвлөх

- 2.1. Зорилго, стратеги, зорилт
- 2.2. Үйл ажиллагааны төлөвлөгөө
- 2.3. Мониторингийн төлөвлөгөө

3.Хэрэгжүүлэх

- 3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- 3.2. Хүний нөөцийн чадавхыг үнэлэх
- 3.3. Төсөв, санхүүжилтийг тооцох

4.Үр дүнг үнэлэх, уялдуулах

- 4.1. Мэдээ, баримт, өгөгдлүүдийг нэгтгэн цуглуулах
- 4.2. Үр дүнг шинжлэх, мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх
- 4.3. Төлөвлөгөөг сайжруулж чамбайруулах
- 4.4. Менежментийн төлөвлөгөөг сумын ИТХ-д өргөн барих

5.Үр дүнг хуваалцах

- 5.1. Үр дүн, амжилт, сургамжийг дүгнэх
- 5.2. Оролцогч талуудад мэдээлэл түгээх, санал солилцох

Менежментийн төлөвлөгөө боловсруулсан баг

Зармангийн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг Луужин Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН)-ийн баг боловсруулав. ЛАСН нь нь зэрлэг амьтан хамгаалах, шинжлэх ухааны судалгаа хийх, иргэдэд байгаль орчны мэдлэг мэдээлэл түгээдэг, ашгийн бус, төрийн бус байгууллага бөгөөд 200 жилийн түүхт Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг (ZSL)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас салбарлан 2020 онд үүсэн бий болсон, тус байгууллагын брэнд үйл ажиллагааг залгамжлан авч үргэлжлүүлж буй НҮТББ юм.

ЛАСН-ийн үндсэн **зорилго** бол зэрлэг амьтад, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, ан амьтдыг устахаас урьдчилан сэргийлэхэд **нутгийн иргэдийг дэмжих, мэдээлэл өгөх, чадавхжуулахад** оршино.

ЛАСН нь дараах таван чиглэлд **үйл ажиллагаа** явуулдаг. Үүнд:

1. Зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах
2. Нутгийн иргэдэд түшиглэсэн амьтан хамгааллыг дэмжих
3. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийг чадавхжуулах
4. Дундын хуримтлалын бүлгийг хөгжүүлэх
5. Эрэлч нохойг байгаль хамгаалахад ашиглахыг дэмжих

ЛАСН нь дараах **төслүүдийг** хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монголын Экологийн цагдаа: Дэлхийн жишгээр ажиллаж иргэдтэй түншлэх нь
- Их Говийн нүүдэлч малчдыг дэмжин хавтгай тэмээг хамгаалах төсөл
- Монголын Албаны нохойн салбарыг чадавхжуулах төсөл
- Баруун шаргын баянбүрдийн экологийн нөхөн сэргээлт хийх туршилтын төсөл
- Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай газрын менежментийг чадавхжуулах төсөл

Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ЛАСН-ийн багт дараах мэргэжилтнүүд ажилласан болно. Үүнд:

- У.Тунгалаг, Колорадогийн Улсын Их Сургуулийн Тал хээрийн экосистемийн шинжлэх ухааны доктор
- Р.Болор, Пинтуны Шинжлэх Ухаан Технологийн Үндэсний Их Сургуулийн Хөдөөгийн хөгжлийн магистр
- Б.Билгүүн, Монгол Улсын Их Сургуулийн Экологийн магистр
- Н.Мөнхтүвшин, Монгол Улсын Хүмүүнлэгийн Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр
- М.Мөнхзаяа, Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалавр
- П.Нямдаваа, Ховдын Их Сургуулийн Физик-байгалийн шинжлэлийн бакалавр
- У.Амартайван, Их Засаг Их Сургуулийн эрх зүйн бакалавр

II БҮЛЭГ: ЗАРМАНГИЙН ХООЛОЙ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Алсын хараа

Зармангийн хоолой ОНТХГ-ын алсын хараа бол Зармангийн говийн шүхэр зүйл - Хар сүүлтий болон бусад зэрлэг амьтан, тэдгээрийн амьдрах орчин болсон заган ой, амьдралыг тэтгэгч баянбүрд бүхий цөлийн хээрийн экосистемийг говийн нүүдэлч малчдын сайн сайхан амьдралын үндэс, төрөлх нутаг, уламжлал соёлын гал голомт хэмээн нутгийн иргэдийн идэвх зүтгэлээр хамгаалж, цэцэглүүлэх, үр хойчид нь өвлүүлэх явдал юм.

Хамрах хүрээ

Орон зайн хамрах хүрээ: Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөнд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутаг Зармангийн говьд баруун талдаа Бага Зарман, Цагаан хороотоос зүүн тийш Бага гол хүртэл Суман хадны нурууны хойгуурх нийт **118,460.58 га** талбай бүхий урт хоолой хамаарна (Зураг.8).



Зураг 8.Зармангийн хоолой Орон нутгийн тусгай хамгаалалттай газар

Хамрах үнэт зүйлс: Энэхүү төлөвлөгөө нь Зармангийн хоолой ОНТХГ орчим байрших дараах **таван үнэт зүйлийг** харилцан шүтэлцээтэй хамгаална. Үүнд:

1. Зармангийн баян бүрд, усны бусад эх үүсвэр
2. Хар сүүлтий
3. Цөлийн хээрийн бэлчээрийн экосистем
4. Заган ойн
5. Говийн нүүдэлчин малчид, өв уламжлал

Цаг хугацааны хамрах хүрээ: Зармангийн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг **2023-2027** онд нийт **дөрвөн жилийн** хугацаанд хэрэгжүүлнэ.

Хамгаалах үнэт зүйлс, сонгосон үндэслэл

Зармангийн хоолой ОНТХГ-ын хамгаалах үнэт зүйлсийг нутгийн иргэдийн саналд үндэслэн тодорхойлов (*График 33*). Үүнд Зармангийн хоолойн Элст хонхор, Хоолойн арын худаг, Шилийн сухай, Цагаан уул зэрэг дөрвөн газар намаржиж байсан 46 малчин, сумын төвд түр оршин сууж байсан 21 малчин болон Эрдэнэ сумын ЗДТГ-ын ажилтнууд, сумын Иргэдийн хурлын төлөөлөгчид зэрэг нийт 158 хүнийг оролцуулан эрэмбэлэх аргаар тодорхойлсон. Оролцогчдын саналаар төлөвлөгөөнд 5 үнэт зүйл оруулахаар болж хамгийн бага хувьтай байсан “мал сүрэг” хасагдсан болно.




График 33.Зармангийн хоолой ОНТХГ-т хамгаалах үнэт зүйлийг тодорхойлсон байдал

Зармангийн хоолой ОНТХГ-нд хамгаалах үнэт зүйлсийг тодорхойлсон нутгийн иргэдийн саналыг хураангуйлбал:

Булаг шанд, худаг ус: Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшлын улмаас хүр бороо багасаж, горим өөрчлөгдсөн, нөгөө төлөөс малын тоо өсөж усны хэрэгцээ ихэссэнээс мал, амьтан усны гачаалд

өртөх нь их болсон. Иймээс Зармангийн баянбүрдийг хамгаалах, түүний дэргэд дэх балгасыг цэвэрлэх, шинээр худаг ус гаргах шаардлагатай байна.

Зэрлэг амьтан, хар сүүлтий: Ахмад настнуудын бага залуу байх үетэй харьцуулахад зэрлэг амьтны тоо цөөрч, харагдац багассан, хулгайн ан буурсан ч мэр сэр агнаж байна. Хар сүүлтий нь Зармангийн хоолойн чимэг болсон амьтан тул түүнийг хамгаалах нь нэн чухал.

Говийн нүүдэлч малчдын өв уламжлал, хөгжил: Төв суурин газраас алслагдсан говийн малчид боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээнээс алслагдмал. Өв уламжлалаа хадгалах болон мал аж ахуй эрхлэх санхүүгийн суурь мэдлэг, мэдээлэл хомс учраас говийн нүүдэлчдийн өв соёл, уламжлал, байгаль орчны үнэ цэнийг ашиг орлогын дараа тавих хандлага гарч байна. Тиймээс хувь хүний хувь хөгжих, өв соёл, уламжлалаа сэргээх шаардлагатай.

Заг. Социализмын үед трос ашиглан заган ойг орвонгоор нь суг татаж сумын төвийн түлшний хэрэгцээг хангадаг байсан. Энэ хөнөөлт үйл ажиллагааны улмаас загийн тоо, хамрах талбайн хэмжээ маш их багассан. Сүүлийн жилүүдэд дулаарч, хур тунадас бага болохын хамт малын тоо ихсэж зулзаган заг идэх нь элбэгшсэн, мөн түлшинд үлэмж хэмжээгээр биш ч хэрэглэсээр байгаа нь загийн нөхөн сэргэлтэд муугаар нөлөөлж байна. Тиймээс говийн экосистемд чухал үүрэгтэй энэ ургамлыг хамгаалах нь маш чухал.

Бэлчээр. Бэлчээр бол нүүдэлч малчдын амьжиргааны хамгийн чухал нөөц төдийгүй зэрлэг амьтан, ургамлын оршин тогтнох үндэс. Тиймээс Зармангийн говийн бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хайрлан хамгаалах нь нэн чухал.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ


Зармангийн хоолойн газрын бүрхэвчийн өөрчлөлт

Газрын бүрхэвч нь гадаргын ерөнхий төрх байдлыг илэрхийлэгч физик хэмжигдэхүүн бөгөөд харьцангуй удаан хугацаанд өөрчлөгддөг боловч сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт болон хүний буруутай үйл ажиллагааны улмаас харьцангуй богино хугацаанд өөрчлөлдөх болсон. Иймээс байгаль орчны төлөв байдлыг зайнаас тандах аргаар судлах явдал нь үрт хугацааны, орон зайн өндөр нарийвчлалтай өөрчлөлтийг илрүүлдэг давуу талтай.

Зармангийн хоолой ОНТГ-ын газрын бүрхэвчийн өөрчлөлтийг тооцохдоо Улсын геодези, зураг зүйн газрын 1983 онд боловсруулсан 1:100000 масштабтай байр зүйн зургийг суурь болгон ашиглаж, Ландсат хиймэл дагуулын багана/мөр 136/29 2-н стацен багтах 2000 болон 2020 онуудын Лансат хиймэл дагуулын зургуудыг <https://earthexplorer.usgs.gov/> сайтаас татан авч, газрын бүрхэвчийн зураглалыг ENVI болон ARCGIS програмууд дээр гүйцэтгэв (Зураг.6).

Газрын бүрхэвчийн ангиллаар **уулын хээр** гэдэгт өндөр, дундаж, нам уулсын хээрийн бүсийн шилжих өндөрлөг хэсэг багтах бол, **хээрийн бүсэд** уулын хээрээс нам уул хоорондын хөндий, ухаа толгод, **хуурай хээрийн** бүсэд хээрийн бүсийг бодвол харьцангуй нам уулс, цав, толгод, талын ургамал багатай хэсэг, **цөлийн хээрт** байгалийн бүслүүрийн хувьд цөлжүү хээр болон заримдаг цөл, цөлийн бүслүүр багтдаг ба ургамлан бүрхэвч сийрэг. **Цөлийн бүсэд** ургамлан бүрхэвч бараг байхгүй, халцгай газар, шал, хуурай сайр багтдаг бол **элс** гэдэгт манхан элс хамруулан ойлгоно. **Нуурын** ангилалд нуур, тойром, ширгэдэг нуур, борооны дараа үүсдэг нуурыг авч үзнэ. **Нуга, голын хөндийд** нуга намгархаг газар, баянбүрд, голын татам, гол, горхийн үндсэн голдирол тус тус хамаарна.

Дээрх ангиллын дагуу Зармангийн хоолой ОНТХГ-ын газрын бүрхэвчийг зураглахад тухайн нутгийн газрын бүрхэвч ихээхэн өөрчлөгдөж **цөлийн хээрээс цөлийн бүслүүрт шилжих** явц ажиглагдаж, шинээр элсжилт болон элсний нүүлт хөдөлгөөний улмаас **2000 онд элстэй газар 7807 га талбай байсан бол 2020 онд 8685.1 га талбай болж нэмэгдсэн** байна. Мөн ургамалгүй нүцгэрсэн газар **2000 онд 29243.5 га талбай байсан бол 2020 онд 33319.2 га талбай болж тэлсэн** байна. Ургамалгүй нүцгэрсэн газрын талбай, хуурай сайрын эзлэх талбайн даруй **4111.6 га-аар нэмэгдсэн** байна. Нуга, намагтай газар **2000 онд 3944.4 га талбай байсан бол 2020 онд 2427.3 га талбай болж буурсан** байна. Мөн 1983 оны 1: 100000 масштабтай байр зүйн зурагт тэмдэглэгдсэн **Овоон нуур хатаж ширгэжээ** (Зураг.9).



Зураг 9. Зармангийн хоолой орчмын газрын бүрхэвчийн 2000 болон 2020 онуудын Лансат хиймэл дагуулын зураг





График 34. Зармангийн хоолой орчмын 2010 болон 2019 оны газрын бүрхэвчийн ангиллын эзлэх хувь

Зармангийн баянбүрд нь тухайн орчны экосистемийг тэнцвэржүүлдэг амин чухал бүрэлдэхүүн. Гэвч тэнд нуга, намгийн эзлэх талбай багасан элсжиж, бэлчээрийн талхагдал эрчимтэй явагдаж байна. Тиймээс Зармангийн баян бүрд орчмын уст цэгүүдийн эхийг хашиж хамгаалах, элсний нүүдлийг сааруулах, айл болон малын дарамтыг бууруулах, аль болох нэмэхгүй байх талаар нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай байна (Зураг.10).



Зураг 10. Газрын бүрхэвчийн өөрчлөлт гарсан газрууд

Зармагийн хоолой ОНТХГ-ын хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн төлөв байдлыг дараах хэсэгт үзүүлэв.

Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн төлөв байдал

Амьтны аймаг

Зармангийн хоолой ОНТХГ нь амьтны аймгийн газар зүйн мужлалаар Алтайн Өвөр говийн цөлийн мужид багтдаг. Энэ мужид нийтдээ 5 ангийн 221 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 33.9 хувь нь оршин амьдардаг. Үүнээс гадна Зармангийн хоолойд талархаг хээр, заримдаг цөлийн экосистемд дасан зохицсон мэрэгч хөхтөн амьтад элбэг тохиолдоно. Том хөхтөн амьтдаас Цоохор ирвэс, Хавтгай, Хар сүүлтий, Аргаль, Янгир, Өөхөн- сүүлт атигдаахай, Таван-хуруут атигдаахай зэрэг нь Монгол улсын улаан номонд орсон байна. Чоно, мануул, ирвэс, аргаль, янгир нь Зэрлэг Амьтан Ургамлын Ховордсон Зүйлийг Олон Улсын Хэмжээнд Худалдаалах тухай Конвенц (CITES)-ийн II хавсралтад бүртгэгдсэн байдаг. Ховор амьтны

2012 оны жагсаалтад хавтгай, аргаль, янгир, хар сүүлтий, ирвэс нь орсон бол Монгол орны хөхтөн амьтдын Улаан дансанд чоно, шар үнэг, хярс, мануул “Ховордож болзошгүй”, аргаль, ирвэс "Устаж болзошгүй", сибирь малтаахай, өөхөн - сүүлт атигдаахай, таван - хуруут атигдаахай, говийн алагдаага, Соколовын шишүүхэй гэсэн зүйлүүд "Мэдээлэл дутмаг", хар сүүлтий “Эмзэг” гэсэн ангилалд орсон байна. Зармангийн ОНТХГ-ын шүхэр зүйл – Хар сүүлтийн бэлчээр нутаг сэлгэн нүүдэллэхэд Зармангийн баянбүрд чухал амьдрах орчин болдог.

Зармагийн хоолой ОНТХГ-ын амьтад болон тэнд тохиолдлоор бүртгэгдсэн ховор амьтдын тоо толгой хомсдох шалтгаан, экосистемийн ач холбогдол, эдийн засгийн үнэлгээг дараах хэсэгт оруулав. .

Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*)

Баг:	Туруутан (Artiodactyla)	
Овог:	Тугалмайтан (Bovidae)	
Латин нэр:	<i>Gazella subgutturosa</i>	
Англи нэр:	Black-tailed Gazelle	
IUCN-н статус	Олон улс	Эмзэг
	Бүс нутаг	Эмзэг
Улаан номны статус	Ховор	
CITES апп.	Байхгүй	



Экосистемийн ач холбогдол: Хар сүүлт зээр нь говийн экосистемд идэш тэжээлийн эргэлтэд чухал байр суурийг эзэлдэг. Амьдралын онцлог нь бэлчээрийн сорыг даган нүүдэллэх зан төрхтэй. Энэ цаашлаад бэлчээрийн эрүүл байдал, талхагдлыг үнэлэх чухал индикатор зүйл болно.

Тоо толгойн хомсдох шалтгаан: Говь цөлийн задгай ус, бэлчээрийн ашиглалт эрчимжин, булаг шандыг хүн, мал байнга эзэгнэх болсноос байршил нутгаасаа дайжих явдал их гарч байна. Тээврийн хэрэгслээр хөөж, гэрэлтүүлэн агнах, байршин идээшсэн нутгаас хөөж дайжуулснаас тоо толгой хорогдон багасаж байна. 1960-аад оноос мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч говь цөлийн задгай ус, баян бүрдүүдийг эзэмших, зэлүүд бэлчээрийг усжуулан эзэгнэх, хүнсний ногоо тарих, машин техник олшрох, задгай усны дэргэд суурьших явдал ихэссэн зэрэг нь хар сүүлтийг идээшин дассан бэлчээр уснаас шахан дайжуулах шалтгаан болсон. Байгаль дарь гол дайсан нь чоно, шилүүс, бүргэд. Тас нялх янзагыг барьдаг. Зуданд түрж, осгон олноор үхнэ. Дээр үеэс их хэмжээгээр хууль бусаар агнаж, сүргийн бүтцийг алдуулснаас зарим нутагт устаж, тархац нутаг алаг цоог болоод байна.

Бүс нутгийн тархац: Уудам тархацтай боловч нягтшил нь бага байдаг. Одоо Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Дорнод говь, Алашань говьд тархсан (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Амгалан, 1984, 1986; Lkhagvasuren нар, 1999). Захуй, Зармангийн говиор хийгдсэн 2020 оны туруутан амьтдын судалгаагаар 1350 бодгаль бүртгэгдсэн байна.



Экологи эдийн засгийн үнэлгээ: Монгол улсад хар сүүлт зээр агнахыг 1995 оноос хуулиар хориглосон бөгөөд Монгол орны хөхтөн амьтны Улаан дансанд ховор амьтны зэрэглэлээр бүртгэж, хуулиар хамгаалсан. Хар сүүлтийн экологи эдийн засгийн үнэлгээгээр эр нь 1,700,000 төгрөг, эм нь 2,000,000 төгрөг, төл амьтны экологи эдийн засгийн үнэлгээг бие гүйцсэн бодгалийн экологи эдийн засгийн үнэлгээний 30 хувиар тооцож тогтоодог. Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад ан амьтны толгой тутамд экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар тооцдог.

Монгол бах (*Bufo raddei*)

Баг:	Сүүлгүй хоёр нутагтан (Anura)	
Овог:	Бах (Bufonidae)	
Латин нэр:	Strauchbufo raddei (Bufo raddei)	
Англи нэр:	Mongolian Toad	
IUCN-н статус	Олон улс	Анхааралд өртөхөөргүй
	Бүс нутаг	Анхааралд өртөхөөргүй
Улаан номны статус	Байхгүй	
CITES app.	Байхгүй	



Хамгаалсан байдал: Энэ зүйл бахын Монгол дахь тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (UNEP-WCMC, 2006).

Бүс нутгийн тархац: Монгол орны хамгийн түгээмэл тархалттай бах (Тэрбиш нар, 2006). Тархалтын ерөнхий төлөв байдлаас үзвэл тус орны говь цөл, тал хээр, ойт хээрийн бүсийн гол, нуур, булаг шанд, баянбүрд зэрэг ус, намгархаг газруудыг шүтэн амьдарна (Terbish нар, 2006). Монгол бах Нууруудын хөндийн баруун умард хэсэг, Бигэр нуурын хотгороос зүүн тийш Их Хянганы уулс, Монгол орны умард нутгаас өмнө зүг Алтайн өвөр говь хүртэл өргөн уудам нутагт тархсан бөгөөд хэд хэдэн хязгаарлагдмал популяци бий. Энэ зүйл Их нуурын хотгор, Хангайн нурууны баруун хэсэг, Хөвсгөлийн уулс, Зүүнгарын говь зэрэг нутгаас харахан олдоогүй (Тэрбиш, 1989; Боркин нар, 1988). Монгол оронд тэнгисийн төвшнөөс дээш 500-3800 метрт тохиолдоно (Банников, 1958; Боркин нар, 1986; Боркин нар, 1988). Энэ зүйл Монгол оронд нийт 842,920 км² талбайд тархсан гэж үнэлсэн.



Ховордлын шалтгаан: Монгол бах олон янзын амьдрах орчинд өргөн тархацтай тул ховордуулах шалтгаан мөн л олон янз байдаг. Тухайлбал амьдрах орчны доройтол, усны бохирдол, байгалийн нөөцийн олборлолт (уул уурхай), гол нуур, булаг шандын татралт, ширгэлт зэрэг олон шалтгаанаас тоо толгой нь хомсдон, ховордох магадлалтай (Х. Тэрбиш, Л.Боркин нар, аман мэдээ). Хэдий тийм ч дээрх шалтгаанууд одоогоор энэ зүйлийг ховордуулах хэмжээнд хүрээгүй гэж үзэж байна (Х. Тэрбиш, Л.Боркин нар, аман мэдээ).

Янгир (*Capra sibirica*)

Баг:	Туруутан (Artiodactyla)	
Овог:	Тугалмайтан (Bovidae)	
Латин нэр:	<i>Capra sibirica</i>	
Англи нэр:	Siberian Ibex	
IUCN-н статус	Олон улс	Анхааралд өртөхөөргүй
	Бүс нутаг	Ховордож болзошгүй
Улаан номны статус	Ховор	
CITES app.	Байхгүй	



Хамгаалсан байдал: Монгол улсын амьтны аймгийн тухай 2000 оны хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2001 (№ 264) онд гарсан Засгийн газрын тогтоолоор ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005), Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор амьтны жагсаалтад оруулсан (БОЯ, 1996). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Янгирын тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газар орсон.

Бүс нутгийн тархац: Говь алтайн баруун өмнөд болон зүүн хэсэг, Хангайн нуруу, болон зүүн хэсгийн нутагт тасархайтсан популяциуд байдаг ч одоогоор энэ зүйл нь Умард говийн зүүн хэсгээс олдсон бөгөөд Алашань говийн Хүрх уул ба Алтайн өвөр говийн хадархаг уулсаар тархсан (Mallon нар, 1997). Хэнтий нуруунд, Дархан цаазат Богд Хан ууланд 1980 –аад онд жижиг популяци нутагшуулах ажиллагааг амжилттай хэрэгжүүлжээ. Энэ зүйл нь Их нартын чулуу байгалийн нөөц газрын хойд хэсэгт саяхан тэмдэглэгдсэн (Reading нар, 2006). *C. s. hagenbecki* салбар зүйл нь Алтайн өвөр новь, Говь Алтайн нуруугаар тархсан, *C. s. sibirica* салбар зүйл нь үндсэн тархцын хойд хэсгээр Монгол Алтайн нурууны хойд хэсгээр тархсан (Fedosenko, Blank, 2001).



Ховордлын шалтгаан: Бүс нутагт мах болон арьсыг худалдаалах, гадаадын анчдад агнуулдаг явдал болон хууль бус болон хяналтгүй ангах нь хорогдлын гол шалтгаан болсоор байна. Зарим нутаг малын тоо толгой өсөж бэлчээрийн талхагдал бий болсноор орчны доройтол үүсэж ус, бэлчээр байршил нутгаар хавчигдаж, малтай өрсөлдөх болсон. Байгалийн нөөцийн олборлолт (уул уурхай) ихэссэнээс амьдрах орчин нь хомсдол, доройтолд орсон. Зүд түрхантай өвөл, цаг уурын нөхцөлүүд популяцид нэлээд хохирол учруулж байна.

Экологи эдийн засгийн үнэлгээ: Эр бодгалийг үнэлгээ 2,700,000 төгрөг, эм бодгалийн үнэлгээ 3,100,000 төгрөг байна. Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад ан амьтны толгой тутамд экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар тооцдог. Монгол улсын засгийн газраас тогтоосон ан агнах зөвшөөрлийн үнэлгээг Алтайн янгирт 800 ам. Доллар, Говийн янгирт 720 ам. доллароор тус тус тогтоосон байдаг.

Аргаль хонь (*Ovis ammon*)

Баг:	Туруутан (<i>Artiodactyla</i>)	
Овог:	Тугалмайтан (<i>Bovidae</i>)	
Латин нэр:	<i>Ovis ammon</i> (<i>Ovis altaica</i>)	
Англи нэр:	Argali sheep	
IUCN-н статус	Олон улс	Эмзэг
	Бүс нутаг	Устаж болзошгүй
Улаан номны статус	Ховор	
CITES апп.	II	



Хамгаалсан байдал: Монгол улсын амьтны аймгийн тухай хуульд (2000) өөрчлөлт оруулж (2001) (Засгийн газрын тогтоол №264) ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Агнахыг 1953 оноос хойш хуулиар хориглосон. Монгол Улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтад орсон (БОЯ, 1996). CITES-ийн II хавсралтад орсон. Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монгол улсын улаан номд ховор зэрэглэлээр орсон (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Аргаль хонины тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагддаг.

Бүс нутгийн тархац: Монгол орны зүүн хэсгээс бусад нутгаар тасархайтсан байдлаар тэгш өндөрлөгүүд, хадан цохио, уулс, дов толгодоор тааралддаг байсан (Mallon нар, 1997; Amgalanbaatar, Reading, 2000; Amgalanbaatar нар, 2002). Одоогоор энэ зүйл говийн бүсийн умард хэсгээс хээр, ойт хээр, уулын тайгын өмнөд хэсэг хүртэлх Монгол Алтай, Говийн Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Алашань говь, Дорнод говийн бэсрэг уулсаар тархсан (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Fedosenko, Blank, 2005). Мөн төв халхын зарим уулс, Хан хөхийн нуруу, Хангайн нуруу, Хөвсгөлийн Арсайн гол орчим тасархайтсан популяциуд бий (Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов 1980; Reading нар, 1997; Reading, 2000; Адъяа, Төмөрсүх, 2001; Amgalanbaatar нар, 2002; Fedosenko, Blank, 2005).



Ховордлын шалтгаан: Хууль бус агнуур, эврийн төлөөх гадаадын анчдын тогтвортой бус (тооцоонд үндэслээгүй) агнуур энэ зүйлийн ховордлын гол шалтгаан болж байна (Амгаланбаатар нар, 2002). Түүний ховордлын зэргийг үл тоомсорлосноос угалзын олзвор агнуурын зөвшөөрлийн тоо өссөөр байгаа (Zahler нар, 2004) бөгөөд ШУА-аас тогтоосон хэмжээнээс даваад байна (Zahler нар, 2004; Wingard, Zahler, 2006). Хууль бус агнуурын ихэнх хувийг нохойтой агналт эзэлж байна (Reading нар, 2003; 2005). Жил дараалсан ган, зудаас болж аргаль ихээр хорогдож байна. Мөн малын тоо толгой өссөнөөр бэлчээр нутаг нь хумигдаж, талхлагдаж буй нь ховордлын шалтгааны нэг болж байна. Байгалийн нөөцийн олборлолтын (уул уурхай) үйл ажиллагаа ихэссэнээс орчны хомсдол бий болж байгаа бөгөөд эдгээр нь аргаль хонинд ямар нөлөө үзүүлж байгааг нарийвчлан судлах шаардлагатай (Reading нар, 1997; 2003; 2005; Wingard, 2005).

Экологи эдийн засгийн үнэлгээ: Аргаль хонины эр нь 11,000,000 төгрөг, эм нь 13,200,000 төгрөг. Мөн соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад эр аргаль 2,200,000 төгрөг, эм аргаль 2,600,000 төгрөг байна.

Хавтгай тэмээ (*Camelus ferus*)

Баг:	Туруутан (Artiodactyla)	
Овог:	Тэмээ (Camelidae)	
Латин нэр:	Camelus ferus (Camelus bactrianus ferus)	
Англи нэр:	Wild Bactrian Camel	
IUCN-н статус	Олон улс	Устаж байгаа
	Бүс нутаг	Устаж болзошгүй
Улаан номны статус	Нэн ховор	
CITES app.	Байхгүй	



Хамгаалсан байдал: Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн (2000) 7.1-д нэн ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Хавтгай тэмээг агнахыг 1930 оноос хуулиар хориглосон бөгөөд ан агнуурын тухай 1995 оны хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтад оруулсан (БОЯ, 1996). Монгол улсын улаан номд нэн ховор зэрэглэлээр тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Нүүдэллэдэг зүйлийн конвенцид нүүдэг зүйл гэж тэмдэглэсэн. Хавтгай тэмээний тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газарт орсон.

Бүс нутгийн тархац: Хавтгай тэмээ Төв, Дунд Азийн говь цөлд түгээмэл дэлгэр тархацтай байжээ. Хятадын Лоб нуураас умард, дорно зүгт Ачикийн хөндий, Аржин шан уул, түүний умард залгаа аараг толгодын дагуу тархдаг. Хавтгай тэмээний Монгол дахь үндсэн тархац нутаг Алтайн өвөр говь, ГИДЦГ-ын А хэсгийн 44000 км² нутгийн ихэнх хэсэгт буюу 30000-35000 км² нутгийг бүрэн хамран байршдаг. Тохиолдлоор ихэвчлэн өвлийн улиралд цөөн тооны бодгалиуд Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь сумын урьд говь, Өмнөговь аймгийн Гурвантэс, Нэмэгтийн хоолой, Ингэн хөөврийн хоолой, Сэрвэй сумын урьд говиор тохиолдоно.



Ховордлын шалтгаан: Гэрийн тэмээтэй эрлийзжих нь ховордох гол шалтгаан болж байна. Эрлийзжилт ямар түвшинд байгаа нь тодорхойгүй байгаа ч малчдын тэмээ хавтгайтай эвцэлд ордог талаар тодорхой мэдээлэл байдаг (R. Reading, аман мэдээ). Гэрийн тэмээ нь ГИДЦГ-ын А хэсгийн нутагт нэвтэрч буй үзэгдэл олон удаа тохиолдож байгаа нь халдварт өвчин тархах, эрлийзжих боломжийг бүрдүүлж болох юм (Walzer, Kaczensky, 2005). Байгалийн нөөцийн олборлолт, хүний сөрөг нөлөөлөл, орчны хомсдол зэрэг нь хойшид хавтгай тэмээнд нөлөөлөх боломжтой (J. Hare, аман мэдээ). Алтны уурхайд төмрийн хүдрийг ялгахад циант калийг ашигласнаас усны нөөцийг нь циантаар бохирдуулж байна (Hare, 2006). Хятад, Монголын хилийн дагуух торон хашаа хавтгайн нүүдэл, хөдөлгөөнд саад болж улмаар Хятадын популяцитай генийн солилцоонд орох байдлыг тусгаарлаж байна. Баянбүрдүүд байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагаанаас болж хуурайшиж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Мөн байгалийн

давтамжаар уст цэгүүд цөөрч байгаа эсэх нь тодорхойгүй байна (R. Reading, аман мэдээ). Хавтгайн ботго руу чоно халддаг нь жижиг популяцийг бууруулах шалтгаан гэж үздэг (M6 Stubbe, аман мэдээ).

Экологи эдийн засгийн үнэлгээ: Эр хавтгай 19,000,000 төгрөг, эм нь 21,300,000 төгрөгөөр үнэлэгдэнэ. Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад ан амьтны толгой тутамд экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар тооцдог.

Мазаалай баавгай (*Ursus arctos gobiensis*)

Баг:	Мах идэштэн (Carnivora)	
Овог:	Баавгай (Ursidae)	
Латин нэр:	Ursus arctos gobiensis (Ursus gobiensis)	
Англи нэр:	Gobi bear	
IUCN-н статус	Олон улс	Устаж байгаа
	Бүс нутаг	Устаж байгаа
Улаан номны статус	Нэн ховор, үлдвэр зүйл	
CITES app.	Байхгүй	



Хамгаалсан байдал: CITES-ийн I хавсралтад орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуульд (2007) 7.1-т нэн ховор зүйл гэж хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай хуулиар 1953 оноос хойш агнахыг хориглосон бөгөөд 1995 оны хуулиар нэн ховор зүйлийн жагсалтад орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987, Шийрэвдамба нар, 1997). Энэ зүйлийн тархац нутгийн 82 орчим хувь нь ГИДЦГ-ын А хэсэгт хамаардаг.

Бүс нутгийн тархац: Мазаалай баавгайн тархац нутаг нь Алтайн өвөр говиос зүүн тийш Тост уул (Банников, 1954) хүрч байсан хэдий ч одоо Алтайн өвөр говийн өмнөд хэсгээр Атас богд, Шар хулс, Цагаан богд уулсын баянбүрдээр хязгаарлагдмал тархсан (McCarthy, 1999). Хааяа (тархцын зураг тусгагдаагүй) Говь гурван сайхан байгалийн цогцолборт газарт орж ирсэн (Нэмэгт болон орчмын нутаг) мал руу дайрсан тохиолдол гарсан. (R. Reading, аман мэдээ).



Ховордлын шалтгаан: Орчны өөрчлөлт, халдварт өвчин мэтийн биотик хүчин зүйлүүдэд эмзэг мазаалай баавгайд жижиг популяцид байдаг олон сөрөг нөлөө (имбридинг, үржлийн эрчим бага гэх мэт) тохиолддог. Тархац нутгийн хэмжээнд популяци хоорондын тусгаарлалтын түвшин болон генетик солилцооны талаар бага судлагдсан популяци улам багасах төлөвтэй байна (McCarthy, 1999). Хүний үйл ажиллагаа мазаалай баавгайн ховордох шалтгааны нэг болж байна (McCarthy, 1999). Мөн жил дараалсан ган, хуурайшилт, баянбүрдийн ус ширгэж байгаа зэрэг нь энэ зүйлийг ховордуулах шалтгаан хэдий ч байгаль орчны өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны аль нь их нөлөөлж байгааг хараахан тогтоогүй байна. ГИДЦГ хийсэн мониторинг судалгаагаар 1992 оноос

хойш ган гачиг болж, жилийн хур тунадас нь 100 мм-ээс 50 мм хүртэл буурсан байна (Мижиддорж, 2006; Н. Reynolds, аман мэдээ).

Экологи эдийн засгийн үнэлгээ: Мазаалайн баавгайн эр нь 19,000,000 төгрөг, эм нь 22,000,000 төгрөгөөр үнэлэгдэнэ. Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад ан амьтны толгой тутамд экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар тооцдог.

Баг:	Мах идэштэн (Carnivora)	
Овог:	Мий (Felidae)	
Латин нэр:	Uncia uncia (Panthera uncia, Uncia irbis)	
Англи нэр:	Snow Leopard	
IUCN-н статус	Олон улс	Устаж болзошгүй
	Бүс нутаг	Устаж болзошгүй
Улаан номны статус	Нэн ховор	
CITES App.	I	



Цоохор ирвэс (*Uncia uncia*)

Хамгаалсан байдал: CITES-ийн I хавсралтад орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн 7.1-д (2000) нэн ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Ариунзүл, 2005). 1972 оноос хойш агнахыг хуулиар хориглосон, 1995 оны ан агнуурын тухай хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтад оруулсан (БОЯ,1996). Монгол улсын улаан номонд ховор зүйл зэрэглэлээр бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Тархац нутгийн 18 орчим хувь (McCarthy, Charpon, 2003) нь улсын тусгай хамгаалалттай 10 газрын нутаг дэвсгэрт ордог (McCarthy 2000).

Бүс нутгийн тархац: Энэ зүйл тархцынхаа бүх нутагт ховор (McCarthy, 2000). Монгол дахь ирвэсийн нийт тархцын талбайг 103,000 км² гэж тооцоолсон. Алтайн өвөр говийн төв хэсэг, Говь-Алтайн хойд хэсгээр нягтшил ихтэй байдаг. Хөвсгөл болон Хангайн нуруунд тохиолдох боловч энэхүү байршилд тогтмол тааралдах нь ховор, харин 1960-аад онд үзэгдэж байсан (McCarthy, Charpon, 2003). Монгол дахь ирвэсийн тархалт нь гол идэш болох янгир (*Capra sibirica*), аргаль хонины (*Ovis ammon*) тархацтай нягт холбоотой (Мүнхцог, 2006).



Ховордлын шалтгаан: Арьс болон ясыг Хятадын ардын эмнэлэгт барын ясны оронд ашиглах зорилгоор хууль бусаар агнадаг. Мөн махыг нь эмийн түүхий эд болгодог. Монгол, Хятадад худалдаалагддаг ирвэсийн арьсны метр тутам нь 250-аас их ам. доллараар үнэлэгддэг байна. Түруутан амьтад ховордсоноос идэш тэжээлийн хомсдолд орсон нь ховордох шалтгаан болдог. Зарим нутагт гэрийн мал руу дайрдаг учраас санаатай агнадаг.

Экологи-эдийн засгийн үнэлгээ: Эр ирвэс 11,200,000 төгрөг, эм нь 13,000,000 төгрөгөөр үнэлэгдэнэ. Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад ан амьтны толгой тутамд экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар тооцдог.

Зармангийн хоолой ОНТХГ-ын өнөөгийн төлөв байдлын үнэлгээ

Объект	~(Source)	Амьдрах чадварын загвар	Статус	~(Future Status)	Төрөл	Муу	дунд	Сайн	Маш сайн	Ахиц
Баянбүрд		Чухал Хүчин Зүйл	дунд	дунд						
Усны ундарга			дунд	дунд	Хэмжээ					
Урсагийн хэмжээ	Тойм		дунд	дунд		Усгүй ширгэх, ...	Урсах нь бага, ...	Урсгал нь арай...	Урсгал түргэн, ...	Тодорхой та...
2022-11-10: Урсах н	Тойм		дунд	дунд			Урсах нь баг...	Урсгал нь ар...		
Усны хуралцаа			дунд	дунд	Хэмжээ					
Малын тоогоор	Тойм		дунд	дунд		100 мал	500-2500 мал	3000 - 4000 мал	4000 мал <	Тодорхой та...
2022-11-10: 500-250	Тойм		дунд	дунд			500-2500 мал	3000-4000 мал		
Бэлчээрийн экосистем		Чухал Хүчин Зүйл	дунд	дунд						
Ургамлын бүрхэц			дунд	дунд	Хэмжээ					
Бүрхэцийн талбайн ху	Тойм		дунд	дунд		0%	20-50%	50-80%	80-100%	Тодорхой та...
2022-11-10: 20-50%	Тойм		дунд	дунд			20-50%	50-80%		
Ургамлын гарц			дунд	дунд	Хэмжээ					
Ургамлын өндөр	Тойм		дунд	дунд		0см	6-8см	8-15см	20см<	Тодорхой та...
2022-11-10: 6-8см	Тойм		дунд	дунд			6-8см	8-15см		
Ургамлын зүйлийн бүрдэл			дунд	дунд	Хэмжээ					
Зүйлийн тоо	Тойм		дунд	дунд		2-3 зүйл	5-8 зүйл	8-10 зүйл	10< зүйл	Тодорхой та...
2022-11-10: 5-8 зүйл	Тойм		дунд	дунд			5-8 зүйл	8-10 зүйл		
Говийн нүүдэлчдийн хөгжил		Чухал Хүчин Зүйл	дунд	Сайн						
Байгаль хамгаалагд оролцо			Муу	дунд	Тодорхой					
Оролцоо	Тойм		Муу	дунд		Муу	Дундаж	Сайн	Маш сайн	Тодорхой та...
Шуурхай	Шуурхай									
Эрүүл мэндийн үйлчилгээ			дунд	Сайн	Хэмжээ					
Үйлчилгээний давтам	Тойм		дунд	Сайн		Огт үйлчилгээ ...	Улиралд 1 удаа	Улиралд 2 удаа	Сард нэг удаа	Тодорхой та...
2022-11-10: Улиралд	Тойм		дунд	Сайн			Улиралд 1 у...	Улиралд 2 у...		
Эв соёл			дунд	Сайн	Төлөв байдал					
Хандлага	Тойм		дунд	Сайн		Мотоцикл унаж...	Морь, мотоцик...	Хааяа нэг мото...	Тэмээ, мориор ...	Тодорхой та...
2022-11-10: Морь, м	Тойм		дунд	Сайн			Морь, мотоци...	Хааяа нэг м...		
Заг		Чухал Хүчин Зүйл	дунд	дунд						
Бүрхэвч			дунд	дунд	Тодорхой					
Тархац	Тойм		дунд	дунд		0-30%	30%	30-50%	50%<	Тодорхой та...
2022-11-10: 30%	Тойм		дунд	дунд			30%	30-50%		
Загийн гарц			дунд	дунд	Тодорхой					
Загийн өндөр	Тойм		дунд	дунд		100см>	100-120см	120-160см	170-200см	Тодорхой та...
2022-11-10: 100-120	Тойм		дунд	дунд			100-120см	120-160см		
Нягтшил			дунд	дунд	Хэмжээ					
Заг хоорондын зай	Тойм		дунд	дунд		Армаг, тармаг	Гүн харгана, ...	Өтгөн гэхдээ тэ...	Ачаатай тэмээ ...	Тодорхой та...
2022-11-10: Гүн хар	Тойм		дунд	дунд			Гүн харгада...	Өтгөн гэхдээ...		
Хар сүүлтэй		Чухал Хүчин Зүйл	дунд	дунд						
Популяцийн тоо			дунд	дунд	Хэмжээ					
Бодгалийн тоо толгой	Тойм		дунд	дунд		0	30-40	40-60	70-80	Тодорхой та...
2022-11-08: 30-40	Тойм		дунд	дунд			30-40			
Тархац			дунд	дунд	Хэмжээ					
Тархац талбайн хувь	Тойм		дунд	дунд		0%	20%	40%	40%<	Тодорхой та...
2022-11-10: 20%	Тойм		дунд	дунд			20%	40%		

Хүснэгт 7. Хамгаалах үнэт зүйлсийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээ

Үнэт зүйлсэд учирч буй аюул дарамтын үнэлгээ

Зармангийн хоолой ОНТХГ-нд хамгаалахаар сонгон авсан үнэт зүйлүүдэд учирч буй аюул, дарамт тус бүрт нутгийн малчдын оролцоотой үнэлгээ хийж үзэхэд хамгийн их тулгамдаж буй асуудал нь бэлчээрийн доройтол “**маш өндөр**” гэж үнэлэгджээ. Үүний дараах “**өндөр**” дарамтыг үзүүлж буй асуудал нь малаас дамжих халдварт өвчин, малын дарамт бэлчээрийн даац хэтрэлт байна. Харин үнэлгээгээр “**дундаж**” болон “**бага**” нөлөөтэй гэж тодорхойлсон дарамтууд нь загийн зохисгүй хэрэглээ, малаас хэт хамааралтай эдийн засаг, боловсролыг тэгш хүртээмж зэрэг орж байв (Хүснэгт 8).

Байгалийг унаган төрхөөр нь хадгалан авч үлдэхэд хүний хөгжил чухал нөлөөтэй. Тиймээс энэхүү менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эн тэргүүнд Зармангийн хоолойд нутагладаг малчдын

Аюул заналууд \ Хамгаалах зүйлс	Заг	Говийн нүүдэлчдийн хөгжил, өв уламжлал	Баянбурд	Хар сүүлтий	Бэлчээрийн экосистем	Аюул заналын үнэлгээний дүгнэлт
Хулгайн ан				бага		бага
Өвчин халдвар				Өндөр		Дундаж
Идэш тэжээлийн хомсдол				Маш өндөр	Маш өндөр	Маш өндөр
Махчлал				бага		бага
Усмы дутагдал			Дундаж	Дундаж	Дундаж	Дундаж
Малын дарамт, бэлчээрийн гаац хэтрэх	Өндөр	Дундаж	Өндөр	Өндөр	Өндөр	Өндөр
Түшмэл хэрэглэх	бага					бага
Боловсрох мэргэшэх боломжгүй		бага		бага	бага	бага
Малаас хэт хамааралтай		Дундаж				бага
Хамгаалах зүйлийн үнэлгээний дүгнэлт:	Дундаж	Дундаж	Дундаж	Өндөр	Өндөр	Нийт Төсөлт Үнэлгээ

Хүснэгт 8. Үнэт зүйлсэд учирч буй аюул дарамтын үнэлгээ

сайн сайхан байдал, боловсрол, байгальд хандах хандлагад өөрчлөлт авчрах үйл ажиллагааг чухалчлах нь зүйтэй. Зармангийн хоолойн ОНТХГ-нд сонгож авсан үнэт зүйл учирч буй нийт аюул дарамт **ӨНДӨР** хэмээн үнэлэгдсэн нь цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ урт хугацаанд өөрчлөлт гарахыг харуулж байна.

Зармангийн хоолойн малчдын байгаль орчны хандлага

Байгалийн нөөц, доройтол, хамгааллын талаарх малчдын хандлага, ойлголт

Зэрлэг амьтдын төлөв байдал

Нутгийн иргэдийн үзэж байгаагаар Зармангийн ОНТХГ-ын зэрлэг амьтны тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд муудсан буюу доройтсон (76.1%) байна. Харин 19.6% хувь нь амьтдын тоо толгойд өөрчлөлт гараагүй, 4.3% нь сайжирсан гэжээ (Хүснэгт.9).

№	Өөрчлөлт	Сайжирсан буюу доройтсон байдлын түвшин				Нийт
		Их	Дунд	Бага	NA	
1	Сайжирсан	0.0%	2.2%	2.2%	0.0%	4.3%
2	Муудсан буюу доройтсон	8.7%	54.3%	13.0%	0.0%	76.1%
3	Өөрчлөлтгүй	0.0%	0.0%	0.0%	19.6%	19.6%
	Нийт					100.0%

Хүснэгт 9. Зэрлэг амьтны тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=46

Тэднээс Зармангийн говь болон Эдрэнгийн нурууны шүхэр зүйл зүйл болох Хар сүүлтий (*Gazella subgutturosa*) болон Янгир (*Capra sibirica*), Цоохор ирвэс (*Uncia uncia*), Чоно (*Canis lupus*), Шилүүс (*Lynx lynx*) гэсэн 5 зүйл амьтны харагдац, харсан давтамж, харагдаж буй байршлыг тодруулахад хамгийн их харагдац сайтай нь Хар сүүлтий, Янгир бол хамгийн харагдац муу нь Цоохор ирвэс, Шилүүс байна. Хар сүүлтий болон янгирог нутгийн малчид олон газар харсан бол бусад амьтдыг тодорхой нэг байршилд харсан байна. Үүнд:

Хар сүүлт зээрийн тухайд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 95.7% нь харсан, 4.3% нь хараагүй гэжээ. Харсан иргэдээс давтамжийг тодруулахад 13.6% нь жилд нэг удаа, 43.2% нь заримдаа (4-11 удаа), 40.9% нь ойр ойрхон буюу жилдээ 12-оос олон удаа харсан байна (График35).

Янгирын тухайд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 62.2% нь харсан, 37.8% нь хараагүй гэжээ. Харсан иргэдээс давтамжийг тодруулахад 60.7% нь жилд нэг удаа, 28.6% нь заримдаа (4-11 удаа), 10.7% нь ойр ойрхон буюу жилдээ 12-оос олон удаа харсан байна (График36).




График 35. Хар сүүлт харсан давтамж, N=44




График 36. Янгир харсан давтамж, N=44

Ирвэсийн тухайд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 13.3% нь буюу 6 иргэн харсан, үлдсэн 40 иргэн буюу 86.7% нь хараагүй гэжээ. Харсан иргэдээс давтамжийг тодруулахад бүгд жилд нэг удаа харсан гэсэн байна (График37).

Чонын тухайд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 50% нь харсан, 50% нь хараагүй гэжээ. Харсан иргэдээс давтамжийг тодруулахад 73.9% нь жилд нэг удаа, 13% нь заримдаа (4-11 удаа), 13% нь ойр ойрхон буюу жилдээ 12-оос олон удаа харсан байна (График38).




График 37. Ирвэс харсан давтамж, %, N=6




График 38. Чоно харсан давтамж, %, N=23

илүүсийн тухайд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 10% буюу 5 иргэн харсан, үлдсэн 41 иргэн буюу 90% нь хараагүй гэжээ. Харсан иргэдээс давтамжийг тодруулахад бүгд жилд нэг удаа харсан гэсэн байна (График38).

Зэрлэг амьтад хаагуур ихэвчлэн харагдаж байгааг тодруулахад хар сүүлтий болон янгирыг нутгийн иргэд олон газар харсан бол, бусад амьтдыг тодорхой нэг байршилд харсан байна. Тухайлбал, Өлзийт багийн нутаг Соёо хад, Дээд хад хавиар, Сангийн далайд Зарманы хоолой, Цагаан уулд Цагаан толгой уул, Суман хад, Цэцэг нуурт уул, говь, нуруунд голлон харсан байна.

Сүүлийн 2 жилийн хугацаанд Зармангийн хоолой ОНТХГ-нд хулгайн ан, заг бэлтгэх, эмийн ургамал түүх, бичил уул уурхай эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь энэ талаар мэдлэг, мэдээлэл хомс буюу мэдэхгүй хэмээн хариулсан байна (Хүснэгт.11).

	Маш их нэмэгдсэн	Нэмэгдсэн	Хэвэндээ	Багассан	Маш их багассан	Мэдэхгүй
Хулгайн ан		10.9%	28.3%	13.0%	15.2%	32.6%
Заг бэлтгэх	4.3%	10.9%	23.9%	21.7%	6.5%	32.6%
Эмийн ургамал		2.2%	8.7%	4.3%	10.9%	73.9%
Бичил уул,уурхай	4.3%	13.0%	6.5%	4.3%	10.9%	60.9%

Хүснэгт 10. Сүүлийн 2 жилийн хугацаанд байгаль орчны зөрчилд гарсан өөрчлөлт, %, N=46

Байгаль орчны зөрчил ихэвчлэн намрын улиралд гардаг байна. Хулгайгаар ан хийх, заг бэлтгэх, эмийн ургамал түүх зэрэг зөрчил хаврын улиралд буурдаг бол хууль бусаар алт ухах зөрчил хавар нэмэгддэг байна (Хүснэгт.12).

Улирал	Хулгайн ан	Заг бэлтгэх	Эмийн ургамал	Бичил уул,уурхай
Зун	12.1%		28.6%	18.2%
Намар	75.8%	57.6%	42.9%	18.2%
Өвөл	9.1%	36.4%	28.6%	9.1%
Хавар				18.2%
4 улирал	3.0%	6.1%		36.4%

Хүснэгт 11. Байгаль орчны зөрчил голчлон гарч буй улирлууд, %

Байгаль орчны зөрчил гаргаж байгаа иргэдийн дийлэнх хувь нь нутгийн иргэд байна. Байгаль орчны зөрчлийг хэн үйлдэж байгааг тодруулахад хулгайн ан хийж байгаа иргэдийн 40% нь нутгийн иргэд, 36% нь сумын төвийн иргэд, 15% нь аймгийн төвийн иргэд, 6% нь Улаанбаатар хотоос ирсэн иргэд, 4% нь алтны хайгуулчид байна. Харин заг бэлтгэж байгаа иргэдийн 44% нь нутгийн иргэд, 42% нь сумын төвийн иргэд, 2% нь аймгийн төвийн иргэд байна. Эмийн ургамал бэлтгэж байгаа иргэдийн 38% нь нутгийн иргэд, 25% нь сумын төвийн иргэд, 13% нь аймгийн төвийн иргэд, 13 нь Улаанбаатар хотоос ирсэн иргэд, 13% нь хайгуулчид байна. Харин бичил уул уурхай эрхэлж байгаа иргэдийн дийлэнх нь аймгийн төвийн иргэд байгаа бөгөөд нутгийн иргэд хамгийн бага буюу 6 хувийг эзэлж байна (График 40).




График 39. Байгаль орчны зөрчлийг хэн үйлдэж байна, %

Байгаль орчны зөрчил гарч байгаа газрууд нь зэрлэг амьтны харагдац ихтэй гэж нэрлэсэн газартай давхцаж байна.

Иргэдийн байгаль хамгааллын талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг тодорхойлохдоо тодорхой нөхцөл өгч, тэдгээрийг ач холбогдлын түшингээр нь үнэлүүлэв. Нутгийн иргэд Зармангийн хоолойн заган ойг хамгаалах, сэргээх (82.6%), говийн баян бүрдийг хамгаалж, нөхөн сэргээх (71.7%), болон байгалийн усыг зэрлэг амьтанд нь хүртээмжтэй болгох (69.6%) нь маш их ач холбогдолтой гэж үзсэн. Харин малын тоо толгойг хянах замаар бэлчээрээ тордох, сэргээх нь ямар ч ач холбогдолгүй (2.2%), ач холбогдол бага, дундаж ач холбогдолтой, ерөнхийдөө ач холбогдолтой, маш их ач холбогдолтой гэж янз бүрээр үнэлжээ. Байгаль хамгаалал болон орчны бүсийн менежментийн тогтолцооны талаарх малчдын мэдлэг, хандлагыг дараах графикт дэлгэрэнгүй харуулав (График 41).

Малчдын ойлголт




График 40. Байгаль хамгааллын талаарх малчдын ойлголт, %

Байгаль хамгаалал болон орчны бүсийн менежментийн тогтолцооны талаарх нутгийн иргэдийн хандлагыг тодорхойлоход эцэг өвгөдөөс уламжилж авсан нутгийн байгаль, амьтан, бэлчээрийг хамгаалахад малчид их үүрэгтэй, малчид нутгийн байгаль, зэрлэг амьтдыг хамгаалахад чадах бүхнээрээ туслах үүрэгтэй, нэг үеэ бодвол малчдын амьжиргаа их сайжирсан, одоо малаа цөөлж бэлчээрээ сэргээх цаг нь болсон, малчдын хүүхдүүд хотод суурьшаад бэлчээр нутаг, мал аж ахуй сонирхохоо больсон гэдэгтээ “маш их санал нийлсэн” байна (График 42).

Малчдын хандлага




График 41. Байгаль хамгаалал, орчны бүсийн менежментийн тогтолцооны талаарх малчдын хандлага, %

Нутгийн иргэдийн малчдын бүлэг нөхөрлөлд хамрагдсан байдлыг тандахад 2022 оны байдлаар Зармангийн ОНТХГ-нд малчдын 4 нөхөрлөл үүссэн ч үйл ажиллагааны идэвх хангалттай биш буюу 34 хувь байна. (График 43).

Нөхөрлөлийн гишүүн эсэх

Үйл ажиллагаа нь идэвхтэй эсэх




График 42. Нөхөрлөлд хамрагдсан байдал болон үйл ажиллагааны идэвх

Дээрх байдлаас дүгнэхэд нутгийн иргэдийн байгаль хамгааллын ажилд оролцох эрмэлзэл өндөр байна. Тиймээс Зармангийн хоолой ОНТХГ-нд нутгийн малчдад түшиглэсэн байгаль хамгааллын үйл ажиллагаа хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд байгаль хамгааллын үйл ажиллагааг малчдын амьжиргааг дээшлүүлэх үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.

Орон нутгийн тусгай хамгаалалтай газрын менежментийн зорилго, зорилт

Зармангийн хоолой ОНТХГ нь ГИДЦГ-ын “А” хэсгийн ховор, нэн ховор амьтдын амьдрах, шилжин нүүдэллэх таатай холбоос нутаг байж, дэлхийд болон Монгол Улсад “эмзэг”, “ховор” зүйл болсон Хар сүүлтийг хамгаалах, түүний амьдрах орчин - заган ой, Зармангийн баянбүрд бүхий цөлийн хээрийн экосистемийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр говийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг тэтгэж, уламжлалт өв соёлыг дэвжээн цэцэглүүлэх хэтийн зорилготой.

ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөө нь дээрх зорилгод хүрэх үндсэн арга хэрэгсэл болох бөгөөд 2023-2026 оны дөрвөн жилийн төлөвлөгөө нь [ОНТХГ-ын экологи-нийгмийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлж, малчны байгууллагыг үүсгэн байгуулах, чадавхжуулах, хамгааллын загвар тогтоох, цаашид үйл ажиллагаа явуулах суурийг тавих зорилготой](#)³.

ОНТХГ-ын менежментийн зорилгын хүрээнд 2023-2026 оны дөрвөн жилийн хугацаанд дараах 4 зорилтыг тавьж ажиллана.

Нэгдүгээр зорилт. Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох, чадавхтай болох

Хоёрдугаар зорилт. ОНТХГ-ын менежментийг хийх байгууллагыг чадавхжуулж, түншлэл хамтын ажиллагааны суурийг тавих

Гуравдугаар зорилт. Зармангийн цөлийн хээрийн экосистемийг цогцоор (бэлчээр, баянбүрд, заг, зэрлэг амьтан) нь хамгаалж суурь түвшнээс доройтуулахгүй түвшинд байлгах

Дөрөвдүгээр зорилт. Зармангийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг суурь үзүүлэлтээс сайжруулж, өв уламжлалыг сэргээх, хөгжүүлэх

Дээрх зорилтуудад хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээр зорилт. Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох, чадавхтай болох

Үйл ажиллагаа 1.1. Зармангийн хоолойн цөлийн хээрийн бэлчээрийн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх: ургамлын ургац, зүйл, бүрхэц, хөрсний түргэвчилсэн судалгаа (эхний болон эцсийн жилд)

Үйл ажиллагаа 1.2. Зармангийн хоолойн заган ойн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх, нөхөн сэргээх газрыг тодорхойлох (эхний болон эцсийн жилд)

Үйл ажиллагаа 1.3. Зармангийн хоолойн баянбүрд, бусад усны эх үүсвэрийн цогц судалгаа хийх, (эхний болон эцсийн жилд) боломжит уст цэгийг тодорхойлох

Үйл ажиллагаа 1.4. Хар сүүлтий, бусад хөхтний камерийн мониторинг судалгаа хийх (жил бүр)

Үйл ажиллагаа 1.5. Зармангийн малчдын нийгэм-эдийн засаг, хандлагын судалгаа хийх (эхний болон эцсийн жилд)

³ ГИДЦГ-ын “А” хэсгийн Орчны бүсэд ОНТХГ ажилласан өмнөх туршлага байхгүй, нутгийн удирдлагууд шинэ тулгар хамгаалалттай газрыг удирдан зохион байгуулах, малчдын байгууллагыг үүсгэн байгуулж чадавхжуулах чадвар хараахан бий болоогүй тул Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн үндэс суурийг тавих эхний дөрвөн жилд энэ чиглэлээр туршлага бүхий гаднын эксперт байгууллагаар чадавхжуулах ажил гэрээгээр хийлгэх шаардлагатай.

Хоёрдугаар зорилт. ОНТХГ-ын менежментийг хийх байгууллагыг чадавхжуулж, түншлэл хамтын ажиллагааны суурийг тавих

Үйл ажиллагаа 2.1. Зармангийн хоолойд нутагладаг малчдын дунд оролцооны аргаар хэлэлцүүлэг хийж малчдын байгууллага үүсгэн байгуулах

Үйл ажиллагаа 2.2. Малчдын байгууллагын засаглалын суурийг тавьж чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, дундын сан, хурлууд)

Үйл ажиллагаа 2.3. Малчдын байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих (сургалт, байгаль хамгаалал, амьжиргаа)

Үйл ажиллагаа 2.4. Зармангийн ОНТХГ-ын менежмент хийх дээвэр байгууллагыг үүсгэн байгуулах, чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, түншлэл, тайлан)

Үйл ажиллагаа 2.5. Зармангийн ОНТХГ-ын менежментийн тогтвортой байдлыг хангах, санхүүжилт татах, түншлэл, бизнесийг өргөжүүлэх

Гуравдугаар зорилт. Зармангийн хоолойн цөлийн хээрийн экосистемийг цогцоор (бэлчээр, баянбүрд, заг, зэрлэг амьтан) нь хамгаалж суурь түвшнээс доройтуулахгүй түвшинд байлгах

Үйл ажиллагаа 3.1. Бэлчээрийн судалгаанд үндэслэн бэлчээр сайжруулах багц арга хэмжээ хэрэгжүүлэх (сургалт, бэлчээр ашиглах гэрээ хийх, зарим газрыг хаших, дарш бэлтгэх, бэлчээр чөлөөлөх, мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих)

Үйл ажиллагаа 3.2. Усны судалгаанд үндэслэж хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэх (баянбүрд цэвэрлэх, эх хаших, хамгааллын бүс тогтоох, хөв байгуулах)

Үйл ажиллагаа 3.3. Заг хамгаалах (сургалт, хаших, үрээр тарих, түлшний өөр эх үүсвэр хайх)

Үйл ажиллагаа 3.4. Идэвхитэн байгаль хамгаалагчдыг сургах, эргүүл мониторинг хийх

Дөрөвдүгээр зорилт. Зармангийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг суурь үзүүлэлтээс сайжруулж, өв уламжлалыг сэргээх, хөгжүүлэх

Үйл ажиллагаа 4.1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагын цуврал сургалт (жилд 3 удаа)


Үйл ажиллагаа 4.2. Бэлчээрийн менежментийн сургалт (жилд 3 удаа)

Үйл ажиллагаа 4.3. Байгаль, заг, зэрлэг амьтны сургалт (жилд 3 удаа)

Үйл ажиллагаа 4.4. Өрхийн эдийн засаг, санхүүгийн сургалт (эхний жилд 3 удаа)

Үйл ажиллагаа 4.5. Нүүдэлчдийн өв уламжлалыг сэргээх үйл ажиллагаа явуулах (жилд 2 удаа)

Эдгээр 4 зорилт, 19 үйл ажиллагаа нь Зармангийн хоолой ОНТХГ-ын 5 үнэт зүйлийг хамгаалах менежментийн зорилгод хүрэхэд хэрхэн хувь нэмэр оруулахыг Миради програм дээр хийсэн “Үр дүнгийн хэлхээс”-нд харуулав (Зураг.11).




Зураг 11. Зармангийн хоолой ОНТХГ-ын үнэт зүйлсийг хамгаалах үр дүнгийн хэлхээс

Зорилт 1-ын хүрээнд заган ой, усны эх үүсвэр, биологийн олон янз байдал болон нийгмийн судалгаа, мөн бэлчээрийн мониторинг хийх гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Малчдын нийгэм-эдийн засгийн суурь судалгааг хийснээр тулгамдаж буй асуудал, хамгаалах зайлшгүй шаардлагатай үнэт зүйлс болон тэдгээрт тулгарч буй аюул занал зэргийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээ, судалгааны арга зүй болон хэрэглэгдэхүүнийг тодорхойлно.

Судалгааны арга зүй тодорхой, суурь судалгааны материал хангалттай болсны дараа шаардлагатай санхүүжилтийг олохын тулд юуны өмнө бүс нутгийн менежментийн байгууллагыг сайжруулах шаардлагатай. Үүний тулд иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, хангалттай мэдээлэл өгөх хэрэгтэй бөгөөд ингэснээр иргэдийн оролцоог нэмэгдүүлж, түүнийг даган эрх бүхий байгууллагуудын оролцоог ханган, төлөвлөгөөтэй ажиллаж эхэлснээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлнө.

Цаашлаад энэ нь түншлэл, дундын санг идэвхжүүлж, тогтвортой санхүүжилтийг бий болгоно. Санхүүжилттэй болсноор төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлнө гэх зэргээр дээрх үйл ажиллагаанууд хоорондоо эргэх холбоотой явагдана.


Менежментийн асуудлыг шийдсэнээр малчдад боловсрох, мэргэших боломжийг нээж өгөх бөгөөд энэ нь малчдын өв уламжлал, хар сүүлт болон бэлчээрт тулгараад буй аюул заналыг нэмэгдүүлэхгүй байх, нөгөө талаар бэлчээрийн менежментийн асуудлыг шийдэж чадвал одоогоор хамгаалах шаардлагатай байгаа үнэт зүйлсэд ирэх малын дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зэрэг нөлөө үзүүлнэ (Зураг.12).



Зураг 12. Зорилт 1-ийн үйл ажиллагааны хэлхээс

Зорилт 2-ын хүрээнд менежментийн байгууллагыг чадавхжуулахад бүрэн төвлөрөх бөгөөд малчдын байгууллага үүсгэн байгуулах үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөөд байна. Юун түрүүнд малчдын нөхөрлөл байгуулж, суурийг нь чанартай тавих хэрэгтэй бөгөөд үүний тулд малчдад мэдлэг олгох, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Жишээ нь малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, байгаль орчны доройтол, тулгамдаж буй


асуудлуудын талаарх бодит байдлыг танилцуулж, хамгаалж болох арга хэмжээнүүдийн талаар мэдээллүүдийг хүртээмжтэйгээр өгч чадвал малчдын нөхөрлөлийн хүний нөөцийг нэмэгдүүлж чадна. Байгууллагын суурийг тавьсны дараа үйл ажиллагааны дүрэм, төлөвлөгөөтэй болж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих дундын сан, хамтын ажиллагааг идэвхжүүлснээр санхүүгийн хувьд тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих дээвэр байгууллагыг үүсгэн байгуулснаар менежментийн тогтвортой байдлыг хангаж чадна. Менежментийн асуудлыг шийдсэнээр малчдад боловсрох, мэргэшэх боломжийг нээж өгөх бөгөөд энэ нь малчдын өв уламжлал, хар сүүлтий болон бэлчээрт тулгараад буй аюул заналыг нэмэгдүүлэхгүй байхад эергээр нөлөөлнө. Нөгөө талаар бэлчээрийн менежментийн асуудлыг шийдэж чадвал одоогоор хамгаалах шаардлагатай байгаа үнэт зүйлсэд ирэх малын дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зэрэг нөлөө үзүүлнэ.



Зураг 13. Зорилт 2-ийн үйл ажиллагааны хэлхээс


Зорилт 3-ын хүрээнд Зармангийн хоолойн ОНТХГ-ын экосистемийг цогцоор нь хамгаалахын тулд бэлчээр сайжруулах багц арга хэмжээ авах, уст цэг хамгаалах судалгаа хийх, заган ойг хамгаалах гэсэн үндсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Экосистемийг цогцоор хамгаалахад шаардлагатай үйл ажиллагаануудыг хийхийн тулд менежментийн

байгууллагыг сайжруулах хэрэгтэй. Энд хамгийн түрүүнд малчдын мэдлэг, боловсролыг дэмжиж, мэдээ мэдээллийг хангалттай өгч, хүний нөөцийг сайжруулах шаардлагатай. Энэ нь орон нутгийн оролцоог идэвхжүүлж, тухайн байгууллагын дүрэм, төлөвлөгөө гэх дотоод үйл ажиллагаа сайжирч тодорхой хэмжээний төсөл, хөтөлбөр, түншлэл, дундын сантай болох нөхцөл бүрдэнэ. Менежмент сайжирснаар мэргэших, боловсрох боломжийг олгох болон оролцоог дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Нөгөө талаас уст цэг хамгаалах судалгаа хийж усны эх үүсвэрийг нэмэгдүүлснээр малын нягтшилыг зохицуулж, бэлчээрийн даац болон малын өвчнийг багасган Харсүүлтий, бэлчээрийн экосистем, заг, баянбүрд, нутгийн иргэдийн хөгжилд үзүүлэх малын дарамт багасаж, доройтох шалтгаан нь буурах юм. Идэш тэжээлийн хомсдолоос үүдэлтэй махчлал болон малчдын тогтсон ойлголт эерэг болсноор хулгайн ан багасах нь Харсүүлтий болон бэлчээрийн экосистемд үзүүлэх аюул заналыг зохицуулах боломжтой.



Зураг 14. Зорилт 3-ийн үйл ажиллагааны хэлхээс

Зорилт 4-ийн хүрээнд малчдын амьдралыг сайжруулж, өв уламжлалыг сэргээхийн тулд орон нутгийн оролцоог нэмэгдүүлж мөн төсөл хөтөлбөр, дундын сангаас санхүүжилтээ сайжруулж орлогын эх үүсвэрийг олон болгох үйл ажиллагаануудыг хийснээр малчдын мэдлэг, боловсрол хангалттай сайн болж, энэ нь эргээд менежмент сайжруулах хүний нөөцийг бий болгох юм. Менежмент сайжирснаар бэлчээрийн даац хүртээмжтэй байх давуу талыг малчдад ойлгуулан Харсүүлтий, бэлчээрийн экосистем, заг, баянбүрд, говийн нүүдэлчдийн аж амьдралд учрах малын дарамт гэх асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулж чадна. Мөн малчдын амьдралын хэв маягийг өөрчилснөөр малаас хэт хамааралтай байх асуудал шийдэгдэж бусад салбарт хөгжих боломжийг олгох юм. Эдгээр үр дүнд хүрэхийн тулд байгалийн нөөцийн цуврал сургалт; бэлчээрийн менежментийн сургалт; байгаль, заг, зэрлэг амьтны сургалт; өрхийн эдийн засаг, санхүүгийн сургалтуудыг зохион байгуулах гэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.



Зураг 15. Зорилт4 -ийн үйл ажиллагааны хэлхээс

III БҮЛЭГ. ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө

Зармангийн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөө нь “Зармангийн хоолой ОНТХГ-ын алсын хараа бол Зармангийн говийн шүхэр зүйл - Хар сүүлтэй болон бусад зэрлэг амьтан, тэдгээрийн амьдрах орчин болсон заган ой, амьдралыг тэтгэгч баянбүрд бүхий цөлийн хээрийн экосистемийг говийн нүүдэлч малчдын сайн сайхан амьдралын үндэс, төрөлх нутаг, уламжлал соёлын гал голомт хэмээн нутгийн иргэдийн идэвх зүтгэлээр хамгаалж, цэцэглүүлэх, үр хойчид нь өвлүүлэх” алсын хараа буюу стратегийн зорилгыг хангахад чиглэгдэнэ.

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь дээрх зорилгод хүрэх үндсэн арга хэрэгсэл бөгөөд 2023-2026 оны дөрвөн жилийн төлөвлөгөө нь “ОНТХГ-ын экологи-нийгмийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлж, малчны байгууллагыг үүсгэн байгуулах, чадавхжуулах, хамгааллын загвар тогтоох, цаашид үйл ажиллагаа явуулах суурийг тавих” зорилготой. Энэ зорилгын хүрээнд 2023-2026 оны дөрвөн жилийн хугацаанд **4 зорилт** дэвшүүлэн ажиллана. Үүнд: **(Зорилт 1)** Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох, чадавхтай болох. **(Зорилт 2)** ОНТХГ-ын менежментийг хийх байгууллагыг чадавхжуулж, түншлэл хамтын ажиллагааны суурийг тавих **(Зорилт 3)** Зармангийн цөлийн хээрийн экосистемийг цогцоор (бэлчээр, баянбүрд, заг, зэрлэг амьтан) нь хамгаалж суурь түвшнээс доройтуулахгүй түвшинд байлгах **(Зорилт 4)** Зармангийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг суурь үзүүлэлтээс сайжруулж, өв уламжлалыг сэргээх, хөгжүүлэх.

Зорилт бүрийг хангах 4-5 үйл ажиллагаа, нийт 19 үйл ажиллагааг 4 жилийн турш хэрэгжүүлнэ. Тухайн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжит эх үүсвэр, хэрэгжилтийг шалгах индикатор, суурь үзүүлэлт, хүрэх түвшин буюу хүлээгдэж буй үр дүнг дараах хүснэгтээр харуулав (Хүснэгт.14).

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Боломжит эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин
		2023	2024	2025	2026				
1 Зорилт 1. Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох чадавхтай болох									
1.1	Зармангийн цөлийн хээрийн бэлчээрийн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх: ургамлын ургац, зүйл, бүрхэц, хөрсний түргэвчилсэн судалгаа					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) ТөсөлТөсөл	Бэлчээрийн талхагдал (га)	Суурь үзүүлэлт байхгүй	Бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг бууруулахгүй байх
1.2	Зармангийн хоолойн заган ойн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх, нөхөн сэргээх газрыг тодорхойлох					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) ТөсөлТөсөл	Заган ойн талбай (га)	35 694 га (2015 еic.mn)	Одоо байгаа түвшинг хадгалах буюу 3-5 га-аар нэмэгдүүлэх
1.3	Зармангийн баянбүрд, бусад усны эх үүсвэрийн цогц судалгаа хийх, (эхний болон эцсийн жилд) боломжит уст цэгийг тодорхойлох					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) ТөсөлТөсөл	Уст цэгийн тоо, уст цэг дээр ирж буй амьтдын тоо		Уст цэгийн тоо суурь үзүүлэлтээс нэмэгдсэн байна.
1.4	Хар сүүлтэй, бусад хөхтний камерийн мониторинг судалгаа хийх					ЗДТГ, Төсөл	Тоо толгой, эрүүл хяналтын тоо	1530 (2020)	Жилд 2 удаа судалгаа хийсэн байх. Хар сүүлтэй тоо толгой суурь үзүүлэлтээс буураагүй байх
1.5	Зармангийн малчдын нийгэм-эдийн засаг, хандлагын судалгаа хийх					ЗДТГ, Төсөл	Мэдлэг хандлага дадлын өөрчлөлт	Хандлага зэрэг, мэдлэг бага	
Нийт									
2 Зорилт 2. ОНТХГ-ын менежментийг хийх байгууллагыг чадавхжуулж, түншлэл хамтын ажиллагааны суурийг тавих									
2.1	Зармангийн хоолойд нутагладаг малчдын дунд оролцооны аргаар хэлэлцүүлэг хийж малчдын байгууллага үүсгэн байгуулах					Төсөл	Малчдын байгууллагын тоо	3 (идэвхгүй)	60 өрх нэгдэж 5 нөхөрлөл байгуулагдсан байна
2.2	Малчдын байгууллагын засаглалын суурийг тавьж чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, дундын сан, хурлууд)					Төсөл	дүрэм, төлөвлөгөө, дундын сан, хурлууд	1 (Малчин бүлэг)	Дүрэм, хуримтлалын сан, нөхөрлөлийн 5 жилийн МТ-тэй болсон байна. Нөхөрлөл жилд 6 удаа хурал хийсэн байна. БМТ-тэй болсон байна. Сумын ЗД-тэй БНХМ-ийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан байна.
2.3	Малчдын байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих					Төсөл	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		0
2.3a	Сургалт, байгаль хамгаалал, амьжиргаа)					Төсөл	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	3 сургалт (2022) 25 хүнд хийсэн.	Жилд 3 удаа БМ-ийн сургалт, зэрлэг амьтны сургалт эхний жил 2 удаа, 2 дахь болон 3 жилд 1 удаа зохион байгуулсан байна.
2.3б	Малчдын санаачилгыг дэмжих					Төсөл	Малчдын санаачилсан төслийн тоо		0
2.4	Зармангийн ОНТХГ-ын менежмент хийх дээвэр байгууллагыг үүсгэн байгуулах, чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, түншлэл, тайлан)					Төсөл	Нөхөрлөлийн холбоо ТББ		0 Нөхөрлөлийн холбоо ТББ байгуулагдсан байна.
2.5a	Зармангийн ОНТХГ-ын менежментийн тогтвортой байдлыг хангах, санхүүжилт татах, түншлэл, бизнесийг өргөжүүлэх					ЗДТГ	Татсан санхүүжилтийн хэмжээ		0 БНАТ-өөс МТ-г хэрэгжүүлэх тодорхой хэмжээний санхүүжилт авсан байна
2.5б	Төслийн санал боловсруулах, санхүүжилт татах					ЗДТГ	Донор байгууллагаас татсан санхүүжилтийн хэмжээ		0
Нийт									
3 Зорилт 3. Зармангийн цөлийн хээрийн экосистемийг цогцоор (бэлчээр, баянбүрд, заг, зэрлэг амьтан) нь хамгаалж суурь түвшнээс доройтуулахгүй түвшинд байлгах									
3.1	Бэлчээрийн судалгаанд үндэслэн бэлчээр сайжруулах багц арга хэмжээ хэрэгжүүлэх (сургалт, бэлчээр ашиглах гэрээ хийх, зарим газрыг хаших, дарш бэлтгэх, бэлчээр чөлөөлөх, мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих)					ЗДТГ	Чөлөөлсөн бэлчээрийн талбайн хэмжээ		0 Бэлчээрийн өнөөгийн төлөв байдал дордоогүй байна.
3.2	Усны судалгаанд үндэслэж хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэх (баянбүрд цэвэрлэх, эх хаших, хамгааллын бүс тогтоох, хөв байгуулах)					ЗДТГ, ГИДЦГ-ын А хэсгийн ХЗ, төсөл	Байгуулсан хөв, хашсан бүлгийн тоо		0 Уст цэгийн тоо суурь үзүүлэлтээс нэмэгдсэн байна.
3.3	Заг хамгаалах (сургалт, хаших, үрээр тарих, түлшний өөр эх үүсвэр хайх)					Төсөл	Заган ойн сэргэн ургалтыг дэмжиж хашаалсан талбайн хэмжээ, үрээр ойжуулсан талбайн хэмжээ, амжилттай ургуулсан загийн тоо		0 Заган ойн талбайн хэмжээ суурт үзүүлэлтээс нэмэгдсэн байна.
3.4	Идэвхитэн байгаль хамгаалагчдыг сургах, эргүүл мониторинг хийх					ЗДТГ, ДЦГ, Төсөл	Идэвхитэн байгаль хамгаалагчийн тоо, жилд хийх эрүүл хяналтын тоо		0 10 идэвхитэн байгаль хамгаалагч тогтмол ажиллаж, жилд 12 удаа эрүүл хяналт хийсэн байна.
Нийт									
4 Зорилт 4. Зармангийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг суурь үзүүлэлтээс сайжруулж, өв уламжлалыг сэргээх, хөгжүүлэх									
4.1	Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагын цуврал сургалт (жилд 3 удаа)					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) Төсөл	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо		0 Зармангийн хоолой ОНТХГ-нд нутагладаг 60 өрх 12 сургалтанд хамрагдсан байна.
4.2	Бэлчээрийн менежментийн сургалт (жилд 3 удаа)					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) Төсөл	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо		0 Зармангийн хоолой ОНТХГ-нд нутагладаг 60 өрх 12 сургалтанд хамрагдсан байна.
4.3	Байгаль, заг, зэрлэг амьтны сургалт (жилд 3 удаа)					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) Төсөл	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо		0 Зармангийн хоолой ОНТХГ-нд нутагладаг 60 өрх 12 сургалтанд хамрагдсан байна.
4.4	Өрхийн эдийн засаг, санхүүгийн сургалт (эхний жилд 3 удаа)					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) Төсөл	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо		0 Зармангийн хоолой ОНТХГ-нд нутагладаг 60 өрх 12 сургалтанд хамрагдсан байна.
4.5	Нүүдэлчдийн өв уламжлалыг сэргээх үйл ажиллагаа явуулах (жилд 2 удаа)					ЗДТГ (ОНХС, БНАТ, малын тоо толгойн албан татвар) Төсөл	Уламжлалт аргаар малаа хариулдаг, нүүдэлдэг өрхийн тоо		

Мониторингийн төлөвлөгөө

Зармангийн хоолой ОНТХГ-нд хамгаалахаар сонгон авсан 5 үнэт зүйлийн төлөв байдал, өөрчлөлт, менежментийн зорилго, зорилтод хүрч байгаа эсэхийг хянах буюу үйл ажиллагааны үр дүнд гарах ахиц дэвшил, ухралтыг хэмжих хамгийн чухал арга хэрэгсэл бол мониторинг төлөвлөгөө боловсруулж, дагаж мөрдөх юм.

Зармангийн хоолой ОНТХГ-ын мониторинг төлөвлөгөө нь Дотоод, Гадаад, Үнэт зүйлийн мониторинг гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Мониторингийн төлөвлөгөөнд тусгагдсан бүхий л үйл ажиллагаанд сумын ИТХ, ЗДТГ, малчдын нөхөрлөл, иргэдийн төлөөлөл ямар нэг хэлбэрээр оролцож, менежментийг гүйцэтгэгч этгээд Зармангийн хоолой ОНТХГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж буй эсэхэд хяналт тавьна.

Дотоод хяналт

Зармангийн хоолой ОНТХГ-нд байгуулагдсан малчдын байгууллагын дотоод зохион байгуулалт, менежментэд үнэлэлт дүгнэлт өгөх, малчдын байгууллагын бүтэц үйл ажиллагааг сайжруулахад энэ хяналтын зорилго оршино. ОНТХГ-ын менежментийг хариуцагч хуулийн этгээдийн үйл ажиллагааг дүгнэх, үнэлэх механизм нь дараах байдлаар авч үзнэ. Үүнд:

1. Гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, гэрээний салшгүй хэсгээр авч үзэх
2. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын ИТХ-нд тайлагнах
3. Гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, цаашид үйл ажиллагааг сайжруулах тал дээр анхааран ажиллах
4. Малчдын нөхөрлөлийн ахлагч багийн болон сумын иргэдийн хуралд нөхөрлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулна.

Гадаад мониторинг

Зармангийн хоолойн ОНТХГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон донор байгууллагаас (гадны санхүүжилт авсан тохиолдолд) хэрэгжилтийн дунд болон төгсгөлийн жил хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Үнэт зүйлийн мониторинг

Зармангийн хоолой ОНТХГ-нд уст цэг, баянбүрд, бэлчээрийн бүрэн хэмжээний нарийвчилсан судалгаа хийгдээгүй нь үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянахад хүндрэл учруулж байна. Менежментийн төлөвлөгөөний зорилт тус бүрийн шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих нэгж, сүүр болон хүрэх түвшин, арга зүйг тодорхойлж үнэт зүйлийн мониторингийн төлөвлөгөөг боловсруулав (Хүснэгт.15).

Мониторингийг төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хамтад нь төсөвлөсөн болно.

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Арга зүй	Хүрэх түвшин
1	Зорилт 1. Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох чадавхитай болох					
1.1	Зармангийн цөлийн хээрийн бэлчээрийн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх: ургамлын ургац, зүйл, бүрхэц, хөрсний түргэвчилсэн судалгаа	2023, 2026	Бэлчээрийн талхагдал (га)	Суурь үзүүлэлт байхгүй	Ургамалын цэгт газрын мониторинг	Бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг бууруулахгүй байх
1.2	Зармангийн хоолойн заган ойн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх, нөхөн сэргээх газрыг тодорхойлох	2023, 2026	Заган ойн талбай (га)	35 694 га (2015 еic.mn)	Хэмжилт тооллого	Одоо байгаа түвшинг хадгалах буюу 3-5 га-аар нэмэгдүүлэх
1.3	Зармангийн баянбүрд, бусад усны эх үүсвэрийн цогц судалгаа хийх, (эхний болон эцсийн жилд) боломжит уст цэгийг тодорхойлох	2023, 2026	Уст цэгийн тоо, уст цэг дээр ирж буй амьтдын тоо		Хэмжилт, Усны чанарын шинжилгээ, Газрын бүрхэвчийн өөрчлөлт	Уст цэгийн тоо суурь үзүүлэлтээс нэмэгдсэн байна.
1.4	Хар сүүлтий, бусад хөхтний камерийн мониторинг судалгаа хийх	Жил бүр	Тоо толгой, эрүүл хяналтын тоо	1530 (2020)	Хээрийн судалгаа ажиглалтын арга	Жилд 2 удаа судалгаа хийсэн байх. Хар сүүлтийн тоо толгой суурь үзүүлэлтээс буураагүй байх
1.5	Зармангийн малчдын нийгэм-эдийн засаг, хандлагын судалгаа хийх	2023, 2026	Мэдлэг хандлага дадлын өөрчлөлт	Хандлага эерэг, мэдлэг бага	Түүвэр аман судалгааны арга	
2	Зорилт 2. Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох, чадавхтай болох					

2.1	Зармангийн хоолойд нутагладаг малчдын дунд оролцооны аргаар хэлэлцүүлэг хийж малчдын байгууллага үүсгэн байгуулах	2023	Малчдын байгууллагын тоо	3 (идэвхгүй)	Бүртгэл тэмдэглэл	60 өрх нэгдэж 5 нөхөрлөл байгуулагдсан байна
2.2	Малчдын байгууллагын засаглалын суурийг тавьж чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, дундын сан, хурлууд)	2023-2024	дүрэм, төлөвлөгөө, дундын сан, хурлууд	1 (Малчин бүлэг)	Бүртгэл тэмдэглэл	Дүрэм, хуримтлалын сан, нөхөрлөлийн 5 жилийн МТ-тэй болсон байна. Нөхөрлөл жилд 6 удаа хурал хийсэн байна. БМТ-тэй болсон байна. Сумын ЗД-тай БНХМ-ийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан байна.
2.3	Малчдын байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих	Жил бүр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	Бүртгэл тэмдэглэл, Тайлан	
2.3a	Сургалт, байгаль хамгаалал, амьжиргаа)	2024 - 2025	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	3 сургалт (2022) 25 хүнд хийсэн.	Сургалтын чанарын үнэлгээ, бүртгэл тэмдэглэл	Жилд 3 удаа БМ-ийн сургалт, зэрлэг амьтны сургалт эхний жил 2 удаа, 2 дахь болон 3 жилд 1 удаа зохион байгуулсан байна.
2.3б	Малчдын санаачилгыг дэмжих	2023-2026	Малчдын санаачилсан төслийн тоо	0	Тайлан	
2.4	Зармангийн ОНТХГ-ын менежмент хийх дээвэр байгууллагыг үүсгэн байгуулах, чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, түншлэл, тайлан)	2025 - 2026	Нөхөрлөлийн холбоо ТББ, баримт бичиг	0	Бүртгэл тэмдэглэл, баримт бичиг	Нөхөрлөлийн холбоо ТББ байгуулагдсан байна.
2.5a	Зармангийн ОНТХГ-ын менежментийн тогтвортой байдлыг хангах, санхүүжилт татах, түншлэл, бизнесийг өргөжүүлэх	Жил бүр	Татсан санхүүжилтийн хэмжээ	0	Бүртгэл тэмдэглэл	БНАТ-өөс МТ-г хэрэгжүүлэх тодорхой хэмжээний санхүүжилт авсан байна

2.56	Төслийн санал боловсруулах, санхүүжилт татах	Жил бүр	Донор байгууллагаас татсан санхүүжилтийн хэмжээ	0	Бүртгэл тэмдэглэл	
3	Зорилт 3. Зармангийн цөлийн хээрийн экосистемийг цогцоор (бэлчээр, баянбүрд,заг, зэрлэг амьтан) нь хамгаалж суурь түвшнээс доройтуулахгүй түвшинд байлгах					
3.1	Бэлчээрийн судалгаанд үндэслэн бэлчээр сайжруулах багц арга хэмжээ хэрэгжүүлэх (сургалт, бэлчээр ашиглах гэрээ хийх, зарим газрыг хаших, дарш бэлтгэх, бэлчээр чөлөөлөх, мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих)	Жил бүр	Чөлөөлсөн бэлчээрийн талбайн хэмжээ	0		
3.2	Усны судалгаанд үндэслэж хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэх (баянбүрд цэвэрлэх, эх хаших, хамгааллын бүс тогтоох, хөв байгуулах)	2023 - 2025	Байгуулсан хөв, хашсан булгийн тоо		Усны чанарын судалгаа, Хээрийн судалгаа	
3.3	Заг хамгаалах (сургалт, хаших, үрээр тарих, түлшний өөр эх үүсвэр хайх)	Жил бүр	Заган ойн сэргэн ургалтыг дэмжиж хашаалсан талбайн хэмжээ, үрээр ойжуулсан талбайн хэмжээ, амжилттай ургуулсан загийн тоо		Тарьц суулгац ургуулах арга зүй, Түлшний бусад эх үүсвэрийн судалгаа	
3.4	Идэвхитэн байгаль хамгаалагчдыг сургах, эргүүл мониторинг хийх	Жил бүр	Идэвхитэн байгаль хамгаалагчийн тоо, жилд хийх эрүүл хяналтын тоо	0	SMART- ашиглан эргүүл хийх арга зүй	10 идэвхитэн байгаль хамгаалагч тогтмол ажиллаж, жилд 12 удаа эрүүл хяналт хийсэн байна.
4	Зорилт 4. Зармангийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг суурь үзүүлэлтээс сайжруулж, өв уламжлалыг сэргээх, хөгжүүлэх					

4.1	Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагын цуврал сургалт (жилд 3 удаа)	Жил бүр	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Байхгүй	Бүртгэл, тэмдэглэл, Сургалтын чанарын судалгаа	Зармангийн хоолой ОНТХГ-нд нутагладаг 60 өрх 12 сургалтанд хамрагдсан байна.
4.2	Бэлчээрийн менежментийн сургалт (жилд 3 удаа)	Жил бүр		Байхгүй	Бүртгэл, тэмдэглэл, Сургалтын чанарын судалгаа	60 өрх, 12 сургалт
4.3	Байгаль, заг, зэрлэг амьтны сургалт (жилд 3 удаа)	Жил бүр		ЛАСН байгаль орчны мэдлэг хандлагыг сайжруулах чиглэлийн сургалт 2022 онд сургуулийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан.	Бүртгэл, тэмдэглэл, Сургалтын чанарын судалгаа	60 өрх, 12 сургалт
4.4	Өрхийн эдийн засаг, санхүүгийн сургалт (эхний жилд 3 удаа)	2023		0	Бүртгэл, тэмдэглэл, Сургалтын чанарын судалгаа	60 өрх, 3 сургалт
4.5	Нүүдэлчдийн өв уламжлалыг сэргээх үйл ажиллагаа явуулах (жилд 2 удаа)	Жил бүр	Уламжлалт аргаар малаа хариулдаг, нүүдэлдэг өрхийн тоо	0	Бүртгэл, тэмдэглэл, Сургалтын чанарын судалгаа	60 өрх, 12 сургалт


Хүснэгт 13. Зармангийн хоолой ОНТХГ-ын үнэт зүйлсийн мониторингийн төлөвлөгөө

IV БҮЛЭГ: МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ

ОНТХГ-ын хамгааллын менежментийг хэрэгжүүлэгч байгууллага, бүтэц, зохион байгуулалт

Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийг хамтын засаглалын хэлбэрээр зохион байгуулах ба нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын үзэл баримтлал, түүнд тохирсон арга хэрэгслүүдийг ашиглан хэрэгжүүлнэ. Төр нь тус ОНТХГ-ийн байгалийн нөөцөд менежмент хийх эрхийг нутгийн иргэдийн байгууллагад шилжүүлэн өгөх ба энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8 дугаар зүйлд заасан байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд байна. Нөхөрлөл нь хариуцан хамгаалж буй газар нутагтаа байгалийн нөөцийн хамтын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, байгаль орчныг өнөөгийн төлөв байдлаас доройтуулахгүй, нөхөн сэргээх ба тогтвортойгоор зохистой ашиглах үүрэг хүлээдэг. Харин төрийн байгууллага нь байгалийн нөөцийн менежмент хийх нутаг дэвсгэрийг нутгийн иргэдийн нөхөрлөлд давуу эрхтэйгээр шилжүүлэн байгалийн нөөцийн зохистой менежментийг хэрэгжүүлэх түшиц нэгж болгох зорилт тавьж, тэдний үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг орон нутгийг хөгжүүлэх бодлого шийдвэрт тусгаж дэмжиж ажиллана. Энэ нь институт, тэдгээрт явагдах үйл явцын цогц механизм бөгөөд менежментийн эрх мэдэл, хариуцлагыг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл олон ургалч байдлаар хамтран шийдэж ажиллах юм. Одоогоор ОНТХГ-т 80 орчим өрх нутаглан амьдарч байгаа нь 5- 6 нөхөрлөл байгуулагдах боломжтой юм.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл (БНХМН): зармангийн хоолой ОНТХГ-ын Менежментийн гол субъект нь байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл байна. Нөхөрлөл нь Зармангийн ОНТХГ-ын үнэт зүйл болсон **Говийн нүүдэлчдийн хөгжил, өв уламжлал, бэлчээр, заг, булаг шанд, худаг ус, хар сүүлтий зээрийг** хамгаалах, нөхөн сэргээх үүргийг хүлээхээс гадна нутгийн иргэдэд тулгамдаж буй нийгэм, эдийн засгийн бусад асуудлуудыг шийдвэрлэхэд анхааран өөрсдийн нөөц боломжийг бүрэн ашиглаж ажиллана. Нөхөрлөлийг анхнаас нь барьж байгуулахад нөхөрлөлийн дотоод засаглалын асуудлыг тодорхойлж тус институцийн дотоод ардчилал, ил тод байдал, шударга ёс, хүний эрхийг хүндэтгэх зэрэг үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх, нөхөрлөл бүр байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах зорилгоо тодорхойлсон нөхөрлөлийн дүрэмтэй, зорилгодоо хүрэхэд гишүүдийг зохион байгуулж, хариуцлагажуулах институцийн бүтэцтэй, менежментийн төлөвлөгөөтэй байна (Зураг.16).



Зураг 16. Нөхөрлөлийн дотоод засаглал

Нөхөрлөлийн дотоод засаглалын бүтэц:

Нөхөрлөлийн дүрэм: Нөхөрлөлийн засаглалын амин чухал бичиг баримт нөхөрлөлийн дүрэм юм. Байгаль орчиныг хамгаалах хуулийн 50-р зүйлийн 10-т заасны дагуу нөхөрлөл дүрмээ боловсруулан, бүх гишүүдийн хурлаараа хэлэлцэн батална. Нөхөрлөлийн дүрэм нь нөхөрлөлийн хувьд үндсэн хууль юм. Дүрэм нь нөхөрлөлийн үйл ажиллагаа, түүнд холбогдох харилцааг зохицуулах зорилготой. Дүрэм нь нөхөрлөлийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, гишүүнчлэл, удирдлагын бүтэц, үүрэг, хяналтын тогтолцоо, хөрөнгө санхүү гэсэн 12 бүлэгтэй байна. Дүрмийг батлах өөрчлөх хурлын ирц 80 хувиас дээш байж, гишүүд гарын үсэг зурснаар баталгааждаг.

Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал: Нөхөрлөлийн удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал юм. Бүх гишүүдийн хурлыг сард нэг удаа зарлан, нөхөрлөлийн ахлагч удирдан хуралддаг. Нөхөрлөлийн гишүүдийн 80-аас доошгүй хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болох ба хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж хурлын дарга, тэмдэглэл хөтөлсөн хүн гарын үсэг зурж албажуулна. Хурлын шийдвэр нь олонхын саналаар гарах бөгөөд шийдвэрийг бүх гишүүд дагаж мөрдөнө.

Нөхөрлөл нь хариуцан хамгаалж буй газар нутагтаа шийдвэрлэх асуудалд “Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө”-г хэлэлцэн батлах, хэрэгжилтэд дүгнэлт гаргах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, бэлчээрийн даацад тохирох малын тооны дээд хэмжээг батлах, жилд ашиглах байгалийн дагалт баялгийн хэмжээ, цэвэрлэгээ хийх баянбүрд, арчилгаа хийх заган ойн талбайн хэмжээг тогтоох, ойжуулалтын хэмжээ, бизнес төлөвлөгөө, хамтын менежментийн 5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, идэвхтэн байгаль хамгаалагчийн эргүүл хяналтын төлөвлөгөө зэрэг ажлын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх, Дундын сангийн орлого, зардлын төлөвлөгөө/төсөв, гүйцэтгэл, тайланг хэлэлцэх, төсвийг батлах, гүйцэтгэлд дүгнэлт гаргах гишүүнийг урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэх, нөхөрлөлийн бүтэц, орон тоо, зардал, ахлагчийн урамшууллыг тогтоох, ахлагчийг томилох, чөлөөлөх, өөрчлөх, хариуцан

хамгаалж буй нутаг дэвсгэрт нөхөрлөлийн гишүүн бус өрх айл, мал сүрэг шинээр орж нутаглах эсэх асуудлыг хэлэлцэх, гэрээгээр эзэмшиж буй ойн санд тухайн нөхөрлөлөөс бусад гаднын болон мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа явуулахыг хүссэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, нөхөрлөлд шинээр гишүүн элсүүлэх, гишүүнээс хасах асуудлыг шийдвэрлэх, нөхөрлөлийг өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

Нөхөрлөлийн удирдах зөвлөл: Нөхөрлөлийн удирдах зөвлөл 3-5 гишүүнтэй байна. Тэднийг нөхөрлөлийн бүх гишүүдийн нууц санал хураалтаар 2 жилийн хугацаатай сонгоно. Бүх гишүүдийн хурал болон нөхөрлөлийн ахлагчийн бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, Дундын сангийн нийт дүнгийн 50 хувиас доош дүн бүхий гэрээ хэлцэл, зардлын төсвийг хэлэлцэж шийдвэрлэх, бүх гишүүдийн хурал зарлах, нөхөрлөлийн ахлагчийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах, хариуцлага тооцох, ИБХ-ийг томилох, ажил үүргийн хуваарийг батлах, үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй байна. Удирдах зөвлөл нь бүх гишүүдийн хуралд тайлагнах, түүний шийдвэр, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бусад төлөвлөгөөт ажлууд болон цаг үеийн шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж, нөхөрлөлийн ахлагчид дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэгтэй. Мөн нөхөрлөлийн тайланг сумын ИТХ, багийн ИНХ, Нөхөрлөлийн холбооны УЗ, оролцогч талууд, олон нийтэд тавих, мэдээлэл хийх, гишүүдийн эрхийг хангах, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нөхөрлөлийн гишүүдийг сургалт, арга хэмжээнд жигд ижил тэгш хамруулах үүрэгтэй.

Нөхөрлөлийн Хяналтын зөвлөл: ХЗ нь 3 гишүүнтэй, тэднийг нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтаар 2 жилийн хугацаатай сонгодог. ХЗ нь УЗ ба нөхөрлөлийн ахлагчийн шийдвэр, үйл ажиллагаа нь нөхөрлөлийн дүрэм, төлөвлөгөөний дагуу байгаа эсэх болон гишүүдийн эрх ашигт нийцэж буй эсэхэд хяналт тавих, нөхөрлөлийн бичиг хэргийн хөтлөлтийг шалгах, хөрөнгийн бүртгэл, зарцуулалт, ашиглалт, санхүүгийн байдлыг хянах, шалгасан ажлын дүн, зөрчлийн талаар бүх гишүүдийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх, гишүүдийн эрхийн хэрэгжилт, санал гомдлыг хэрхэн барагдуулсныг хянах эрх, үүрэгтэй.

Нөхөрлөлийн ахлагч: Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаас олонхын саналаар нөхөрлөлийн ахлагчийг сонгоно. Ахлагч нь БНМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад нөхөрлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах, гишүүдэд дүрмийн дагуу шаардлага тавих, үүрэг даалгавар өгөх, биелэлтэд нь хяналт тавих, батлагдсан төсвийг эрхийн хүрээнд захиран зарцуулах, УЗ-өөс олгосон эрхийн хүрээнд холбогдох талууд, нөхөрлөлийн зөвлөх, ИБХ-тай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, УЗ-ийн хуралд санал оруулах, гишүүдийг идэвхжүүлэх, мэдээллээр хангах, сургалт арга хэмжээнд ижил тэгш жигд хамруулах, нөхөрлөлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг үүрэгтэй. Мөн нөхөрлөлийн ахлагч гүйцэтгэлд үндэслэн урамшуулал авах, БГХ-д нэг саналын эрхтэй.

Дундын хуримтлалын бүлгийн ахлагч: Нөхөрлөлийн Дундын хуримтлалын бүлгийн ахлагч нь сар бүр мэдээллийг нөхөрлөлийн дэвтэрт тэмдэглэж гишүүдэд мэдээлэх, сарын тайланд тусгах, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдээлэх, төсөв хянах, нөхөрлөлийн хурлын шийдвэрийн дагуу төсвийг зарцуулах үүрэгтэй. Мөн нөхөрлөлийн бизнес, санхүүгийн үйл

ажиллагааг гүйцэтгэх, баримтжуулах, санхүүгийн бичиг баримт бүрдүүлэх, аливаа тайланг нөхөрлөлийн ахлагчид бэлдэж өгөх, нөхөрлөлийн дотоод ажил, бичиг хэргийн хөтлөлтийг хийх, нягтлах, үр дүнг бүх гишүүдийн хуралд танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах үүрэгтэй.

Нөхөрлөлийн гишүүний андгай: Нутгийн иргэн нөхөрлөлийн зорилгыг хүлээн зөвшөөрч зармангийн хоолой ОНТХГ-ын байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах үйл ажиллагаанд хамтран оролцохыг хүсэж байгаагаар илэрхийлэн нөхөрлөлд орж өөрийн чадах хэмжээгээр хүчин зүтгэж байгаль орчны аливаа зөрчил гаргахгүй гэдгээ илэрхийлэн нөхөрлөлийн гишүүдийн өмнө андгай өргөж, Андгай бичигт гарын үсэг зурна.

Нөхөрлөлийн гишүүдийн хамтран ажиллах гэрээ: Энэхүү гэрээ нь Монгол Улсын Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах хуулийн 3-р зүйлийн 8-д заасныг үндэслэл болгон хүн бүр хамтран ажиллах зорилго, эрх үүрэг, оролцоо, хариуцлагаа харилцан тохиролцож гишүүд хоорондоо гэрээ байгуулна. Байгаль орчныг хамгаалах хуулийн 50-р зүйлийн 4-ийн 4-д заасны дагуу энэ гэрээ нь Засаг дарга нөхөрлөлтэй гэрээ байгуулах нэг үндэслэл болно.

Нөхөрлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө: Нөхөрлөл нь бүх гишүүдийн хурлаараа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг оролцооны аргаар хэлэлцэн тодорхойлж эрэмбэлэн шалтгааныг тодруулж, шийдэл гаргана. шийдлүүдийг өөрсдийн хийж чадах болон бусад хамтрагч талуудтай хамтран хийж чадах, хийж чадахгүй ажлуудыг тодорхойлж хийж чадах ажлуудыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана. Мөн гишүүдийн амьжиргаанд хүн хүч шаардлагатай ажлуудыг тодруулан хөдөлмөрөө хоршин хийх ажлын төлөвлөгөөг боловсруулна. Төлөвлөгөөнд нөхөрлөлүүдийн гэрээгээр хариуцсан нутаг дэвсгэрт байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ерөнхий зорилгын хүрээнд байгаль орчинд тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх, SMART байгаль орчны эргүүл мониторинг тогтмол хийж хууль бус агнуур, модны хулгайг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нутгийн иргэдийн эв санаа, хамтаараа хөгжих, бэлчээрийн болон ойн менежментийг оновчтой хэрэгжүүлэн гишүүдийнхээ амьжиргааг нэмэгдүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг тусган батална.

Нөхөрлөлийн 5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө: Энэ төлөвлөгөө нь нөхөрлөлийн дунд хугацаанд шийдвэрлэх асуудалтай илүү холбоотой байх бөгөөд үүнд бэлчээрийн даацад малын тоо толгойг тохируулах, бэлчээр хариуцлагажуулах журамыг батлах, ойжуулалт, заган ойн арчилгаа цэвэрлэгээний ажлыг шат дараатай зохион байгуулах, уст цэгүүдийг хамгаалах, зэрлэг амьдын бэлчээрийг чөлөөлөх гэх мэт ажлуудыг төлөвлөж өгнө.

Нөхөрлөлийн бизнес төлөвлөгөө: Гишүүдийн амьжиргааг сайжруулах, орлого нэмэгдүүлэх зорилгоор бизнесийн мэргэжлийн зөвлөхийн туслалцаатайгаар нөхөрлөл бүрийн бизнесийн боломж, гишүүдийн ур чадварыг үнэлэн, бизнесийн төлөвлөгөөг оролцооны аргаар хэлэлцэн гаргана. нөхөрлөлүүд хамтран эсвэл нөхөрлөл тус бүрдээ бизнес төлөвлөгөөг боловсруулж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна. Нөхөрлөлийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөл хөтөлбөр, сум хөгжлийн сан, дундын хуримтлалын сан зэрэг эх үүсвэрээс тоног төхөөрөмжийн болоод маркетингийн дэмжлэг үзүүлнэ.

Нөхөрлөлийн дундын сангийн хурал Нөхөрлөл нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйл, 51.4-т заагдсаны дагуу байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын байр бий болгох, нөхөрлөлийн гишүүдийн амьжиргааг дэмжих, байгалийн гамшгийн улмаас учирсан хохирлыг багасгах, нөхөрлөлийн гишүүдийн хурлаас тогтоосон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой дундын санг үүсгэнэ. Хурал нь нөхөрлөлийн БГХ-тай нэг цаг хугацаанд хийх ба ОУ-н дундын хадгаламжийн бүлэг (VSLA) аргачлалыг ашиглан зохион байгуулна. Энэ аргачлалыг Говийн малчид өөр хоорондоо хол зайтай нутагладаг учраас мэдээлэл өгөх хурал зохион байгуулахад гишүүдийн ирцийг сайжруулах арга хэрэгсэл болгон ашиглана.

Дундын хуримтлалын бүлэг аргачлал Энэ аргачлал нь CARE олон улсын байгууллагаас гаралтай бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт амжилттай ашиглаж ирсэн.

Аргачлал нь банк, санхүүгийн байгууллагын шаардлагыг хангахгүй байгаа эсвэл хүн ам төвлөрсөн орон нутгаас хол оршин суудаг бүлэг хүмүүсийн санхүүгийн үйлчилгээнд хамрагдах гол арга замуудын нэг юм. Бүлгийн хувьд хамтын үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, бичил зээлийн үйлчилгээ авах, тухайн бүс нутгийн нийгмийн үйл явцад хамтаараа оролцох, мөнгө удирдах, санхүүгийн мэдлэгээ дээшлүүлэх, хадгаламжтай болох, амьжиргаагаа нэмэгдүүлэх боломжийг олгож өгнө.

Уг аргачлалыг нөхөрлөлүүд 15-25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлсэн ба тодорхой цаг хугацааны циклээр мөнгөө нэгтгэн аюулгүй бөгөөд тохиромжтой нөхцөлд уян хатан аргаар хадгалж, мөн түүнээсээ бага хэмжээгээр нэмэлт орлого олох болон бусад яаралтай нөхцөлд гишүүд зээл авах боломжийг бүрдүүлдэг (Зураг.17).



Зураг 17. Дундын хуримтлалын бүлэг аргачлал

ОНТХГ-н менежментийг хэрэгжүүлэх санхүүжилт 2012 онд батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулиар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутгийн төсөвт төвлөрдөг болсон бөгөөд ойн нөөц ашигласны орлогын 85%, газрын нөөц ашигласны 30%, ус, рашаан ашигласны 35%, ан амьтны нөөц ашигласны 50%, байгалийн ургамлын нөөц ашигласны 15-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар заасныг орон нутагт хэрэгжүүлнэ. Мөн 2021 онд батлагдсан “Малын тоо толгойн албан татварын тухай хууль”-ийн дагуу сүм хөгжлийн сангийн журмаар санхүүжилтийг нөхөрлөлийн үйл ажиллагаанд зарцуулах боломжтой.


Нөхөрлөлийн гишүүдийн боловсролын хөтөлбөр ОНТХГ-ын менежмент хийх чадавх буй болгох зорилгоор ойн түймэр, хортноос урьдчилан сэргийлэх, бэлчээр хамгаалах, зэрлэг амьтны тооллого судалгаа хийх, СМАРТ ашиглан эргүүл хийх, гишүүн өрхийн бизнесийн үр чадварыг сайжруулах чиглэлээр сургалт, үулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.

Мэргэжлийн зөвлөл, эксперт техникийн хороод ОНТХГ-ын биологийн олон янз байдлын мониторинг, заган ойн судалгаа, бэлчээрийн төлөв байдлын судалгаа зэргийг МУИС, ХААИС, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын багаар хийлгэж тэдний зөвлөмжийн дагуу нөөцийн менежментийн үйл ажиллагаа явуулна. Мөн нөхөрлөлийн үйл ажиллагаанд аймгийн БОАЖГ, сумын ЗДТГ, сум дундын Ойн анги зэрэг орон нутгийн байгууллагуудын мэргэжилтнүүд хамтран оролцоно. Тухайлбал, ойн арчилгаа, цэвэрлэгээ, ойжуулалт зэрэг ажлыг сум дундын Ойн анги, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад Экологийн цагдаа, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжихэд сумдын ЗДТГ-н мэргэжилтнүүд идэвхтэй оролцоно.

Хүний нөөцийн болон цаг хугацааны хөрөнгө оруулалт Нөхөрлөлийн үйл ажиллагаанд оролцож буй аймгийн БОАЖГ, сумын ЗДТГ-ын ажилтнууд, сум дундын Ойн ангийн мэргэжилтнүүд нь байгууллагын ажил үүргийн дагуу оролцох бол Идэвхтэн байгаль хамгаалагч нар нь өөрийн санаачилга, сэтгэлийн дуудлагаар сайн дураараа оролцох ба нөхөрлөлийн БГХ-аар томилогдох ба сумын засаг даргатай гэрээ байгуулж ажиллана. Тэд СМАРТ эргүүлийг сард 2 удаа тогтмол хийж, хэрэг зөрчил илрүүлсэн зэрэг гүйцэтгэлд үндэслэн жилд нэг удаа урамшуулалд хамрагдана. урамшууллын зардлыг ИБХ ажиллуулах гэрээний дагуу сумын засаг дарга хариуцана. ИБХ нь нөхөрлөлийн нутагт байгаль орчны эргүүл хяналт хийх, зэрлэг амьтны ажиглалт, мониторинг хийх, байгаль орчны эсрэг хууль бус үйлдлийг мэдээлэх, таслан зогсоох, нөхөрлөлийн гишүүдэд мэдээлэл хийх, цагдаагийн болон бусад байгаль орчны талуудтай хамтран ажиллах, гишүүдийг байгаль хамгааллын ажилд татан оролцуулах дайчлах, үйл ажиллагаа санаачлан БГХ-д оруулах эрх үүрэгтэй.

Нөхөрлөлийн холбоо: Хэрэв ОНТХГ-т байгуулагдсан нөхөрлөлүүд хамтын шийдвэр гаргасан тохиолдолд ландшафтын түвшний менежмент хийх нөхөрлөлүүдийн талуудын оролцоог зангидсан институт байгуулж болох ба энэ нь нөхөрлөлүүдийн холбоо ТББ юм. Холбоо нь 2 ба түүнээс дээш нөхөрлөл, орон тооны Гүйцэтгэх захиралтай, Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн тэргүүн, болон хяналтын зөвлөлтэй, дээд удирдлага нь холбооны бүх гишүүдийн хурал гэсэн бүтэцтэй байна (*Зураг.18*).

Нөхөрлөлийн холбооны засаглалын бүтэц:



Зураг 18. Нөхөрлөлийн холбооны дотоод засаглалын бүтэц

Нөхөрлөлийн холбооны Бүх гишүүдийн хурал: Нөхөрлөлийн холбооны удирдах дээд байгууллага нь холбооны бүх гишүүдийн хурал юм. Хурал жилд нэг удаа хуралддаг ч гишүүдээс ирсэн санал болон Удирдах зөвлөл (УЗ), Хяналтын зөвлөл (ХЗ)-ийн санаачилгаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Бүх гишүүдийн хурал нь дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, холбооны урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах, хүлээн авах, УЗ-ийн гишүүдийг сонгох, сонгогдсоныг баталгаажуулах, үүрэгт ажлаас чөлөөлөх, УЗ-ын дарга буюу холбооны тэргүүнийг чөлөөлөх, дараагийн сонгогдсон тэргүүний бүрэн эрхийг батлах, Нөхөрлөлийн холбоог татан буулгах асуудлыг шийдвэрлэх эрх үүрэгтэй. Шийдвэр нь олонхын саналаар батлагдаж хурлын тэмдэглэлд орно. Хурлын тэмдэглэлийг нөхөрлөл бүрээс сонгосон УЗ-ийн гишүүн үншиж, гарын үсгээ зурж баталгаажуулна. Хурлын шийдвэрийг бүгд дагаж мөрдөнө. Хуралд Гүйцэтгэх захирал үйл ажиллагааны тайланг бүх гишүүдэд танилцуулж, хэлэлцүүлэх, Нөхөрлөлийн холбооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батална.

Нөхөрлөлийн холбооны Удирдах зөвлөл: Нөхөрлөлийн холбооны УЗ нь дарга ба нөхөрлөл бүрийг төлөөлсөн гишүүдтэй байна. УЗ-ын даргыг Бүх гишүүдийн анхны хурлаар олонхын саналаар сонгоно. УЗ нь нөхөрлөлийн холбооны үйл ажиллагааг чиглүүлэх, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаас баталсныг албажуулж батлах, гишүүн нөхөрлөлүүдээс дэвшүүлсэн холбооны түвшний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй. Удирдах зөвлөлийн хурлыг улирал бүр хийж, нарийн тэмдэглэл хөтлөх бөгөөд гишүүд үншиж танилцаад гарын үсгээ зурж баталгаажуулна. УЗ-ын даргын боломж болон цар тахлын асуудлаас УЗ-ын хурлыг тогтмол хийж хараахан чадаагүй ч чухал шийдвэрүүд гаргах шаардлагатай үед цаг алдалгүй ажиллана.

Нөхөрлөлийн холбооны Хяналтын зөвлөл: Нөхөрлөлийн холбооны ХЗ нь Бүх гишүүдийн хурал (БГХ)-аас нууц санал хураалтаар сонгогдсон гишүүдтэй байна. ХЗ-ийн дотоод хурлаас ХЗ-ийн даргаа

сонгоно. ХЗ нь холбооны үйл ажиллагаа, холбооны дүрэм болон БГХ-аас шийдвэр гаргасны дагуу явагдаж буй эсэхэд гишүүдийн өмнөөс хяналт тавина. Мөн УЗ, УЗ-ын дарга, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, шийдвэр нь гишүүдийн эрх ашигт нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах, дотоод бичиг хэргийн хөтлөлт, хөрөнгийн бүртгэл, зарцуулалт, ашиглалт, санхүүгийн байдлыг шалгах, шалгасан ажлын дүн болон зөрчлийн талаар баримтжуулж бүх гишүүдийн хуралд танилцуулах, шийдвэрлүүлэх эрх мэдэл, үүрэгтэй. ХЗ нь хуралдаж, хурлын тэмдэглэл хөтөлж гарын үсэг зуран гаргасан шийдвэрээ баталгаажуулна.

Гүйцэтгэх захирал: Нөхөрлөлийн холбооны Гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар өрсөлдүүлж сонгож, хөдөлмөрийн гэрээ байгуулна. Цаашид УЗ-өөс Гүйцэтгэх захирлын ажилд үнэлэлт дүгнэлт өгч, гэрээг сунгах, шинээр авах бол ийм өрсөлдөөнтэй байдлаар шалгаруулах нь Холбооны гишүүдийн эрх ашигт илүү нийцнэ. Шалгаруулалтад УЗ-ын гишүүд оролцож, нээлттэй санал хураалтаар Гүйцэтгэх захирлыг сонгож УЗ-ын дарга томилгоог албажуулна. Гүйцэтгэх захирал БГХ, УЗ-өөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг орон тооны албан тушаал юм. Нөхөрлөлийн холбоог чадавхжуулах зорилгын хүрээнд сумын ЗДТГ, төсөл хөтөлбөр эсвэл нөхөрлөлийн холбоо уг албан тушаалыг санхүүжүүлэх юм.

Нөхөрлөлийн холбооны гишүүн нөхөрлөл: ОНТХГ-т амьдарч буй малчид 6 нөхөрлөл болж байгуулагдан холбоонд нэгдэж гишүүн нөхөрлөл болно. ОНТХГ-ын нийт талбай ч эдгээр 6 нөхөрлөлийн нутаг бөгөөд хариуцсан нутгийн байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үүрэг хүлээнэ. Нөхөрлөл бүр 2 ИБХ-тай, тэд нөхөрлөлийн хариуцсан нутаг дэвсгэрт тогтмол эргүүл хийж, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхээс гадна биологийн олон янз байдлын, бэлчээрийн, ойн үнэлгээ мониторингийн ажилд оролцох юм.

ОНТХГ-н менежментийн төлөвлөгөө Зармангийн хоолойн ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг гол хамтрагч талууд, нутгийн иргэд, малчдын төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийн дүнд боловсруулсан байх ба менежментийн төлөвлөгөөнд Зармангийн хоолой орчмыг хамгаалалтад авах үндэслэл, нутгийн иргэдийн санал санаачилга, байгалийн нөхцөл, биологийн олон янз байдал, нийгэм эдийн засгийн байдал, хамгаалах зүйлсийн нөхцөл байдлын суурь мэдээлэл орсон байна. Тус төлөвлөгөө нь ОНТХГ-ын эрхэм зорилго, хамгааллын стратеги, хүрэх зорилтууд, үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хэрэгжүүлэх арга зам, хяналт мониторингийн хэлбэрийг тодорхойлсон гол баримт бичиг юм.

Нөхөрлөлүүдийн холбооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөний зорилго зорилтуудад нийцүүлэн боловсруулна. Гишүүн нөхөрлөл тус бүрийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж олонхын саналаар баталсан төлөвлөгөөг нэгтгэн гаргана. Төлөвлөгөөнд нөхөрлөлүүдийн гэрээгээр хариуцсан нутаг дэвсгэрт байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ерөнхий зорилгын хүрээнд байгаль орчинд тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх, SMART байгаль орчны эргүүл мониторинг тогтмол хийж хууль бус агнуур, мод бэлтгэлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нутгийн иргэдийн эв санаа, хамтаараа хөгжих, бэлчээрийн болон ойн менежментийг оновчтой хэрэгжүүлэн гишүүдийнхээ амьжиргааг нэмэгдүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг тусган хэрэгжүүлнэ.

Нөхөрлөл, нөхөрлөлийн холбоотой байгуулах менежментийн гэрээ: “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 32-р зүйлийн 2-т “Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно” гэсэн болон “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалт, 50 дугаар зүйлийн 5 дахь заалт, 47 дугаар зүйлд заасан мөн БОАЖЯ-ны сайдын 2019 оны нэгдүгээр сарын 16-ний өдрийн а/12 тоот тушаалыг үндэслэн сумын засаг дарга нь нөхөрлөлтэй **үйл ажиллагаа явуулах гэрээг** байгуулна. Нөхөрлөл нь байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэртээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлд заагдсанаар газар түүний хөрс, газрын хэвлий түүний баялаг, ус, ургамал, амьтан тэдгээрийн байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ, хуулийн хүрээнд энэхүү гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрхтэй байна. Улмаар **менежментийн төлөвлөгөөг** боловсруулан баталж нөхөрлөлийн холбоо болон нөхөрлөлүүд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ОНТХГ-ын төлөвлөгөөг хэрэгжүүлж гүйцэтгэлийг багийн болон сумын ИТХ-д тайлагнана.

ОНТХГ-ын менежментийг хэрэгжүүлэх бусад талууд, эрх үүрэг, оролцоо


Менежментийн үндсэн эрх мэдэл хариуцлага нь нутгийн иргэдийн эв нэгдлийн байгууллагад төвлөрөх ч бусад талуудтай хамтран шийдвэр гаргах үүрэг хүлээсэн, тэрхүү хамтын шийдвэрийг албажуулж батлах хэлбэрээр ОНТХГ-ын засаглалыг бэхжүүлнэ. Иймээс хэрэгжүүлэгч байгууллага нь ОНТХГ-ын хил хязгаар дотор оршин суудаг нутгийн иргэдийн эв санаа, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зорилгын төлөө нэгдсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд болон тэдгээрийн нэгдэн байгуулсан иргэний нийгмийн байгууллага байна. Менежментийг гол хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц нь төрийн байгууллага, нутгийн иргэдийн нэгдэн байгуулсан иргэний нийгмийн байгууллага байх ба Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр нь менежментийг дэмжин чиглүүлэх оролцоотой байна (Зураг.19).

Менежментийг хэрэгжүүлэгч талууд:



Зураг 19. Менежментийг хэрэгжүүлэгч талууд

ТХГН-ийн засаглалын хэлбэрийг тодорхойлсны дагуу **хамтын засаглалын хэлбэртэй** байна. ОНТХГ-ын засаглалд **оролцогч талууд** нь аймгийн ИТХ, Байгаль орчин аялал жуулчлалын газар (БОАЖГ), ойн анги, сумын ИТХ, Засаг дарга, Цагдаагийн газар, Экологийн цагдаа гэсэн төрийн байгууллагууд, харин төрийн бус оролцогч талууд нь ОНТХГ-ын нөхөрлөлүүд, тэдгээрийг нэгтгэсэн Нөхөрлөлийн холбоо, аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоо, ОУБ, ИНБ-ын төсөл хөтөлбөр болно. Эдгээрээс сумын ИТХ, Засаг дарга, нутгийн иргэдийн нөхөрлөл, нөхөрлөлийн холбоо нь засаглалын үйл явцад давуу эрхтэй тал (Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 48-р зүйл) бол бусад байгууллагууд нь оролцогч тал юм. Эдгээр талуудын ОНТХГ-ын менежментийн эрх үүрэг хариуцлага дараах байдлаар хуваарилагдана.



Зураг 20

ГИДЦГ-ын “А” хэсгийн Орчны бүсийн хамтын менежментийн зөвлөл (ОБХМЗ): Одоогоор ландшафтын нэгдсэн менежментийг ГИДЦГ-ын “А” хэсгийн орчны бүсэд байрладаг Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр, Говь-Алтай аймгийн Цогт, Эрдэнэ, Алтай сумдын Орчны бүсийн зөвлөл/ИТХ, ЗДТГ-ын тодорхой чиг үүрэг бүхий албан тушаалтнууд, ГИДЦГ-ын Хамгааллын захиргаа, тэнд үйл ажиллагаа явуулж буй зарим төсөл хөтөлбөрийн төлөөлөл оролцсон Хамтын менежментийн зөвлөл ажиллаж хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа нь

явагдаж байна. Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн төлөөлөл энэхүү ХМЗ-д элсэн орж тэдний төлөвлөгөөтэй үйл ажиллагаагаа шууд уялдуулан ажиллана.

ОБХМЗ нь ОБ-ийн менежментийн хүрээнд оролцогч талуудын хооронд зохицуулах үйл ажиллагааны урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийх, гадаад, дотоодын төслүүдийн үйл ажиллагааг зангидах, ажлын уялдаа холбоог сайжруулж, хийх ажлын давхцалгүй байх явдлыг хангах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжих, сүм дамжсан хулгайн ан хийх, байгалийн бусад нөөцийг хууль бусаар болон зохисгүй ашиглах асуудлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг хамтран зохион явуулах, ОБ-эд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн хор хөнөөлийг бууруулах, дахин гаргуулахгүй байх, байгалийн унаган төрхийг нөхөн сэргээлгэх асуудалд онцгой анхаарч, хамтын хяналт тавих, нутаг дэвсгэрт ан амьтныг нутагшуулан өсгөн үржүүлэх, байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах асуудлаар сүм, баг, нөхөрлөл, эко клубийн түвшинд гарч байгаа тэргүүн туршлагыг харилцан судлуулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахад гол хамтрагчаар оролцоно.

5 сүмдын орчны бүсийн зөвлөл: ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг уялдуулах, малчдын амьжиргааг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг төрөлжүүлэх үйл ажиллагааг түүштай дэмжин, бизнес төсөл боловсруулах, санхүүжилт авах, хэрэгжүүлэхэд туслах, сумын ИТХ-д нөхөрлөлийн үйл ажиллагааг танилцуулах, нөхөрлөлийн холбоо, түүхий эдийн болон маркетингийн хоршоо байгуулах зэрэг нэгдмэл шинж чанартай арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, шаардлагатай зөвлөмжөөр хангана.

ГИДЦГ А хэсгийн хамгаалалтын захиргаа: Зэрлэг амьдын судалгаа мониторингийн ажлыг хамтран зохион байгуулах, байгаль хамгаалагч, нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагч нарыг ажлын чиг үүрэгт мэргэжлийн зөвлөмжөөр хангах, СМАРТ системийн эргүүл хяналтын чиглэл, байнгын болон цаг хугацаат эргүүл хяналтын төлөвлөгөө, хэрэгжилт, тайланг хянах, зөрчлийн болон гэмт хэргийн шинж чанартай мэдээллийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, хэрэг шийдвэрлэлтэд хяналт тавих, хуулийн дагуу урамшуулал олгоход хяналт тавина. Тухайн орчинд өвөлжих болон бэлчээр ашиглаж байгаа малчдтай байнга харилцаатай байж байгаль орчны багц хууль, тусгай хамгаалалттай нутгийн тухай хууль, холбогдох дүрэм журмыг сурталчлах, зөвөлгөө мэдээллээр хангах, гарын авлага, материалаар хангах, малчдын нөхөрлөлийн уулзалт хурлын зарыг тараах, нэгдсэн хурал, уулзалт, цуглаан, сургалт зохион байгуулах шаардлагатай тохиолдолд сургалтын танхим, өглөө, өдөр, оройн хоол, техник зэрэгсэлээр хангах ажлыг хамтран зохион байгуулах үүрэгтэй оролцоно. Мөн малчдын нөхөрлөлийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явцад хамтын шийдвэр гаргах, хянах, тоон болон чанарын мэдээ, мэдээллээр хангах, хязгаарлалтын бүсэд мал өвөлжүүлэх гэрээг малчидтай байгуулах, цаг хүндэрсэн тохиолдолд хуулийн дагуу яаралтай арга хэмжээ авах ажилд хамтран оролцоно. ОНТХГ-ын хилийн цэсийг “Ашиг малтмал, газрын тосны газар” бүртгүүлэх, нөхөрлөлийн хариуцан хамгаалах газар нутгийн хилийн цэсийг тогтоох, харицан тохиролцох үйл ажиллагаанд хамтран оролцоно.

Сүмдын Эко-клубууд: Малчдын нөхөрлөлийн гишүүд, орон нутгийн иргэдэд байгаль орчинд тулгамдаж буй асуудлыг ойлгуулах, суурь мэдлэгийг олгох зорилгоор “Хүүхдээс хүүхдэд” “Хүүхдээс насанд хүрэгчидэд” сургалт нөлөөллийг ажлыг зохион байгуулна.

Аймгийн БОАЖГ нь байгаль орчныг хамгаалах, тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ чиглэлийн төрийн бодлого хөтөлбөрийг аймагтаа хэрэгжүүлэх, ОНТХГ-ын менежментийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үүрэг хариуцлагын хүрээнд нөхөрлөлүүд болон хамтрагч талуудтай нягт хамтран ажиллаж менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлагын, хүний нөөцийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

Сумын ИТХ нь ОНТХ-т авах шийдвэр гаргаж нөхөрлөлд хуулийн дагуу тодорхой хугацаагаар гэрээгээр эзэмшүүлнэ. ОНХГ-н менежментийг хэрэгжүүлэх төсвийг дараа жилийн орон нутгийн төсөвт суулган баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Жишээлбэл: байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18-р зүйлийн 1 дэх хэсэгт *“байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг түүний дотор ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 85% байх”*-аар тогтоосон байдаг. Нөгөө талаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хууль заагдсан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг сайжруулах, ИБХ-ыг урамшуулах арга хэмжээнд зарцуулах шаардлагатай. нөхөрлөлийн болон холбооны тайланг сонсох, ас

Сумдын Засаг даргын Тамгын газар нь төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сумандаа хангуулах, нөхөрлөлүүдтэй гэрээ хийх, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, ОНТХГ-н менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах, хэрэгжилтийг хангуулах үүргийн дагуу сумын ИТХ-ийн шийдвэрийг үндэслэн нөхөрлөлүүдтэй ОНТХГ-ын менежментийн гэрээ байгуулан ажиллана. Сумын байгаль хамгаалагч, бэлчээрийн мэргэжилтэн, газрын даамал нь нөхөрлөлүүдийн чадавхжуулах сургалтад оролцож, зөвлөмж өгч ажиллана.

Ойн анги нь ойн менежмент хийхэд чадавхжуулах, ойжуулах, хүлээж авах, нөхөрлөлд мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх үүргийн дагуу жил бүр ОНТХГ-ын нөхөрлөлүүдэд ойн хортон шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх сургалт хийж, ойжуулалт, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж нягт хамтран ажиллана.

Аймгийн Цагдаагийн газар нь иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл олгох, байгаль орчны эсрэг зөрчлийг газар дээр нь шалгах, иргэдийн гомдол мэдээллийг хүлээн авах, шалгах шийдвэрлэх, мөн мэдээлэл өгсөн иргэний урамшууллыг олгох, ОНТХГ-ын ИБХ-дад хууль эрх зүйн мэдлэг олгож нягт хамтран ажиллана.

ОУБ, ИНБ-ын төсөл, хөтөлбөр нь төсөл хөтөлбөр санаачлах, төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, донорт тайлагнах ажлыг гүйцэтгэх, ОНТХГ-ын талуудыг үндэсний болон олон улсын мэргэжилтэн эрдэмтэдтэй холбож шинжлэх ухаан судалгаанд үндэслэсэн хамгааллын үйл ажиллагаа явуулахад гол үүрэг гүйцэтгэж засаглалын бүхий л зарчмыг хэрэгжүүлэхийг эрмэлзэн ажиллана.

Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо: Малчдад бэлчээрийн талаарх ойлголт мэдлэг олгох, Хөрс ургамал, бэлчээрийн суурь судалгаа, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, тухайн

жилийн бэлчээрийн төлөв байдлын судалгаанд үндэслэн малчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, бэлчээр хариуцлагажуулах журам боловсруулан сумдын ИТХ-аар батлуулах, хадлангийн талбай хаших, ногоон тэжээл тариалах талаар сургалт арга хэмжээг зохион байгуулна.

Дундын хуримтлалын бүлэг аргачлалын чиглүүлэгч багш: Дундын хуримтлалын бүлэг аргачлалын 7 модуль цуврал сургалт, үүлзалтыг зохион байгуулна. чиглүүлэгч багш нь албан ёсны багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

Байгаль орчны эргүүл хяналтын SMART системийн зөвлөх SMART системийн 7.5.4 хувилбар дээр ажиллах ба SMART connection -г хэрэгжүүлнэ. (Зураг.21)



Зураг 21.Хамтын ажиллагааны схем зураг

ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөний санхүүжилт, тогтвортой байдал

Монгол Улсад ОНТХГ-ын менежментийг нутгийн төрийн захиргааны байгууллагууд БХОУХ-ны стандарт шаардлагын дагуу гүйцэтгэх чадвар хараахан бүрэлдээгүй байгаа шалтгаанаар тус улсад гадаадын хандивлагчдын төслөөр ихэвчлэн менежментийг хийх, загвар бий болгох ажлууд хийсэн байдаг. Анх НҮБХХ-өөс 2013-2018 онд хэрэгжүүлсэн “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн дэмжлэгтэй Дорнод аймгийн Түмэнхаан-Шалз ОНТХГ (Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-уул, Хэнтий аймгийн Норовлин сумдын 374,499 га), Хэнтий аймгийн Хавтгар ОНТХГ (Батширээт сумын 104,900 га), Увс аймгийн Гүлзат ОНТХГ (Сагил, Бөхмөрөн сумдын 203,316 га)-ыг байгуулсан байна. Мөн Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН)-ээс Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНВУ)-ын Засгийн газрын “Дарвины санаачилга” сангийн санхүүжилтээр “Ойт хээрийн экосистем болон ховордож буй зүйлүүдийг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах нь” төслөөр 2018-2021 онд Архангай аймгийн Булган сумын Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын менежментийн загварыг буй болгосон бөгөөд одоог хүртэл хамгааллын үйл ажиллагааг амжилттай явуулж байна.

Их говийн бүс нутагт ч ОНТХГ-ыг ажиллуулсан өмнөх туршлага байхгүй тул Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд энэ чиглэлээр ажилласан туршлагатай байгууллагын туслалцаа хэрэгтэй. Иймд тус төлөвлөгөөнд тийм эксперт байгууллагын зардлыг менежментийн болон зөвлөхийн зардлын хэлбэрээр тусгасан буй.

Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөө нь 4 жилийн хугацаанд нийт **685 сая төгрөгийн өртөгтэй** болох бөгөөд зардлыг зорилт бүрээр, жилээр дараах Хүснэгт 14-ээс харж болно.

Хүснэгт 14. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийн төсөөлөл үйл ажиллагаа/жилээр

Зорилт	Үйл ажиллагаа	Төсвийн төсөөлөл (сая.төг/жил)				Шаардлагатай төсвийн төсөөлөл (сая. төг)
		2023	2024	2025	2026	
Зорилт 1. Хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг тогтмол мониторинг хийх загвар бий болгох, чадавхитай болох	1.1.Зармангийн цөлийн хээрийн бэлчээрийн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх: ургамлын ургац, зүйл, бүрхэц, хөрсний түргэвчилсэн судалгаа	6.27	0.00	0.00	6.72	12.99
	1.2 Зармангийн хоолойн заган ойн суурь болон өөрчлөлтийн судалгаа хийх, нөхөн сэргээх газрыг тодорхойлох	0.00	0.00	0.00	6.71	6.71
	1.3 Зармангийн баянбүрд, бусад усны эх үүсвэрийн цогц судалгаа хийх, боломжит уст цэгийг тодорхойлох	6.27	0.00	0.00	6.72	12.99
	1.4 Хар сүүлтий, бусад хөхтний камерын мониторинг хийх	5.27	5.42	5.53	5.63	21.85
	1.5 Зармангийн малчдын нийгэм-эдийн засаг, хандлагын судалгаа хийх	-	-	-	6.42	6.42
Зорилт 2. ОНТХГ-ын менежментийг хийх байгууллагыг чадавхжуулж, түншлэл хамтын ажиллагааны суурийг тавих	2.1 Зармангийн хоолойд нутагладаг малчдын дунд оролцооны аргаар хэлэлцүүлэг хийж малчдын байгууллага үүсгэн байгуулах	9.49	0.00	-	-	9.49
	2.2 Малчдын байгууллагын засаглалын суурийг тавьж чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, дундын сан, хурлууд)	9.81	10.11	-	-	19.92
	2.3 Малчдын байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих (сургалт, байгаль хамгаалал, амьжиргаа)	-	20.69	23.72	-	44.41
	2.4 Зармангийн ОНТХГ-ын менежмент хийх дээвэр байгууллагыг үүсгэн байгуулах, чадавхжуулах (дүрэм, төлөвлөгөө, түншлэл, тайлан)	-	-	8.86	9.03	17.89

	2.5 Зармангийн ОНТХГ-ын менежментийн тогтвортой байдлыг хангах, санхүүжилт татах, түншлэл, бизнесийг өргөжүүлэх	-	-	10.47	10.51	20.98
ЗОРИЛТ 3: Зармангийн цөлийн хээрийн экосистемийг цогцоор (бэлчээр, баянбүрд,заг, зэрлэг амьтан) нь хамгаалж суурь түвшнээс доройтуулахгүй түвшинд байлгах	3.1. Бэлчээрийн судалгаанд үндэслэн бэлчээр сайжруулах багц арга хэмжээ хэрэгжүүлэх (сургалт, бэлчээр ашиглах гэрээ хийх, зарим газрыг хаших, дарш бэлтгэх, бэлчээр чөлөөлөх, мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих)	5.45	5.61	5.72	5.83	22.61
	3.2 Усны судалгаанд үндэслэж хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэх (баянбүрд цэвэрлэх, эх хаших, хамгааллын бүс тогтоох, хөв байгуулах)	5.00	-	58.00	-	63.00
	3.3 Заг хамгаалах (сургалт, хаших, үрээр тарих, түлшний өөр эх үүсвэр хайх)	5.45	7.71	0.75	0.75	14.66
	3.4 Идэвхитэн байгаль хамгаалагчдыг сургах, эргүүл мониторинг хийх	20.70	17.51	17.91	18.25	74.37
ЗОРИЛТ 4: Зармангийн нүүдэлч малчдын амьдралын сайн сайхныг суурь үзүүлэлтээс сайжруулж, өв уламжлалыг сэргээх, хөгжүүлэх	4.1 Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагын цуврал сургалт	16.82	16.40	16.72	17.04	66.98
	4.2 Бэлчээрийн менежментийн сургалт					
	4.3 Байгаль, заг, зэрлэг амьтны сургалт					
	4.4 Өрхийн эдийн засаг, санхүүгийн сургалт	21.94	16.71	17.66	18.00	74.31
	4.5 Нүүдэлчдийн өв уламжлалыг сэргээх үйл ажиллагаа явуулах	3.57	4.05	6.76	6.88	21.26
Бусад зардал	Удирдлага, менежментийн зардал	41.13	41.13	41.13	35.23	158.62
	Тоног төхөөрөмж, худалдан авалт болон бусад зардал	10.60	1.62	1.63	1.63	15.48
	ЗОРИЛТЫН НИЙТ ДҮН	167.76	147.00	214.86	155.38	685.00

Эдгээрээс үзэхэд нийт зардлын **50.8%** хувь буюу **348.35 сая** төгрөг нь үнэт зүйлсийн хамгааллын үйл ажиллагаа болон говийн малчдыг хөгжүүлэх тэдний амьжиргааг дэмжихэд зориулагдана. Мөн эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотой экологийн болоод

нийгмийн өөрчлөлт мониторинг хийх учир нийт зардлын **165.21 сая төгрөг** орчим нь зөвлөхийн болон менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулагдана.

Эхний хоёр жилд үнэт зүйлсийн суурь судалгаанууд болон ОНТХГ-ын менежмент хийх институцийг байгуулах, чадавхжуулах ажил хийгдэх тул энэ чиглэлийн зардлууд дийлэнх буюу **73.33 сая** төгрөг байхаар төлөвлөлөө. Харин малчдын байгууллага чадавхжиж гишүүн нөхөрлөлүүд, идэвхитэн байгаль хамгаалагчид сургалтаа авч дууссаны дараа эргүүл хийх, байгаль хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлууд эрчтэй явагдах тул 3 дах жилд хамгийн өндөр зардал буюу **214.85 сая** төгрөгийг зарцуулна. Сүүлийн дөрөв дэх жилд менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр үнэт зүйлд ямар өөрчлөлт гарсныг хэмжих тул холбогдох судалгаанууд хийгдэж үр дүнг тооцох, үүнд үндэслээд байгаль хамгааллын төслийн санал боловсруулах, санхүүжилт татах ажлууд шат дараатайгаар хийнэ.

Зармангийн хоолой ОНТХГ-ын менежментийн төлөвлөгөөг санхүүжүүлэх эх үүсвэр нь Эрдэнэ сумын ЗДТГ-ын байгалийн нөөцийг ашигласны албан татвар (БНАТ)-аас орсон орлого, Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн төсөв, Малын тоо толгойн албан татвар (МТТАТ)-ын орлого болон байгаль хамгааллын төсөл хөтөлбөрөөс санхүүжих боломжтой.

Энэхүү 4 жилийн менежементийн төлөвлөгөөний зорилго нь ОНТХГ-ын менежментийн үндэс суурийг тавих тул байгууллагыг чадавхижуулах, сурах боловсрох чиглэлд менежментийн төлөвлөгөөний дийлэнх зардлыг тусгав. Эхний ээлжинд хамгааллын ажилд эхлэл тавих, малчид, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хамтын үйл ажиллагаа явуулж сурах, үр дүнг хянаж, дүгнэж сурах, түүнээсээ урамших явдал чухал.

ОНТХГ-ын менежментийг хамгаалалтад авсан сүм өөрөө холбогдох зардлаа хариуцах хуультай тул энэхүү эхний төлөвлөгөөний санхүүжилтийн **гуравны нэг** буюу **228.33 сая төгрөгийг** нь орон нутгаас гарч байхаар төсвийг тооцоолсон бөгөөд дээр дурдсан эх үүсвэрүүдээс санхүүжүүлэх боломжтой. Мөн санхүүжилтийн хугацааны хувьд алгуур нэмэгдэхээр тооцсон учир дараа жилийн төсөвт тусгаад явах нь зүйтэй.

Зармангийн ОНТХГ-ын менежментийн **тогтвортой** байдлыг хангахад дараах хүчин зүйлс нөлөөлнө.

- ОНТХГ-ын менежмент хийх талууд хангалттай сайн чадавхтай болсон эсэх. Үүнд малчдын нөхөрлөлүүд, тэдгээрийн дээвэр байгууллага, идэвхтэн байгаль хамгаалагчид, тэдгээрийг дэмжиж ажиллах сумын мэргэжилтнүүд, удирдлагууд, ГИДЦГ-ын ХМЗ болон Хамгааллын захиргаа орно.
- ОНТХГ орчим байгалийн гамшигт үзэгдэл бага, уур амьсгал, цаг агаарын тааламжтай нөхцөл байх эсэх. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж үнэт зүйлсээ хамгаалахад хүнээс шалтгаалахгүй эдгээр хүчин зүйлүүд тохиолдож болзошгүй тул хүрэх үр дүнг уян хатан гаргаж, хугацааны хувьд хойшлуулах боломжтой байхаар төлөвлөлөө.
- Цаашид ОНТХГ-ын менежментийг санхүүжүүлэхэд аялал жуулчлал, эко үйлдвэрлэл зэрэг орлого буй болгох үйл ажиллагаа чухал бөгөөд эдгээрийг СВОН дүн шинжилгээ, боломжийн судалгаа зэрэг арга хэрэгслээр тодорхойлно. Иймд нөхөрлөлүүд үүсгэн байгуулагдсаны дараа эдгээр судалгааг хийхээр төлөвлөсөн болно.

- Аливаа ОНТХГ-ын менежмент нь нутгийн иргэдэд түшиглэсэн байдлаар явагддаг бөгөөд менежмент хийх гол субъект болох малчид нь МАА-н үйлдвэрлэл явуулдаг, цаг зав багатай хүмүүс учир менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагаанууд малчдын жил, улирлын ачаалалд тохирсон, аажуу хэмнэлээр явагдана. Хэт их олон ажил төлөвлөж, шахалт дарамт үзүүлэхгүй, харин ч малчдын нутгаа хайрлах хайр, уул овоогоо шүтэх бишрэх сүсгийг хөхүүлэн дэмжиж зөв хэмнэл аргаар ажиллах нь тогтвортой байдалд ихээхэн нөлөөтэй.
- Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын амжилт, урт удаан үргэлжлэх эсэх нь ОНТХГ-ын менежментийг явуулах засаглал хэр зэрэг зөв зохистой тавигдаж ил тод байдал, эрх тэгш байдал, шударга ёс хэрхэн тогтохоос ихээхэн хамаарна. Иймд эхнээсээ нөхөрлөлийн болоод дээвэр байгууллагын бүтэц, засаглалын үйл явцыг зохистой байдлаар хэвшүүлэхийн тулд хөндлөнгийн эксперт байгууллагын туслалцаа, сургалтыг төлөвлөсөн болно. Сүүлийн хоёр жилд дээвэр байгууллагын удирдлагууд суралцаад чадавхжих үед менежментэд илүү үүрэг рольтой ажлаа хариуцаж явах юм.

Эрдэнэ сумын алслагдмал байдлаас хамааран аялал жуулчлал хөгжүүлэх магадлал ойрын жилдээ хязгаарлагдмал, мөн эхний дөрвөн жилийн төлөвлөгөөний хугацаанд сумаас менежментийг бүрэн санхүүжүүлэх боломж хараахан бүрдэхгүй, нөгөө талаасаа ОНТХГ-ын цаашдын хөгжлийн шаардлагыг харгалзан 2027 оноос эхлэх төлөвлөгөөнд ч төсөл боловсруулж санхүүжилт татах шаардлагатай гэж үзэж байна. Иймээс Зармангийн хоолойн менежментийн гэрээг зарлахдаа дараагийн төслийг боловсруулах ажлыг Ажлын даалгаварт багтаах нь чухал. Олон улсын практик туршлагаас үзэхэд аливаа ТХГН-т экологи ба нийгмийн үр дүнд хүрэхэд дундажаар 10 жил зарцуулсан байдаг.


АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Авирмэд А., 1995. Говийн Их Дархан газрын экосистемийн төлөв байдал, хувьсал өөрчлөлт. Говийн Их Дархан Цаазат газрын байгалийн нөхцөл биологийн нөөц баялаг. УБ.4-9
2. Адьяа Я, Рийдинг Р Хавтгай тэмээний сүүлийн үеийн судалгааны тойм, 2004 Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм, Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ
3. Адьяа Я. 2012, Хавтгай тэмээний нөөцийг тогтоосон судалгааны ажлын тайлан.
4. Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм. 2004, Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ
5. Алтанцэцэг. Ж. 1995. Говийн Их Дархан Цаазат газрын уур амьсгалын зарим онцлог. Говийн Их Дархан Цаазат газрын байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг. УБ. 9-12
6. Биологийн төрөл зүйлийн тухай конвенцыг хэрэгжүүлэх үндэсний 2 дахь тайлан. УБ, 2002
7. Батсайхан Н, Лхагвасүрэн Д, Самьяа Р. Их говийн дархан цаазат газрын жижиг хөхтөн амьтад. 2004. Алтайн өвөр говийн шувууны судалгаанд. Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ
8. Болд А., Цэвээнмядаг Н., 2001. CITES-ийн зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн лавлах. CITES-ийг хэрэгжүүлэх Монголын үндэсний зөвлөл. Улаанбаатар.
9. “Говийн их дархан цаазат газрын байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг”. э/ш бага хурлын илтгэлийн хураангуй. 1995.VI.12. Улаанбаатар.123
10. ГИДЦГ-ын жилийн ажлын тайлан 2005-2013
11. Даш.Д. Физик газарзүйн мужлалын шинэчилсэн хувилбар. Монгол орны ландшафт-экологийн зарим асуудлууд. УБ.,2000. х. 84-96
12. Довчиндорж Г. Говийн дархан цаазат газар 2006
13. Дуламцэрэн С. 2004. Говийн их дархан цаазат газрын «А» хэсгийн хөхтөн амьтны зүйлийн бүрэлдэхүүн, тархацын судалгааны тойм. Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм. 2004, Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ
14. Золжаргал. П, 2013, Говийн Их Дархан цаазат газрын герпетологийн хээрийн судалгааны тайлан
15. Жирнов Л.В., Ильинский В.О. 1985, Большой Гобийский заповедник-убежище редких животных пустынь Центральной Азии. М.,
16. Жон Хейр. Говийн хаан Хавтгай тэмээний тухай өгүүлэх нь Улаанбаатар. 2002. 27х. (Б.Лхагвасүрэнгийн орчуулга)
17. Монгол орны физик газарзүй. Ред. Ш.Цэгмид. УБ., 1969
18. Монгол Улсын Улаанном, УБ., 1987, 1997, 2013
19. Монгол орны улаан данс
20. Монгол улсын биологийн баялаг. Үндэсний тайлан. УБ, 1998
21. Мөнх баяр Х, Тэрбиш Х, Мөнхбаатар М. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийг тодорхойлох бичиг. УБ.,2001
22. Мижиддорж Б. 2013, Говийн баавгай мазаалай
23. Оюунгэрэл Б., Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг. 2004


24. Одбаяр т. нар., 2014, Мазаалай баавгайг генетикийн аргаар тоолсон судалгааны ажлын тайлан
25. Орчны бүсийн сүмдын нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд 2013
26. Самьяа Р. Ховор амьтан хамгаалах онол практикийн зарим асуудалд, 2004. Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ
27. Тулгат.Р. 1995. Хавтгайн үржлийн биологи, ороо нийллэг, төллөлтийн үеийн физиологи, зан төрхийн онцлог. Говийн Их Дархан Цаазат газрын байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг. УБ. 96-102
28. Их говь төслийн тайлан 2006
29. Цогтбаатар.Ж, нар. Монгол орны заган ойн үнэлгээний тайлан, 2015
30. Монгол орны заган ой, Тархалт, нөөц, экологи-эдийн засгийн үнэ цэнэ, 2017
31. Хилти, Ж. *, Уорбойс, Г.Л., Кили, А. *, Вудли, С. *, Лауш, Б., Локк, Х., Карр, М., Пулсфорд И., Питток, Ж., Вайт, Ж.В., Теобалд, Д.М.Левин, Ж., Рулинг, М., Ватсон, Ж.Э.М., Амент, Р., болон Табор, Г.М.* (2022). Экологийн сүлжээ ба коридор нутгуудаар дамжуулан холбоосуудыг хадгалж үлдэх удирдамж. ТХГН-үүдын шилдэг түршлэгүүд, Цуврал Дугаар № 30, IUCN, Гланд, Швейцарь. *Холбогдох зохиогчид: Хилти (jodi@y2y.net), Кили (annika.keeley@yahoo.com), Вудли (woodleysj@gmail.com), Табор (gary@largelandscapes.org)
32. У.Тунгалаг, Г.Эрдэнэцолмон, Ш.Мягмарсүрэн, Ц.Мөнхзул, Н.Мөнхтүвшин (2021) Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн загвар: Хойд Могойн гол – Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын жишээн дээр. Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дах Төлөөлөгчийн газар, Улаанбаатар, Монгол Улс
33. UNEP-WCMC, I. a. N. (2021). Protected Planet Live Report 2021. from UNEP-WCMC, IUCN and NGS Available at: www.protectedplanet.net
34. Dudley, N. (2008). Guidelines for Applying Protected Area Management Categories. In S. Stolton, P. Shadie & N. Dudley (Eds.), (2013) IUCN WCPA Best Practice Guidance on Recognising Protected Areas and Assigning Management Categories and Governance Types (Best Practice Protected Area Guidelines Series No. 21 ed., pp. x + 86). Gland, Switzerland: IUCN.
35. Borrini-Feyerabend, G., et al. (2013). Governance of Protected Areas: From understanding to action (Vol. Best Practice Protected Area Guidelines Series No. 20). Gland, Switzerland: IUCN

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын тогтоол



Хавсралт 2. Ашигт малтмал, газрын тосны газрын албан бичиг


МОНГОЛ УУСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70
И-мэйл: info@mram.gov.mn


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.НЯМДАВАА ТАНАА

2020.02.04 № 8/635
танай 2020.01.25-ны № 01/45 -Т

Р.Аюул
Баттөлөгт Агвант,
685 мрб
ОИХ - хамгаалсан газар
түр орлон гүйцэтгэгч
Нэгдсэн
шилжээг үү.
2020.07.14

Танай сумын ИТХ-ын 2020 оны 1 дүгээр сарын 25-ний өдрийн Зарим газар нутгийг сумын тусгай тусгай хамгаалалтанд авах тухай 14 дугаар тогтоолоор батласан "Зармангийн хоолой" нэртэй 118472.62 гектар талбай, "Хараат хайрхан" нэртэй 6787.16 гектар талбай, "Цагаан уул хайрхан" нэртэй 663.94 гектар талбай, мөн өдрийн 15 дугаар тогтоолоор батласан "Долооны хоолой" нэртэй 114566.73 гектар талбай, "Цагаан дэрс" нэртэй 42790.88 гектар талбай, "Ширт булаг жонш" нэртэй 13610.52 гектар талбайг тогтоолын хавсралтад заагдсан солбицлын дагуу Кадастрын бүртгэлийн системд бүртгэж авсныг мэдэгдье.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Одончимэг* Д ОДОНЧИМЭГ



537099273

